

**ЕВРОПЫН СЭРГЭН БОСГОЛТ ХӨГЖЛИЙН БАНКНЫ
БАРИМТ БИЧИГ**

**МОНГОЛ ОРНЫ ХУВЬД БАРИМТЛАХ
СТРАТЕГИ**

**2009 оны 10-р сарын 21-ий өдрийн Захирлуудын зөвлөлийн хурлаас баталсан
байдлаар**

АГУУЛГА

I.	ТОВЧ ХУРААНГУЙ	2
II.	МОНГОЛ ОРНЫ ХУВЬД БАРИМТЛАХ СТРАТЕГИ	9
1.	Банкны санхүүжилтын багц	9
1.1	Өнөөг хүртэлх хугацаанд явуулсан үйл ажиллагааны тойм	9
1.2	Өмнөх Стратегийн хэрэгжилт	10
1.3	Шилжилтийн нөлөө ба хуримтлуулсан туршлага	12
1.3.1	Шилжилтийн үйл явцад нөлөөлөх нь	12
1.3.2	Төслүүдийг санхүүжүүлсэн байдал	14
1.3.3	Хамтарсан санхүүжилтийг дайчлах	15
1.3.4	Хуримтлуулсан туршлага, сургамжууд	15
1.4	Хэрэгжүүлсэн төслүүдийн харьцаа	16
2.	Үйл ажиллагааны орчин	17
2.1	Өөрчлөлт шинэчлэлийн ерөнхий орчин	17
2.1.1	Улс төрийн орчинд гарсан өөрчлөлтүүд	17
2.1.2	Хууль эрх зүйн шинэчлэл	17
2.1.3	Бизнесийн орчин	18
2.1.4	Байгаль орчны асуудлууд	19
2.1.5	Нийгмийн асуудлууд	20
2.1.6	Ажиллах хүчний асуудлууд	22
2.1.7	Хүйсийн асуудлууд	22
2.2	Шилжилтийн үеийн эдийн засгийн хөгжил ба ололт амжилт	23
2.2.1	Банкны үйл ажиллагааны макро эдийн засгийн нөхцөл байдал	23
2.2.2	Шилжилтийн үеийн ололт амжилт ба шийдвэрлэгдээгүй асуудлууд	25
2.2.2.1	Шилжилтийн үеийн ололт амжилт	25
2.2.2.2	Шилжилтийн үеийн сорилтууд	30
2.3	Хөрөнгө санхүүгийн хүртээмж	31
3.	СТРАТЕГИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛ	33
3.1	Банкны тэргүүлэх чиглэл	33
3.2	Салбарын шийдвэрлэвэл зохих асуудлууд ба Банкны үйл ажиллагааны зорилго	36
3.2.1	Аж ахуйн нэгж, хувийн хэвшил	36
3.2.2	Санхүүгийн байгууллагууд	37
3.2.3	Байгалийн нөөцийн салбар	39
3.2.4	Дэд бүтэц	40
3.2.4.1	Тээвэр	41
3.2.4.2	Эрчим хүч	43
3.2.4.3	Нийтийн аж ахуй ба байгаль орчин	44
3.2.4.4	Харилцаа холбоо	45
3.2.5	Эрчим хүчний үр ашиг	45
3.2.6	Банкны стратегийн байгаль орчны болон нийгмийн нөлөө	47
4.	Олон Улсын Санхүүгийн Байгууллагууд болон Олон талт хандивлагч байгууллагууд	47
4.1	Олон Улсын Валютын Сан (ОУВС)	47
4.2	Дэлхийн Банкны Бүлэг	48
4.3	Азийн Хөгжлийн Банк (АХБ)	49
4.4	НҮБ-ийн Хөгжлийн Хөтөлбөр (НҮБХХ)	49
4.5	Европын Холбоо	50
ХАВСРАЛТ 1	УЛС ТӨРИЙН НӨХЦӨЛ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ	
ХАВСРАЛТ 2	ЭДИЙН ЗАСГИЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТҮҮД	
ХАВСРАЛТ 3	БАЙГАЛЬ ОРЧНЫ ҮНДСЭН АСУУДЛУУД	
ХАВСРАЛТ 4	ХУУЛЬ ЗҮЙН ШИЛЖИЛТ	
ХАВСРАЛТ 5	ЕСБХБ-НААС БАТЛАГДСАН ҮЙЛ АЖИЛЛАГАА	
ХАВСРАЛТ 6	ЦААШИД ХЭРЭГЖИХ ТӨСЛҮҮД	
ХАВСРАЛТ 7	ТЕХНИКИЙН ХАМТЫН АЖИЛЛАГАА	
ХАВСРАЛТ 8	ТЕХНИКИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ТӨСЛҮҮД	
ХАВСРАЛТ 9	УДИРДЛАГЫГ ҮНДСЭЭР НЬ ӨӨРЧЛӨХ/БИЗНЕСИЙН ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР	
ХАВСРАЛТ 10	ХОЁР ТАЛТ ТУСЛАЛЦАА	
ХАВСРАЛТ 11	ШИЛЖИЛТИЙН ҮЕИЙН СОРИЛТЫН ҮНЭЛГЭЭ	
ХАВСРАЛТ 12	МОНГОЛ УЛСЫН ГАЗРЫН ЗУРАГ	

I. ТОВЧ ХУРААНГУЙ

Монгол Улс нь олон намын тогтолцоо, олон үзэлт нийгэмтэй орон бөгөөд Банкныг Үүсгэн Байгуулах тухай Гэрээний Зүйл 1-д заасны дагуу зах зээлийн эдийн засагт шилжих явцад нааштай ахиц гаргаж байгаа билээ. 2008 оны 6 дугаар сард болж өнгөрсөн парламентын сонгуулийг бүхэлдээ чөлөөт ба шударга болсон гэж хараат бус ажиглагчид үзсэн бөгөөд сонгуулиас хойшхи хэсэг хугацаанд үүссэн тодорхой бус байдлын дараа улс төрийн гол хоёр нам болох Монгол Ардын Хувьсгалт Нам болон Ардчилсан Нам эвслийн Засгийн Газрыг байгуулсан юм. 2009 оны 5-р сарын 24-ний өдрийн Ерөнхийлөгчийн сонгуульд сөрөг хүчний нэр дэвшигч ялалт байгуулсан явдал нь тус улсын ардчилсан ололт амжилтуудын илрэл болж уг сонгуулийг шударга явагдсан гэж дотоод, гадаадын ажиглагчид хүлээн зөвшөөрсөн байна.

2006 онд Монгол орны хувьд баримтлах анхны стратеги батлагдсан бөгөөд өнөөг хүртэлх хугацаанд Монгол Улс үсрэнгүй хөгжсөн байна. Сүүлийн 3 жилийн дундажаар эдийн засгийн өсөлт 9 хувьтай байж, нэг хүнд ногдох ДНБ 2005 онд 871 ам доллар байсан бол 2008 онд 1,970 ам доллар болж өссөн байна. Гэвч ядуурлыг бууруулах тал дээр бага ахиц гарсан ба ядуурлын түвшин 2003 оны 36.1 хувиас 2008 онд ердөө 35.2 хувь болж буурсан байна. Засгийн Газар ядуурлыг бууруулах явдлыг үндэсний тэргүүлэх асуудал болгон ач холбогдол өгсөөр хэвээр байгаа бөгөөд 2007 онд Үндэсний Хөгжлийн Стратегийг боловсруулсан байна.

Дэлхийн санхүүгийн хямрал 2008 оны дунд үе хүртэл Монголд нөлөө үзүүлээгүй боловч одоогийн байдлаар тус улсад эдийн засгийн уналт нүүрлээд байна. 2008 оны намар дэлхийн зах зээл дээрхи бараа, түүхий эдийн, ялангуяа зэсийн үнийн үлэмж хэмжээний уналт нь 2008 оны сүүлийн хагас жилийн төсөв болон гадаад тооцоонд сөргөөр нөлөөлж алдагдалтай гарсан байна. Монголын банкны салбар гадаад санхүүжилтэнд нээлттэй бус байхад 2008 онд нөхцөл байдал улам доройтож санхүүгийн хоёр чухал суваг болох хадгаламж болон банк хоорондын санхүүжилт эмзэг болсон байна. Арилжааны банкууд шинэ зээл олголтоо багасгаж, хөрөнгийн чадвараа сайжруулах, нэгдэх зэрэг шаардлагууд банкны салбарт тавигдсан байна.

Засгийн Газар эдгээр хүндрэлүүдийг даван туулахад харьцангуй шуурхай бөгөөд тодорхой арга хэмжээ авч ажиллаж банкны хадгаламжийг төрөөс батлан даах шийдвэр гаргаж, эдийн засгийг сэргээх 1.1 тэрбум ам.долларын төлөвлөгөөг 2009 оны 3-р сард баталсан байна. Мөн Засгийн Газар Олон Улсын Валютын Сантай 229 сая ам.долларын Стэнд-бай хөтөлбөрийн тохиролцоонд хүрсэн. 2009 оны 10-р сард Монголын Засгийн Газар Оюу Толгойн зэс болон алтны ордыг ашиглах зорилгоор Рио Тинто/Айвэнхоу Майнс компанитай хөрөнгө оруулалтын нэн чухал гэрээнд гарын үсэг зурсан юм. Иймээс 2010 онд бусад томоохон уул уурхайн гэрээнүүд байгуулагдах боломжтой ба энэ нь ялангуяа Таван Толгойн нүүрсний ордод хамаатай болно. Санхүүгийн хөшүүргүүд үр нөлөө өгч дээр дурдсан хөрөнгө оруулалтын чухал гэрээнүүд хэрэгжих шатандаа орсон нөхцөлд Монгол Улс эргээд эрүүл болон тогтвортой эдийн засгийн өсөлтийн зам дагуу явах боломжтой юм.

Монгол Улс бүтцийн өөрчлөлт, шинэчлэлтийн салбарт нилээн ахиц гаргасан. Тухайлбал, үнэ болон худалдааны чөлөөлөлт, өмч хувьчлал зэрэгт ахиц дэвшил гаргасан хэдий ч байгууллагын бүтцийн өөрчлөлт болон засаглалын хувьд хоцорч явна. Банкны систем хэмжээний хувьд өсч санхүүгийн зохицуулалт сайжирсан ч одоогийн байдлаар тус салбарт шийдвэрлэвэл зохих асуудлууд тулгараад байна. Хэдийгээр дэд бүтцийн салбарт зарим дэвшил гарсан боловч дэд бүтэц дахь хувийн хэвшлийн оролцоо болон аж ахуйн тогтоцлоонд шилжих үйл явц нь дөнгөж хөгжлийн эхний шатанд явагдаж байна. Энэ

бүхнийг үндэслэн 2009-2011 онд баримтлах Стратегийн шилжилтийн сорилтуудыг дараах байдлаар тодорхойлов:

- Хувийн хэвшлийн бүтцийн өөрчлөлтийг дэмжих ба компанийн засаглалыг сайжруулах
- Санхүүгийн системийг нэгтгэх ба бэхжүүлэх
- Эрдэс баялгийн менежмент ба эдийн засгийг олон төрлийн суурьтай болгох
- Бизнесийн орчныг сайжруулах
- Төрийн мэдлийн дэд бүтцийг арилжааны хэлбэрт шилжүүлэх, түүнд хувийн хэвшлийн оролцоог хангах явдлыг хөхиүлэн дэмжих.

Иймд дээр дурдсан макро эдийн засгийн орчин, өөрчлөлт шинэчлэлтийн үе шатыг харгалзан үзэж, Банк нь дараагийн стратегийг хэрэгжүүлэх хугацаанд үйл ажиллагааны дараах тэргүүлэх чиглэлд анхаарлаа төвлөрүүлэх болно. Үүнд:

(1) Хувийн Хэвшлийн Өсөлт, Хөгжлийг санхүүжүүлэх

Хувийн бизнесийг хөгжүүлэх нь Банкны стратегийн үндсэн тулгуур хэвээр байх болно. Банк нь эдийн засгийг хамрах цар хүрээний хувьд өргөжүүлэхэд хувь нэмрээ оруулах зорилгоор хүнсний үйлдвэрлэл, ноолуур/сүлжмэл, зочид буудал ба аялал жуулчлал, үл хөдлөх хөрөнгө, үйлчилгээ зэрэг нилээн хэдэн гол салбарт шууд хөрөнгө оруулах боломжийг судална. Банк нь олон улсын томоохон нэр хүнд бүхий хөрөнгө оруулагчдыг татахын төлөө ажиллана.

Монгол Улсыг ШЭҮШОДС-д хамруулснаар (Early Transition Countries Initiative) тус улсад санхүүжүүлэх төслүүдийг бэлтгэх боломжийг нэмэгдүүлэх болно. ЖДҮ-ийгн хөгжлийг дэмжих хүчин чармайлтынхаа хүрээнд, Банк нь саяхан хэрэгжиж эхэлсэн Удирдлагыг Өөрчлөн Байгуулах хөтөлбөр (TAM-Turn Around Management) болон Бизнесийн зөвлөлгөө өгөх үйлчилгээ хөтөлбөрүүдийн (BAS-Business Advisory Service Programme) туршлага цаашид хуримтлуулан ажиллана.

Банкны зүгээс бичил болон жижиг бизнесийг үргэлжлүүлэн тусгайлан анхаарч Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй хувийн банкуудаас олгож буй бичил, жижиг бизнесийн зээлийн шугамыг бэхжүүлэн хөгжүүлэх, нэн ялангуяа илүү алслагдсан бүс нутагт хийгдэж буй үйл ажиллагааг хөгжүүлэхийг эн тэргүүлэх зорилтоо болгон ажиллана.

(2) Санхүүгийн салбарын нэгдэл ба бэхжилтийг дэмжих

Зарим арилжааны банкуудын өмнө тулгарсан сорилт бэрхшээлүүдийн мөн чанар нь оролцогч бүх талуудын хамтарсан хүчин чармайлт тухайлбал Төв Банкны удирдлагын арга хэрэгслүүдийг бэхжүүлэхийг шаардаж байна. Банк нь одоо хамтран ажиллаж байгаа арилжааны банкуудтай байгуулсан харилцаа, холбоогоо цаашид өргөжүүлэхийн зэрэгцээ шинээр хамтран ажиллах боломжтой банкуудтай харилцаа тогтоож шууд хөрөнгө оруулах, зээлийн шугамаар хангах, хамтран санхүүжилт хийх зэргээр ажиллана.

Банкны зүгээс Монголын банкны салбарын нэгдлийг дэмжихийн зэрэгцээ нэгдлийн дараа сонгогдсон банкуудын институцын бүтцийг боловсронгуй болгох хөтөлбөрүүдийг хэрэгжүүлнэ. Ингэснээр санхүүгийн орчны нөлөөллөөр гарч ирсэн сул талуудыг засаж залруулахад нь тусална. Банк нь зарим сонгогдсон төслүүдэд шинэ зээлийн санхүүжилт эсвэл урт хугацааны санхүүжилт олгохоос гадна институцийг бий болгох хүрээ, арилжааны банкууд ба бүхэлдээ салбарын удирдлагын хэмжээнд байгаа зөрчил дутагдалд анхаарал хандуулах зорилгоор шаардлагатай техникийн туслалцааг

дайчилж ажиллана. Банкны засаглалын хатуу журмыг тууштай мөрдөж байгаа арилжааны банкуудтай Банк үргэлжлүүлэн ажиллах болно; мөн нарийн судалгааны үндсэн дээр эдгээр банкуудын хөрөнгийн чадвартай байлгах, цаашид нэмэгдүүлэх болон институцыг бий болгох талаар туслалцаа үзүүлнэ (үүнд техникийн хамтын ажиллагааны санг дайчилна).

Банк нь Худалдааг дэмжих хөтөлбөрийг (Trade Facilitation Programme) үргэлжлүүлэн идэвхтэй дэмжиж арилжааны банкууд болон банк бус байгууллагуудад, ялангуяа орон нутагт зээлийн шугам нээх замаар, бичил болон жижиг бизнесүүдийн санхүүжилтийг нэмэгдүүлнэ.

Үүнээс гадна Банк нь банк бус санхүүгийн байгууллагуудын хөгжлийг дэмжин банк бус бичил санхүүгийн байгууллага болох лизинг, даатгал, тэтгэвэрийн байгууллага зэрэгт анхаарлаа хандуулна. Энэ нь эрчим хүчний үр ашгийг нэмэгдүүлэх, сэргээгдэх эрчим хүчийг байгуулахад чиглэгдсэн зээлийн шугам зэрэг эрчим хүчний эцсийн хэрэглээ ба бага оврын, тогтвортой эрчим хүчний салбарт зориулагдсан шинэ санхүүгийн хэрэгслүүдийг багтаан өргөжих боломжтой. Мөн бодлогын хүрээнд Санхүүгийн Зохицуулах Хороотой хамтран ажиллаж хөрөнгийн зах зээлийн хөгжлийг дэмжих болно. Ингэснээр хөрөнгийн зах зээлийн зохицуулалтын тогтолцоог боловсронгуй болгох, удирдлагын чадавхийг дэмжих, компанийн засаглал, санхүүгийн тайлагнал ба ил тод байдлыг сайжруулахад хувь нэмрээ оруулах болно.

(3) Байгалийн баялгийн салбарын тогтвортой хөгжил

Байгалийн баялгийн салбар нь төсвийн орлого, экспорт болон ДНБ-ий томоохон хэсгийг бүрдүүлдэг Монголын ирээдүйг тодорхойлж буй стратегийн чухал салбар юм. Монголын Засгийн Газар, Рио Тинто/Айвэнхоу Майнс компаний хооронд дэлхийн хамгийн том зэсийн ордуудын нэг болох Өмнийн Говьд байрлалтай уурхайг ашиглах замыг нээсэн хөрөнгө оруулалтын гэрээнд 2009 оны 10 дугаар сард гарын үсэг зурсан нь энэ салбарын ач холбогдлыг улам тодруулсан юм. Монголын ирээдүйн хөгжил цэцэглэлт нь байгалийн баялгийн салбарын амжилттай ба зохистой хөгжил, түүний ил тод байдал болон байгаль орчны бодлогоос хамаарах болно.

Банк нь уул уурхайн салбарт хувийн салбарын зээлийн болон өөрийн хөрөнгийн санхүүжилтийн томоохон боломжууд байгааг олж тогтоосон бөгөөд энэ нь томоохон эерэг үр дүн авчрах тул эдгээр боломжуудыг үргэлжлүүлэн судлах болно. Үүнээс гадна, Банк нь Засгийн Газрын зүгээс хувийн томоохон хөрөнгө оруулалт эрэлхийлж байгаа стратегийн ордыг санхүүжүүлэхэд оролцох боломжийг харгалзаж үзнэ. Энэ хүрээнд Банк нь төрийн болон хувийн хэвшлийн ашиг сонирхолын зөв зохистой харьцааг тогтооход туслах зорилгоор Засгийн Газар болон гадаад, дотоодын хувийн хөрөнгө оруулагчидтай хамтран ажиллах болно.

(4) Үндсэн дэд бүтцийг дэмжих

Дэд бүтцийг хөгжүүлэхэд ихээхэн хэмжээний хөрөнгө оруулалт шаардлагатай байгаа ч энэ нь улсын төсвийн хөрөнгө хязгаарлагдмал болон одоогоор хөнгөлөлттэй бус нөхцлөөр санхүүжилт авах боломжгүй байгаа зэргээс шалтгаалж байна. Төр, хувийн хэвшлийн түншлэлд чиглэгдсэн институцийн тогтолцоо хөгжөөгүй хэдий ч аливаа боломж (үүнд институц байгуулах боломжууд орно) бий болвол Банк нь гарсан санаачлагыг сонголтын үндсэн дээр дэмжихэд бэлэн байх болно. Банк нь Монголд одоо байгаа нүүрс хүчлийн хийн эрчимжилтийн өндөр түвшин болон эрчим хүчний алдагдлыг бууруулахад чиглэгдсэн төслүүд дээр төвлөрөн ажиллах болно.

Монгол Улс бага орлоготой орнуудын жагсаалтанд хамрагдахгүй байх нөхцөл нь (тухайлбал Олон Улсын Хөгжлийн Ассоциаци болон Францын Хөгжлийн Агентлагийн

шалгуур үзүүлэлтээр) Банкны хувьд улсын салбарт ажиллах шинэ боломжуудыг бий болгох боломжтой.

Азийн Хөгжлийн Банк, Дэлхийн Банк болон хоёр талт гол хандивлагчидтай хамтран ажиллах нь ЕСБХББанк онгоцны нисэх буудал, зам, төмөр зам болон эрчим хүч дамжуулах төслүүдэд оролцоход шийдвэрлэх нөхцөл болно. Банк нь Төв Азийн орнуудын хэмжээнд тээвэр, эрчим хүч болон худалдааг хөнгөвчлөх бүс нутгийн хамтын ажиллагааг идэвхжүүлэх, хөнгөвчлөхөд чиглэгдсэн Азийн Хөгжлийн Банкнаас дэмжлэгтэй “Төв Азийн бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагаа” хөтөлбөртэй хамтран ажиллах болно.

(5) Бодлогын түвшин дэх яриа хэлэлцүүлэг

Банк нь 2006 оноос Монгол Улсад үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн үеээсээ бодлогын түвшинд хийгдэх яриа хэлэлцүүлгийг идэвхтэй өрнүүлж Монгол дахь хувийн хэвшлийн салбарын хөрөнгө оруулалтанд тэргүүлэх байр суурь эзэлсэн явдал нь корпорацийн засаглал, санхүүгийн салбар, уул уурхай болон хөрөнгө оруулагч нийгэмлэгтэй тогтоосон Засгийн Газар зэрэг салбарт хийгдэх яриа хэлэлцүүлгийг бэхжүүлэх маш сайн үндэс болж чадсан.

Банкны салбарын удирдлагыг сайжруулах, бэхжүүлэх, нэгдэхийг хөхиүлэн дэмжих, мөнгө угаахаас сэргийлэх зэрэг бодлогын шинж чанартай онцгой асуудлууд дээр төвлөрч Монгол Банктай идэвхтэй яриа хэлэлцээр хийх болно. Банк нь 2008 оны дундуур Монгол дахь хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах, хувийн хэвшлийг хөгжүүлэх зөвлөлдөх зөвлөлийн ажлыг амжилттай эхлүүлсэн бөгөөд энэ нь зөвхөн төр-хувийн хэвшлийн хооронд харилцан яриаг өрнүүлээд зогсохгүй Монголын эрх бүхий байгууллагууд болон хөрөнгө оруулагчдын хооронд урд өмнө нь явагдаж байсан яриа хэлэлцэрт дутагдаж байсан шийдвэр гаргах, асуудал боловсруулах, тайлагнах механизм болж чадсан.

Эрдэс Баялаг, Эрчим Хүчний Яам, Ашигт Малтмалын Газар болон Газрын Тосны Газартай бодлогын түвшин дэх яриа хэлэлцүүлгийг үргэлжлүүлж ялангуяа байгалийн баялгийн салбарын эрх зүйг сайжруулах, сэргээгдэх эрчим хүчний төслүүдийн хөгжил болон Олборлох салбарын ил тод байдлын тухай санаачилга (EITI) үр ашигтай хэрэгжүүлэхэд хамааралтай асуудлаар хамтран ажиллах болно. Банк нь эрдэс баялагийг боловсруулах аж үйлдвэрийг байгуулах боломжуудыг судлах дотоодын санаачлага болон боловсруулсан эрдэс баялагийг экспортлоход шаардлагатай дэд бүтцийн хөгжлийг дэмжиж ажиллана.

Банк нь бусад ОУСБ, хандивлагчид болон бизнесийн хамтын нийгэмлэгтэй ажлаа нягт уялдуулан зохицуулна. Банкны Байгаль орчны талаарх бодлого ба Олон Нийтийн Мэдээллийн Бодлого Монгол Улсад хэрэгжүүлж буй бүх төсөлүүдэд хамаарах болно.

ТОВЧИЛСОН НЭРС

ADB	Asian Development Bank – Азийн хөгжлийн банк
AFD	Agence Française de Développement – Францын Хөгжлийн Агентлаг
AM	Annual Meeting – Жилийн уулзалт
AML	Anti-money laundering – Мөнгө угаахтай тэмцэх
BAS	Business Advisory Service – Бизнесийн зөвлөлгөө өгөх үйлчилгээ хөтөлбөр
BEEPS	Business Environment and Enterprise Performance Survey – Бизнесийн орчин болон үйлдвэрийн газрын үйл ажиллагааны судалгаа
BOM	Bank of Mongolia (Central Bank) – Монголбанк (Төв Банк)
CAREC	Central Asian Regional Economic Cooperation – Төв Азийн бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллага
CAS	Country Assistance Strategy – Улс оронд үзүүлэх тусламжийн стратеги
CCA	United Nations Common Country Assessment – НҮБ-ээс улс оронд өгөх Нэгдсэн үнэлгээ
CCIC	Consultative Council on Investment Climate – Монгол дахь хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах, хувийн хэвшлийг хөгжүүлэх зөвлөлдөх зөвлөлийн
CIS	Commonwealth of Independent States – Тусгаар тогтносон улсуудын хамтын нийгэмлэг
CL	Credit Line – Зээлийн шугам
COMECON	Council for Mutual Economic Assistance – Эдийн засгийн харилцан туслах зөвлөл
CPAP	Country Program Action Plan – Улс оронд хэрэгжүүлэх Хөтөлбөрийн Ажлын Төлөвлөгөө
CPI	Corruption Perceptions Index – Авилгалын индекс
CRC	Communications Regulatory Commission – Харилцаа холбооны зохицуулах хороо
CSP	Country Strategy and Programme – Улсын стратеги ба хөтөлбөр
DAC	Development Assistance Committee – Хөгжлийг дэмжих хороо
DIF	Direct Investment Facility – Шууд хөрөнгө оруулалтын хэрэгсэл
DLF	Direct Lending Facility – Шууд зээлжилтийн хэрэгсэл
DP	Democratic Party – Ардчилсан нам
EC	European Commission – Европын комисс
EGSPRS	Economic Growth Support and Poverty Reduction Strategy – Эдийн засгийн өсөлтийг дэмжих ба ядуурлыг бууруулах стратеги
EITI	Extractive Industry Transparency Initiatives – Олборлох салбарын ил тод байдлын тухай санаачилга
ETCI	Early Transition Countries Initiative – Шилжилтийн эхний үе дэх орнуудыг дэмжих санаачлага
ESAF	IMF Enhanced Structural Adjustment Facility – ОУВС-ийн Бүтцийн Зохицуулалтын Хэрэгсэл
EU	European Union – Европын холбоо
FAO	Food and Agriculture Organisation of the United Nations – НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага
EVD	Evaluation Department – Үнэлгээний газар
FDI	Foreign Direct Investment – Гадаадын шууд хөрөнгө оруулалт
FI	Financial Institutions – Санхүүгийн байгууллагууд
FRC	Financial Regulatory Commission – Санхүүгийн зохицуулах хороо
GDP	Gross Domestic Product – Дотоодын нийт бүтээгдэхүүн
GDR	German Democratic Republic – Бүгд найрамдах ардчилсан герман улс
GSM	Global System for Mobile Communication – Үүрэн харилцаа холбооны глобаль систем
GTZ	German Technical Cooperation Fund – Германы техникийн хамтын ажиллагааны нийгэмлэг

IBRD	International Bank for Reconstruction and Development – Сэргээн босголт, хөгжлийн олон улсын банк
ICNC	Information and Communication Networking Company – Мэдээлэл, харилцаа холбооны сүлжээний компани
ICTPA	Information, Communication Technology and Postal Authority – Мэдээлэл, харилцаа холбооны технологи, шуудангийн газар
IDA	International Development Association – Олон улсын хөгжлийн ассоциаци
IFC	International Financing Corporation – Олон улсын санхүүгийн корпораци
IFI	International Financial Institution – Олон улсын санхүүгийн байгууллага
IFRC	International Financial Reporting Standards – Олон улсын санхүүгийн тайлагнах стандартууд
ILO	International Labour Organisation – Олон улсын хөдөлмөрийн байгууллага
IMCHM	Improvement of the Maternal and Child Health Research Centre of Mongolia – Монгол Улсын Эх нялхсын эрдэм шинжилгээний төвийн сайжруулалт
IMF	International Monetary Fund – Олон улсын валютын сан
IOSCO	International Organization of Securities Commissions – Аюулгүй байдлын хороодын олон улсын байгууллага
IPO	Initial Public Offering – Анхны нийтийн арилжаа
JFPR	Japan Fund for Poverty Reduction – Ядуурлыг бууруулах японы сан
JV	Joint Venture – Хамтарсан үйлдвэр
KfW	Kreditanstalt für Wiederaufbau - Сэргээн Босголтын Банк
LIS	Legal Indicator Survey – Эрх зүйн үзүүлэлтийн судалгаа
LTT	Legal Transition Team – Эрх зүйн шилжилтийн баг
MCC	Millennium Challenge Corporation – Мянганы сорилтын корпораци
MCF	Mongolia Cooperation Fund – Монголын хамтын ажиллагааны сан
MCFF	Medium Size Co-Financing Facility – Дунд хэмжээний хамтран санхүүжүүлэх хэрэгсэл
MCHRC	Maternal and Child Health Research Centre – Эх нялхсын эрдэм шинжилгээний төв
MDG	Millennium Development Goals – Мянганы хөгжлийн зорилтууд
MPRP	Mongolia People’s Revolutionary Party – Монгол ардын хувьсгалт нам
MF	Micro Finance – Бичил санхүүжилт
MIAT	Mongolian National Airline – Монголын иргэний агаарын тээвэр
MSE	Micro and Small Enterprises – Бичил ба жижиг үйлдвэрүүд
MSME	Micro, Small and Medium Enterprises – Бичил ба жижиг, дунд үйлдвэрүүд
MT	Mongolian Telecom – Монголын Харилцаа холбоо
MTC	Mongolia Telecommunication Company – Монголын Харилцаа холбоо компани
NEMA	National Emergency Management Agency – Онцгой байдлын ерөнхий газар
NEAP	National Environmental Action Plan – Байгаль орчны үйл ажиллагааны үндэсний хөтөлбөр
NBFI	Non-Bank Financial Institution – Банк бус санхүүгийн байгууллага
NGO	Non-Governmental Organisation – Төрийн бус байгууллага
NPL	Non-performing Loans – Найдваргүй зээлүүд
NPV	Net Present Value - Өнөөгийн цэвэр өртөг
ODA	Official Development Assistance – Хөгжлийн албан ёсны тусламж
OECD	Organisation for Economic Co-operation and Development – Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага
PAM	Petroleum Authority of Mongolia – Газрын тосны газар
PIP	Public Investment Programme – Төсвийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр
PPP	Public-Private Partnership – Төр, хувийн хэвшлийн түншлэл
PRGF	Poverty Reduction and Growth Facility – Ядуурлыг бууруулах ба өсөлтийн хэрэгсэл
PSP	Private Sector Participation – Хувийн хэвшлийн оролцоо
RR	Resident Representative – Суурин төлөөлөгчийн газар
RZD	Russian Railways – Оросын төмөр зам
SCO	Shanghai Cooperation Organization – Шанхайн хамтын ажиллагааны

	байгууллага
SDR	Software Defined Radio - Программ хангамжаар тодорхойлогдох радио
SME	Small and Medium Enterprise – Жижиг ба дунд үйлдвэр
SOE	State Owned Enterprise – Төрийн өмчийн үйлдвэрийн газар
SPC	State Property Committee – Төрийн өмчийн хороо
TA	Technical Assistance – Техникийн туслалцааны төсөл
TACIS	Technical Assistance for Commonwealth of Independent States – ТТУХН-ийн орнуудад зориулсан техникийн туслалцаа
TAM	Turn Around Management - Удирдлагын Өөрчлөн Байгуулах Хөтөлбөр
TC	Technical Cooperation – Техникийн хамтын ажиллагаа
TFP	Trade Facilitation Programme – Худалдааг дэмжих хөтөлбөр
UNEP	United Nations Environment Programme – НҮБ-ын Байгаль орчныг хамгаалах хөтөлбөр
UNDAF	United Nations Development Assistance Framework – НҮБ-ын Хөгжлийн Тусламжийн хөтөлбөр
UNDP	United Nations Development Programme – НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр
UNICEF	United Nations International Children’s Fund – НҮБ-ын Олон улсын хүүхдийн сан
UNCITRAL	United Nations Commission on International Trade Law – НҮБ-ын Олон улсын худалдааны хуулийн комисс
USAID	United States Agency for International Development – АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлаг
WB	World Bank – Дэлхийн банк
WHO	World Health Organisation – Дэлхийн эрүүл мэндийн байгууллага
WTO	World Trade Organisation – Дэлхийн худалдааны байгууллага
WWF	World Wildlife Fund - Дэлхийн байгаль хамгаалах сан
Мөнгөний нэгж	
	Euro, European Union Currency – Евро, Европын холбооны мөнгөн тэмдэгт
EUR	
USD	United States Dollar – АНУ-ын доллар
MNT	Mongolian Currency – Монгол Улсын төгрөг

II. МОНГОЛ ОРНЫ ХУВЬД БАРИМТЛАХ СТРАТЕГИ

1. Банкны Санхүүжилтын Багц

1.1 Өнөөг хүртэлх хугацаанд явуулсан үйл ажиллагааны тойм

Монгол Улс нь 2006 оны 10 дугаар сард Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банкны үйл ажиллагааны орон болсон билээ. Үүнээс өмнө Банкны үйл ажиллагаа нь техникийн хамтын ажиллагаагаар хязгаарлагдаж ирсэн. Гэсэн хэдий ч түүнээс хойш Банк нь өмнө нь үзэглэдсэн бүс нутгийн уул уурхайн хоёр төслөөс гадна зээл, шууд хөрөнгө оруулалт ба баталгаа зэргийг хамарсан нийт 26 төслийг баталсан байна. Гарын үсэг зурагдсан санхүүжилтын хэмжээ нь 126 сая евро байна (бүгд 28¹ төслүүд), үүнд 71 сая еврогийн өр төлбөр/баталгаанууд болон 55 сая еврогийн шууд хөрөнгө оруулалт орно.

Банкны үйл ажиллагаа нь амжилттай өргөжин тэлж бизнесийн бүх салбарт үйл ажиллагаагаа явуулж байгаа хувийн хэвшилд санхүүжилт хийгдсэн байна. Үүнд бүс нутгийн уул уурхай, дотоодын нүүрс үйлдвэрлэгч, өрөмдлөг, газрын тосны дистрибьютор, супермаркетын сүлжээ, орон нутгийн санхүүгийн байгууллагуудад өөрийн хөрөнгийн санхүүжилт болон санхүүгийн байгууллагууд, дотоодын нүүрс үйлдвэрлэгч, ундаа үйлдвэрлэгч, ноолуур үйлдвэрлэгч, үл хөдлөх хөрөнгө ба геофизикийн судалгааны компаний зээлийн санхүүжилт багтана. Доорхи хүснэгтээс харахад, гэрээ хэлцлийн дийлэнх хэсэг нь байгалийн нөөц, жижиг санхүүгийн бизнес, хүнсний үйлдвэрлэл, санхүүгийн байгууллагууд болон аж үйлдвэрийн салбарт байгуулагдсан байна. Банк нь өөрийн үйл ажиллагаагаа хамрах цар хүрээний хувьд өргөжүүлэх зорилготой байсан хэдий ч хөрөнгө оруулалтын багцын гуравны хоёр нь байгалийн нөөцийн салбарт оруулсан санхүүжилт байна. Энэ нь голчлон (i) улс орны хэмжээнд байгалийн нөөцийн салбар хэт давамгайлсан байдал болон (ii) Банк нь урьд өмнө нь дэд бүтцийн салбарт төсөл хэрэгжүүлж байгаагүйтэй холбоотой юм.

Хүснэгт 1-1 Монгол Улс: Өнөөг хүртэлх² Банкны үйл ажиллагааны тойм

	Төслийн тоо	Төслийн нийт өртөг, сая евро	ЕСБХБанкны санхүүжилт, сая евро	Зээл, сая евро	Шууд хөрөнгө оруулалт, сая евро	Хувийн жин, хувиар
Хувийн хэвшил	28	337	126	71	55	100%
Улсын салбар	0	0	0	0	0	0%
Банкуудын өөрийн хөрөнгөнд	1	5	5	0	5	4%
Банкуудад олгос зээл	4	0	3	3	0	2%
Жижиг бизнесийн санхүүжилт	4	16	12	10	2	10%
Хүнсний үйлдвэрлэл	4	23	14	8	6	11%
Аж үйлдвэр	4	9	9	9	0	7%
Байгалийн баялаг	11	284	83	40	42	66%
Бүгд	28	337	126	71	55	100%

¹ Нийт 28 төслүүд байгаагаас 22 нь хөрөнгө оруулалтын төслүүд, гурав нь Худалдааг дэмжих хөтөлбөрийн төслүүд, гурав нь бүс нутгийн уул уурхайн төслүүд байна.

² 2009 оны 9 дүгээр сарын сүүлийн байдлаар

Хүснэгт 1-2 Монгол Улс: Банкны бизнесийн хандлага (Худалдааг дэмжих хөтөлбөрийг оролцуулсан байдлаар)

	2006	2007	2008	2009	Бүгд
Төслийн тоо	2	7	12	5	26*
Жил бүрийн төслийн хэмжээ /сая евро/	3	33	50	26	113

*өмнө нь үзэгдэсэн бүс нутгийн хоёр төслийг хасаж тооцов.

1.2 Өмнөх Стратегийн хэрэгжилт

ЕСБХБ-ны Монгол орны хувьд баримтлах 2006-2009 оны стратеги нь дараахь тэргүүлэх чиглэлүүдийг багтаасан байсан:

- *Хувийн хэвшлийн хөгжлийг санхүүжүүлэх*, зарим гол салбаруудад шууд санхүүжилт хийх, ялангуяа бичил бизнесүүдийг тусгайлан авч үзэх, мөн үлдсэн томоохон хувьчлалыг дэмжихэд төвлөрч ажиллах;
- *Санхүүгийн салбарыг бэхжүүлэх*, дотоодын банкууд, ББСБ-д зээлийн шугам нээх, өөрийн хөрөнгийг санхүүжүүлэх, техникийн туслалцаа үзүүлэх болон Худалдааг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэх замаар;
- *Байгалийн баялгийн салбарыг тогтвортой байдлаар хөгжүүлэх*, ил тод байдал, засаглал, байгаль орчин болон эрх зүйн зохицуулалтанд түлхүү анхаарах, мөн дотоодын уул уурхайн компаниудыг дэмжих;
- *Үндсэн дэд бүтцийн хөгжлийг дэмжих*, бусад хандивлагчид болон олон улсын санхүүгийн байгууллагуудтай нягт хамтран ажиллах байдлаар эдгээр байгууллагуудын санхүүжилтээр хэрэгжиж буй төслүүдэд хувь нэмэр оруулах боломжууд дээр төвлөрөх;
- *Бодлогын түвшинд хийгдэх яриа хэлэлцүүлэг өрнүүлэх*, хөрөнгийн зах зээлийн хөгжлийг идэвхжүүлэх, бизнесийн орчныг сайжруулах болон өөрчлөлт, шинэчлэлт хийх хүчин чармайлтыг дэмжих, мөн хөрөнгө оруулалтын орчны асуудлаар зөвлөлдөх шинэ зөвлөл зохион байгуулах.

Өмнөх стратеги нь Монгол Улс ЕСБХБ-ны үйл ажиллагааны орон болохын өмнө батлагдаж байсан ч Банк нь санхүүжилтийн шинэ хэлбэрүүдийг идэвхитэй нэвтрүүлж чадсан. Энэ нь Стратегийн хэрэгжилтэнд, ялангуяа хувийн хэвшлийн хөгжил, банк болон байгалийн баялгийн салбарт тодорхой ахиц гарах боломжийг олгосон. Төрийн болон орон нутгийн байгууллагуудад хөнгөлөлттэй бус нөхцлөөр зээл олгох боломжгүй байдлаас үүдэн төслүүдийг зөвхөн хувийн секторт хэрэгжүүлсэн болно.

Хувийн Хэвшлийн Хөгжил

Хувийн хэвшлийн салбар нь Монгол Улсын эдийн засагт чухал хувь нэмэр оруулдаг, өсөн дэвжих өргөн боломж байгаа нь ЕСБХБ-ны хувьд тодорхой болсон. Ялангуяа шууд хөрөнгө оруулалт ихээхэн хэрэгцээтэй гэдэг нь харагдсан. (өнгөрсөн оны байдлаар нийт санхүүжилтийн 50 хувь нь шууд хөрөнгө оруулалт байсан). Төрийн өмчийн томоохон үйлдвэрийн газруудын хувьчлал удааширснаар эдгээр газрууд нь санхүүгийн хувьд өрсөлдөх чадваргүй болохын зэрэгцээ стратегийн зорилгоор төрийн хяналтанд байсаар байна.

Өмнөх стратегийн хугацаа буюу 2006-2009 онд ЕСБХБанк нь хүнсний болон аж үйлдвэрлэл, үл хөдлөх хөрөнгө болон уул уурхайн салбарт Шууд зээлжилтийн хэрэгслийн (DLF) 6 гэрээнд гарын үсэг зурж дэлгүүрийн сүлжээ болон өрөмдлөгийн

компаниудтай Шууд хөрөнгө оруулалтын хэрэгслийн (DIF) 2 гэрээг үзэглэсэн байна. Өсөн тэлж буй ЖДҮ-ийн санхүүгийн хэрэгцээ шаардлагыг дотоодын банкууд бүрэн хангах боломжгүй байгаа Монголын бизнесийн орчинд Шууд зээлжилтийн хэрэгсэл болон Шууд хөрөнгө оруулалтын хэрэгслүүд нь амжилттай хэрэгжиж байна.

Удирдлагын Өөрчлөн Байгуулах Хөтөлбөр (одоо хэрэгжиж байгаа) болон “Бизнесийн зөвлөлгөө өгөх үйлчилгээ” хөтөлбөрөөр (2008 онд эхлүүлсэн) дамжуулан Банк нь дотоодын менежерүүдэд дэмжлэг үзүүлж байна.

Санхүүгийн салбарыг бэхжүүлэх

ЕСБХБ-ны хувьд санхүүгийн салбар нь үйл ажиллагаа явуулах гол салбаруудын нэг тул өөрийн хамтран ажилладаг дотоодын банкуудаар дамжуулан бичил болон ЖДҮ-ийг санхүүжүүлдэг ба шууд хөрөнгө оруулалтын замаар банкуудын хөрөнгийн чадварыг бэхжүүлэх, стратеги болон засаглалыг сайжруулах, шинэ бүтээгдэхүүнүүдийг танилцуулахад туслана.

- Банк нь бичил болон ЖДҮ-д зээл олгох зорилгоор дотоодын 3 банкинд зээлийн шугам нээлээ. Эдийн засгийн хямралтай өнөө үед ЕСБХБ нь компанийн засаглалын хувьд шаардлага хангасан тодорхой банкуудад зээл олгохоор судалж байна. Худалдааг дэмжих хөтөлбөрийн хэрэгслүүд нь харилцагч дотоодын банкуудын хувьд санхүүгийн чухал эх үүсвэр болж байна. Банк нь төсөлд хамрагдаж буй дотоодын банкуудад техникийн туслалцаа үзүүлэн компанийн засаглалыг сайжруулах чиглэлээр ажиллаж байна.
- Шууд хөрөнгө оруулалтын хувьд ЕСБХБ нь дотоодын 2 банкны дүрмийн санг нэмэгдүүлэхэд оролцсон юм. Уг хөрөнгө оруулалттай холбоотойгоор банкны чадавхийг бэхжүүлэх техникийн туслалцаа үзүүлсэн.
- ЕСБХБ нь Монголын даатгалын салбарын зохицуулалтыг боловсронгуй болгох зорилгоор Санхүүгийн зохицуулах хороонд техникийн туслалцаа үзүүлсэн байна.

Байгалийн баялгийн салбарыг тогтвортой хөгжүүлэх

Энэ салбар нь Монгол Улсын ирээдүйн хувьд стратегийн чухал ач холбогдолтой юм. ЕСБХБ нь уул уурхайн олон төслийн хүрээнд дотоод болон гадаадын хөрөнгө оруулагчидтай хамтран уул уурхайн хэд хэдэн төслүүдийг зээл олгох болон шууд хөрөнгө оруулалтын замаар санхүүжүүлсэн. 2006-2009 онд нийт санхүүжилтийн 68 хувь байгалийн нөөцийн салбарт хийгдсэн. Бодлогын түвшинд хийгдэх яриа хэлэлцүүлэг нь Монголын стратегийн ордуудын тогтвортой хөгжилд чиглэгдэж байгаа ба үүнд байгаль орчны зохистой бодлого орж байна.

2007 онд ЕСБХБ-ны анхны санхүүжилт нь дотоодын хувийн нүүрсний уурхайд хийгдсэн ба энэхүү төсөл нь нүүрс цэвэршүүлэх технологийг нэвтрүүлэхэд зориулагдсан. Банкны хамгийн сүүлд гарын үсэг зурсан гэрээ нь дотоодын уул уурхайн компани болох Энержи Ресурсд шууд хөрөнгө оруулалтын санхүүжилт байсан. Энэ компанийг Монголын хамгийн том хувийн 3 групп эзэмшдэг ба үүнд MCS, Петровис болон Шунхлай орж байна. Эдгээр 3 групп нь өөрсдөө болон гадаадын түншүүдтэй хамтарсан үйлдвэр байгуулах замаар Монголд өргөн хэрэглээний бараа, хүнд машины нийлүүлэлт, түлш шатахуун, эрчим хүч зэрэг салбарт үйл ажиллагаагаа явуулдаг арвин туршлагатай юм. Эдгээр бүх уул уурхайн томоохон гэрээ хэлцлүүд нь шилжилтийн үйл явцад чухал хувь нэмэр оруулсан гэж үнэлэгдсэн. Үүнээс гадна, Банк нь шатахуун түгээх дистрибьюторын сүлжээг өргөжүүлэх зорилгоор Монголд 2-рт орох түлш

шатахууны томоохон дистрибьюторт зээл ба шууд хөрөнгө оруулалтын санхүүжилт хийсэн.

Зайлиггүй шаардлагатай дэд бүтцийн хөгжлийг дэмжих

ЕСБХБанк нь сэргээгдэх эрчим хүч болон агаарын тээврийн салбар дахь хувийн хэвшлийн төслүүдийг хэлэлцсэн. Гэвч хөнгөлөлттэй бус нөхцлөөр зээл авах, баталгаа гаргах чадваргүй байдаг тул хотын дэд бүтцэд санхүүжилт хийхэд хүндрэлтэй юм. Зээлийн хүүг багасгах зорилгоор ЕСБХБ-ны санхүүжилт болон буцалтгүй тусламжийг уялдуулах нь Монголын нөхцөлд хэрэгжих боломжгүй гэдгийг тогтоосон юм.

Гэвч, Монгол Улс нь дараагийн хэдэн жилд хөнгөлөлттэй санхүүжилт авах орнуудын нэг байхаа болих магадлалтай тул ЕСБХБ-ны дараагийн стратегийн хугацаанд хотын болон бүс нутгийн тээврийг багтаасан дэд бүтцийн төслүүдийг судлах боломжтой.

Бодлогын түвшинд хийгдэх яриа хэлэлцүүлэг

Монгол Улсын хувьд хөрөнгө оруулагчид болон эрх бүхий байгууллагуудын хоорондох харилцаа нь чухал байдаг ба тогтмол уулзалтууд (заримдаа Ерөнхийлөгчийн ивээл дор) зохион байгуулагддаг ба худалдаа аж үйлдвэрийн танхим болон бизнесийн холбоодууд идэвхитэй үйл ажиллагаа явуулсаар ирсэн. Ийм учраас Банк нь 2008 оны дундуур Монгол дахь хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах, хувийн хэвшлийг хөгжүүлэх зөвлөлдөх зөвлөлийн ажлыг эхлүүлсэн ба түүний зорилго нь шийдвэр гаргагчид, дотоодын ба гадаадын бизнесийн байгууллага болон хандивлагчдын хооронд шууд харилцах сувгийг бий болгоход оршино. Монгол дахь хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах, хувийн хэвшлийг хөгжүүлэх зөвлөлдөх зөвлөлийн уулзалтуудыг улирал бүр Ерөнхий Сайд болон Шадар Сайдын ивээл дор зохион байгуулагддаг.

Мөн түүнчлэн Банк нь техникийн хамтын ажиллагааны хүрээнд ихээхэн дэмжлэг үзүүлсэн бөгөөд эдгээр нь Монголын ирээдүйн хувьд чухал ач холбогдолтой юм. Үүнд 0.3 сая еврогийн төсөвтэй Даатгалын салбарын зохицуулалтыг шинэчлэх, өргөжүүлэх төсөл, Сэргээгдэх эрчим хүчний зохицуулалтыг хөгжүүлэх 0.29 сая еврогийн төсөл, Уул уурхайн салбарын чадавхийг бэхжүүлэх 2.0 сая еврогийн төсөл, Улаанбаатар хотын цэвэр агаар санаачлага 0.3 сая еврогийн төсөл болон Геологийн мэдээллийн дижитал өгөгдлийн системийг хөгжүүлэх 2.2 сая еврогийн төсөл тус тус орж байна.

1.3 Шилжилтийн нөлөө ба хуримтлуулсан туршлага

1.3.1 Шилжилтийн үйл явцад нөлөөлөх нь

ЕСБХБ нь Монголын хувийн хэвшлийн санхүүжилтын зах зээл дээр онцгой байр суурийг эзэлсэн бөгөөд шинээр эрчимтэй хөгжиж буй хувийн хэвшил нь Монгол Улсын хөгжлийн дараагийн шатны хөдөлгүүр болох нь тодорхой болж байна. Манай төслүүд нь дөнгөж эхний шатандаа явж байна. Одоогоор төслүүд нь шилжилтийн үйл явцад үр дүнтэй нөлөө үзүүлж байгаа боловч гарах бодит үр дүнг тодорхойлохын тулд нилээн хугацаа шаардагдах юм.

Хувийн хэвшлийн хөгжил

Хүнсний үйлдвэрлэл, аж үйлдвэр, үл хөдлөх хөрөнгө болон уул уурхайд холбогдох үйлчилгээний салбарт Шууд зээлжилтийн хэрэгсэлийн 6 төслийг хэрэгжүүлсэн бөгөөд эдгээр нь дотоодын санхүүгийн зах зээл дахь нөхцлүүдийн харьцангуй урт хугацаатай

ба их хэмжээтэй санхүүжилтыг шаардаж байсан салбарууд юм. Эдгээр төслүүд нь санхүүгийн тайланг тогтмол гаргах, аудит хийх зэрэг асуудлуудыг хэвшүүлснээр компанийн засаглалыг сайжруулах болон компаниудын ил тод байдлыг сайжруулахад ихээхэн нөлөө үзүүлж эхэлсэн юм. Эдгээр үйлчлүүлэгчид нь зах зээлээ өргөжүүлсэн ба өрсөлдөөнийг нэмэгдүүлсэн байна.

Дотоодын супермаркетын сүлжээг (Шууд хөрөнгө оруулалтын хэрэгсэл) санхүүжүүлсэн нэг төсөл мөн л зах зээлийг тэлэхэд хувь нэмрээ оруулсан, гэвч шилжилтийн нөлөө нь нийлүүлэгчдийн үйл ажиллагааг сайжруулах хөшүүрэг болон гарч ирэх учиртай, тухайлбал, бараа нийлүүлэгчдэд чанарын болон эрүүл ахуйн хатуу шаардлага тавихын хамт илүү сайн нөхцлөөр гэрээ байгуулах ёстой. Шууд хөрөнгө оруулах нь компанийн бизнес стандартыг сайжруулах боломжийг олгож байгаа юм (жишээ нь хараат бус зөвлөлийн төлөөлөл, олон улсын санхүүгийн тайлагнах стандартууд болон дотоодын шинэ урамшууллын схем).

Банк нь Удирдлагын Өөрчлөн Байгуулах Хөтөлбөр (одоо хэрэгжиж байгаа, 2009-2012 оны үйл ажиллагааг техникийн хамтын ажиллагааны зөвлөлөөр саяхан баталж сунгасан) болон Бизнесийн зөвлөлгөө өгөх үйлчилгээ (2008 онд эхлүүлсэн) зэрэг хөтөлбөрүүдийг мөн хэрэгжүүлж байна. Эдгээр хөтөлбөрүүд нь голчлон жижиг болон дунд хэмжээний хувийн хэвшилд ур чадвар ба бизнес практикийг сайжруулахад тусалж байна (үүнд санхүүгийн тайлагнал, нягтлан бодох бүртгэл болон маркетинг орно).

Санхүүгийн салбар

Банк нь Монголын банкны салбарт шилжилтийн үр дүнд хүрсэн хэдий ч салбарын хэмжээнд болон хэд хэдэн банкуудын өмнө их олон сорилтууд нүүрлэж олон зүйлийг хийх шаардлагатай байна. Бичил болон ЖДҮ-д нээсэн зээлийн шугамууд нь хувийн компаниудад, ялангуяа орон нутагт зах зээлээ өргөжүүлэхэд нь тусалсан байна. Худалдааг дэмжих хөтөлбөрүүд нь зөвхөн бүс нутгийн худалдааны үйл ажиллагааг идэвхжүүлэхээс гадна Монголын банкуудын хүчин чадал болон нэр хүндийг нь өсгөж байгаа юм.

Институци байгуулах тал дээр бол өөрийн хөрөнгийн санхүүжилт болон Худалдааг дэмжих хөтөлбөр гэх мэт техникийн хамтын ажиллагааны төсөл зэрэг Банкны оролцоо нь компанийн засаглалын стандарт болон бизнес практикийг сайжруулахад тусалж байна. Салбарын зохицуулалт ба удирдлагын хувьд Банк нь Монголын даатгалын зохицуулалтыг нэмэгдүүлэх зорилгоор Санхүүгийн Зохицуулах Хороонд (банк бус санхүүгийн байгууллагуудад зориулагдсан хараат бус зохицуулагч агентлаг) техникийн туслалцаа үзүүлсэн байна.

Байгалийн баялгийн салбар

Банкны үйл ажиллагаа нь байгалийн баялгийн салбарт томоохон нөлөө үзүүлсэн байна. Баримт дурьдвал, энэ салбарын гурван том төслүүдэд “онцсайн” шилжилтийн нөлөө үзүүлэх боломжтой гэсэн үнэлгээг Зөвлөлийн хурлаас өгсөн юм. Уул уурхайн салбарт төрийн оролцоо давамгайлж байгаа хэдий ч Банк уул уурхайд хувийн хэвшлийн оролцоог өсгөн нэмэгдүүлэхэд ихээхэн хувь нэмэр оруулсан билээ. Олборлох Салбарын Ил Тод Байдлын тухай Санаачлагыг корпорацийн түвшинд (мөн түүнчлэн улсын хэмжээнд бодлогын хүрээнд) хэрэгжүүлэхэд Банкны үйл ажиллагаа мөн тусалсан байна. Банкны төслүүдийг хэрэгжүүлснээр байгаль орчны/нийгмийн менежментийн өндөр стандарт хэвшиж, ил тод байдал бий болсон ба корпорацийн удирдлага сайжирсан юм.

Банкны үйл ажиллагаа нь зах зээлд шинэ бүтээгдэхүүнүүдийг нэвтрүүлэхэд хувь нэмэр оруулж байна. Жишээлбэл, “нэг цэгийн үйлчилгээ” гэх зах зээлийн загварыг (гол нэрийн барааны дэлгүүрүүд, бэлэн мөнгөний автомат машинууд г.м.-ийг шатахуун түгээх станцууд дээр байгуулах) нэвтрүүлэхэд Монголын түлш шатахууны салбарт хоёрт орох томоохон дистрибьюторт зориулагдсан төсөл зохих хувь нэмрээ оруулсан байна. Уул уурхайн хамгийн том хувийн компаниудын нэг болох Монгол Алт компанид үзүүлсэн Банкны санхүүжилтийн нэг хэсгийг цэвэршүүлсэн нүүрс үйлдвэрлэхэд (Монгол Улсад анх удаа) зориулж олгосон юм. Энэржи Ресурс компанид хийсэн санхүүжилт нь Монголын уул уурхайн компанид хийгдсэн анхны шууд хөрөнгө оруулалт юм.

Бодлогын түвшинд хийгдэх яриа хэлэлцүүлэг

ЕСБХБанк Монгол Улсад үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн цаг үеэс эхлэн эрх бүхий байгууллагуудтай бодлогын асуудлаар чухал яриа хэлэлцүүлэг өрнүүлж байсан юм. 2007 онд Монгол Улсын Ерөнхийлөгч ЕСБХБанкинд зочилсон бөгөөд ЕСБХБанкны Ерөнхийлөгч Тэргүүн Дэд Ерөнхийлөгч Банкны бусад удирдах ажилтнуудын хамт Монголд айлчилж өмнөх стратегийн хугацааны туршид Бодлогын түвшин дэх яриа хэлэлцүүлэгт оролцож байсан билээ.

Банк нь Монгол дахь хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах, хувийн хэвшлийг хөгжүүлэх зөвлөлдөх зөвлөлийг (CCIC) техникийн хамтын ажиллагааны хөтөлбөрийн (ТС) дэмжлэгтэйгээр байгуулснаар шийдвэр гаргагчид, дотоодын ба гадаадын бизнес нийгэмлэг болон хандивлагчид шууд харилцах боломжийг бий болгосон юм.

Уул уурхайн салбарт олон улсын байгууллагуудаас гаргасан уул уурхайн салбарын хөгжилд шударга, ил тод ба зохистой ажлын хүрээг тогтоох талаар Засгийн Газарт зөвлөлгөө өгөх санаачлагад ЕСБХБанк идэвхитэй оролцсон. Түүнчлэн уул уурхайн хөрөнгийн мэдээллийн санг бүрдүүлэхэд чиглэгдсэн уул уурхайн эрх бүхий байгууллагуудын чадавхийг бий болгоход Банк дэмжлэг үзүүлсэн байна (энэ нь уул уурхайн салбарын мэдээллийн ил тод байдлыг сайжруулахад хувь нэмэр оруулна). Банк нь сэргээгдэх эрчим хүчний салбарын зохицуулалтыг бэхжүүлэх (Сэргээгдэх эрчим хүчний зохицуулалтын хөгжлийн бүдүүвч зураг) болон Улаанбаатар хотын агаарын бохирдлын асуудлыг шийдэх арилжааны шинж чанартай механизмуудыг нэвтрүүлэхэд (Улаанбаатар хотын цэвэр агаар санаачлага төсөл) чиглэсэн бодлогын түвшин дэх яриа хэлэлцүүлгийг өрнүүлж байна. Мөн ЕСБХБ Монгол Улсын эрчим хүчний салбарыг өөрчлөн шинэчлэхэд чиглэсэн хандивлагчид болон эрх бүхий байгууллагуудын үйл ажиллагааг зохицуулагч Эрчим хүчний ажлын хэсгийн үйл ажиллагаанд оролцож байгаа болно.

1.3.2 Төслүүдийг санхүүжүүлсэн байдал

Одоогийн байдлаар 27³ төсөл зурагдсанаас 21 төсөл нь санхүүжилт олгох, 6 нь эргэн төлөгдөх шатанд явж байна. ЕСБХБанкны төслүүдийн дийлэнхи хэсэгт нь санхүүжилт саяхнаас олгогдсон ба эдгээр төслүүд эргэн төлөгдөх шатандаа явж байгаа учраас үнэлэлт дүгнэлт өгөхөд эрт байна. Гэсэн хэдий санхүүгийн хямралаас улбаалан нэгэн уул уурхайн үйлчилгээ үзүүлдэг гадаадын хөрөнгө оруулалттай жижиг аж ахуйн нэгжтэй байгуулсан өөрийн хөрөнгийн санхүүжилтийн төслийн хэрэгжилт болон нэгэн банк дээр ихээхэн хэмжээний найдваргүй зээл хуримтлагдсан зэргээс шалтгаалан 2 төсөл дээр хүндрэлүүд гарсан. Одоогоор хэрэгжүүлж буй төслүүд нь улсын бус салбарт

³ Нэг төсөл бүрэн хэрэгжиж дууссан.

байгаа хэвээр байна. Эргэлтийн хөрөнгийн 51 хувь нь шууд хөрөнгө оруулалт эзэлж байгаа нь өндөр үзүүлэлт юм.

1.3.3 Хамтарсан санхүүжилтийг дайчлах

Одоогоор хэрэгжүүлж буй төслүүдээс албан ёсоор хамтарсан хэлбэрээр санхүүжигдсэн төсөл нь MCS Кока Кола компанийн ундаа савлах үйлдвэрийг өргөжүүлэх төсөл бөгөөд ЕСБХБ-наас 7.0 сая ам доллар болон Cordiant Capital-ын 6.0 сая ам доллараас бүрдсэн хөрөнгө оруулалт юм. Энэхүү төсөл нь Монголын зах зээл дээр бүртгэгдсэн цөөн хамтарсан санхүүжилтүүдийн нэг бөгөөд зах зээл сэргэсний дараах хамтран санхүүжилтийн төслүүдэд үлгэр жишээ болох учиртай юм.

1.3.4 Хуримтлуулсан туршлага, сургамжууд

ЕСБХБанк нь 2006 оноос хойш нийлбэр дүнгээр 113 сая еврогийн нийт 26 хөрөнгө оруулалтын төслийг санхүүжүүлсэн (хүснэгт 1-2) ба энэ үйл явцад тус Банк нь хувийн хэвшлийн манлайлагч хөрөнгө оруулагчийн байр суурийг эзэлж чадсан байна. Өнөөдрийг хүртэлх хугацаанд Банк туршлага хуримтлуулан зарим сургамжуудыг авсан юм. Үүнд:

- Хандивлагч болон хөнгөлөлттэй санхүүжилт давамгайлсан нөхцөлд үйл ажиллагаагаа явуулж байгаа хэдий ч ЕСБХБанк нь бодит хөрөнгө оруулалт ба бүтцийн өөрчлөлтийг дэмжих замаар хувийн хэвшлийн үйл ажиллагааг Монгол Улсын хөгжлийн дараагийн шатны хүчтэй хөтлөгч болгох боломжтой гэдгийг баталсан;
- Буцалтгүй тусламж, хөнгөлөлттэй зээл зэргээс хүчтэй хамаарсан улс оронд ч мөн зээлийн болон өөрийн хөрөнгийн санхүүжилтыг арилжааны журмаар олгож бизнесийн соёл, сэтгэлгээг хөгжүүлэх боломжтой гэдгийг харуулсан (мөн чадавхи бэхжүүлэх техникийн хамтын ажиллагаа үүнд орно);
- Шилжилтийн эхний үе шатан дахь орнуудыг дэмжих санаачлага нь Монголын хувийн хэвшлийн хөгжлийг дэмжих маш сайн механизм мөн болох нь батлагдлаа. Энэ нь Шууд зээлжилтийн хэрэгсэл/Шууд хөрөнгө оруулалтын хэрэгсэл болон Дунд хэмжээний хамтарсан санхүүжилтын хөтөлбөр байдлаар олгох жижиг хөрөнгө оруулалтын журмыг хялбар болгохоос гадна нарийвчилсан судалгаа, хяналт болон хэрэгжилтийн явцад шаардагдах техникийн хамтын ажиллагааны дэмжлэг авах боломжийг нээж байна. Энэ нь Банкны Бичил санхүүжилтийн хэлтэс, Хүнсний үйлдвэрлэлийн хэлтэс болон УӨБХ(ТАМ)/БЗӨҮХөтөлбөр (BAS) зэрэг хэд хэдэн хэлтсүүдийн идэвхтэй оролцоог хангаж байгаа юм.
- Дотоодын хувийн компаниудыг санхүүжүүлэх замаар Монгол Улсын уул уурхайн салбарт компанийн засаглал болон ил тод байдлын стандартууд, түүнчлэн байгаль орчин, эрүүл мэнд болон аюулгүй ажиллагааны олон улсын шилдэг стандартуудыг нэвтрүүлэх боломжтой байна. Ингэснээр шинэ жижиг бизнесүүдийг дэмжин алслагдсан бүс нутагт эдийн засгийн эрчимтэй хөгжил, тогтвортой өсөлтийг нэвтрүүлж байна, УӨБХ(ТАМ)/БЗӨҮХөтөлбөрүүдийн (BAS) тусалцаатайгаар ийм үр дүнд хүрэх боломж байна.
- Дотоодын санхүүгийн байгууллагуудад санхүүжилт олгохдоо Институци байгуулах оновчтой төлөвлөгөөг хэрэгжүүлэн үйл ажиллагаанд нарийвчилсан шалгалт тогтмол хийж, мөн шаардлагатай үед шийдвэр гаргах, хариуцлага хүлээх тогтолцоог бий болгох үүднээс нэмэлт аудит хийх шаардлагатай юм.

- Техникийн хамтын ажиллагааны хөтөлбөрийн санхүүжилтээр хийгддэг зөвлөх үйлчилгээ нь дотоодын бизнесүүд болон банкуудын чадварыг бэхжүүлэх, шинээр бий болгоход дэмжлэг үзүүлэхэд чухал хувь нэмэр оруулдаг. Нэг үйлчлүүлэгчид олон төрлийн бүтээгдэхүүн хүргэх чадвар нь Банкны нөлөөг өсгөж байна.
- Техникийн хамтын ажиллагааны хөтөлбөрийн санхүүжилтээр хийгддэг нарийвчилсан судалгаа (техникийн, хууль эрх зүйн, санхүүгийн, байгаль орчны, нийгмийн болон санхүүжилт хийгдсэний дараах хяналт) нь орон нутгийн ЖДҮ-ийн хувьд ЕСБХБанкнаас санхүүжилт олгох, эсэхийг шийдэхэд амин чухал үүрэгтэй юм. Банкны шаардлагыг хангахуйц дотоодын мэргэжилтнүүд хомс байдаг тул ЖДҮ-ийн хувьд энэхүү судалгаа нь зардал өндөртэй байдаг юм. Банкнаас хийгдэж буй шууд хөрөнгө оруулалтын хүрээнд одоо үзүүлж буй техникийн хамтын ажиллагааны дэмжлэгийг авах нь Хараат бус Зөвлөлийн Гишүүдийн хувьд мөн чухал асуудал юм.
- Сэргээгдэх эрчим хүч зэрэг онцлог салбаруудад Засгийн Газартай яриа хэлэлцүүлэг хийн тухайн салбарт өөрчлөлт шинэчлэлтийг нэвтрүүлж хувийн хэвшилд хөрөнгө оруулалт хийх боломжтой.

1.4 Хэрэгжүүлсэн төслүүдийн харьцаа

2006-2009 оны стратегийн хугацааны туршид ЕСБХБ санхүүжүүлсэн бүх төсөл хувийн хэвшлийн салбарт хийгдсэн (100% хувийн хэвшилд) бөгөөд голчлон байгалийн баялгийн болон санхүүгийн салбарт хэрэгжсэн юм. Энэ харьцаа нь Банкны Монгол орны хувьд баримтлах стратегийн тэргүүлэх чиглэлүүд болон Шилжилтийн эхний үе шатан дахь орнуудыг дэмжих санаачлагын ажлын хүрээтэй холбоотой юм.

2. Үйл ажиллагааны орчин

2.1 Өөрчлөлт шинэчлэлийн ерөнхий орчин

2.1.1 Улс төрийн орчинд гарсан өөрчлөлтүүд

Улс орны ардчилсан шилжилт нь ахиц дэвшилтэй байгаа нь илэрхий юм. Монгол Улс нь олон намын бүтэц болон төрийн бус байгууллагуудын идэвхтэй сүлжээг бий болгосон билээ. Хэвлэл мэдээллийн байгууллагууд өргөн хүрээтэй асуудлуудаар чөлөөтэй мэдээлдэг бөгөөд хууль журмын мөрдөлт болон хүний эрхийг хүндэтгэх явдал улам нэмэгдэж байна.

1992 оны Үндсэн Хууль нь дөрвөн жил тутам сонгогддог Улсын Их Хурал буюу 76 гишүүн бүхий нэг танхимтай парламентын системийг үндэслэсэн юм. Парламентын сүүлийн сонгууль нь 2008 оны 6 дугаар сард явагдсан бөгөөд хараат бус ажиглагчдын тодорхойлсноор уг сонгууль тэнцвэртэй, чөлөөт ба шударга болж өнгөрсөн билээ. Монголын улс төрийн үйл явцад улс төрийн гол хоёр нам болох МАХН болон АН хүчтэй нөлөө үзүүлдэг уламжлалтай юм.

Хамгийн сүүлд болсон ерөнхийлөгчийн болон парламентын сонгуулиуд нь урд өмнөх сонгуулиудаас нэг их өөр байсангүй. МАХН нь хууль тогтоох байгууллагад олонхийн суудлаа нэмэгдүүлсэн боловч АН-аас сонгуулийн дүнг маргаантай гэж үзсэн байна. Сонгуулийн дараах тодорхойгүй байдал хоёр сар орчим үргэлжилсэн бөгөөд 2008 оны 8 дугаар сарын сүүлээр АН шинээр сонгогдсон парламентыг эсэргүүцэхээ зогсоосон юм. Хэдийгээр МАХН дангаараа Засгийн Газар байгуулахад хангалттай олонхийг бүрдүүлсэн байсан хэдий ч тус нам цөөнх болох АН-тай хамтран эвслийн Засгийн Газрыг байгуулахаар шийдсэн юм.

Шинээр байгуулагдсан эвслийн Засгийн Газрын бүтэц бүрэлдэхүүнд улс төрийн гол хоёр хүчин орсон бөгөөд илүү уялдаатай байдлаар хөгжих боломжийг нээсэн байна. Дэлхийн эдийн засгийн хямралаас үүдэн хурцадсан эдийн засгийн болон нийгмийн сорилтууд улс орны өмнө тулгарч байгаа өнөө үед эвслийн Засгийн Газар байгуулсан явдал нь тогтвортой байдлыг бүрдүүлэхэд зохих хувь нэмрээ оруулсан байна.

2009 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн Ерөнхийлөгчийн сонгуульд сөрөг хүчний нэр дэвшигч буюу Ерөнхий Сайдаар хоёр удаа ажиллаж байсан Цахиагийн Элбэгдорж ялалт байгуулсан юм. Энэ сонгууль нь тайван орчинд болж өнгөрсөн ба өнгөрсөн жилийн парламентын сонгуулийн дараа сонгуулийн үр дүнг эсэргүүцсэн иргэдийн үймээн энэ удаад дахин давтагдсангүй.

2.1.2 Хууль эрх зүйн шинэчлэл

Сүүлийн хорин жилийн хугацаанд Монголын хууль эрх зүйн системд томоохон өөрчлөлтүүд хийгдсэн байна. Одоо хүртэл үйлчилж буй 1992 оны Үндсэн Хууль нь бүгд найрамдах зарчмууд дээр үндэслэсэн ардчилсан улсын суурийг тавьсан юм. Монголын эрх баригчид гадаадын хөрөнгө оруулалт болон худалдааг дэмжих зорилгоор нээлттэй дотоод зах зээлийн стратегийг сонгон авсан байна. Олон улсын шилдэг практик дээр үндэслэн худалдааны эрх зүйг сонгож авсан нь бизнесийн харьцангуй таатай орчныг бий болгосон байна. Гэвч бизнесийн оролцоог тогтоож барих нь амаргүй хэвээр үлдсэн ба захиргааны дэд бүтэц болон одоогийн татварын систем нь бизнесийн үйл ажиллагаанд ихээхэн саад бэрхшээлүүдийг учруулж байна.

Төлөвлөгөөт системээс зах зээлийн эдийн засаг руу шилжих явцад арилжааны байгууллагууд, татварын асуудлууд, банкны үйл ажиллагаа, аюулгүй байдлын зах зээл, арбитраж болон валютын арилжаа зэргийг зохицуулсан олон хуулийг боловсруулж мөрдсөн байна. 2002 онд баталсан Иргэний Хууль нь орчин үеийн иргэний хуулийн системийн суурийг тавихад чухал алхам болсон байна. Гэвч дотоодын хууль тогтоох болон шүүх эрх мэдлийн байгууллагуудын хувьд энэ хуулийн заалтуудыг дунд шатанд болон шүүхийн практикт зохих ёсоор нь биелүүлэх асуудал дутагдалтай хэвээр байна. Үүнээс гадна, шүүгчид хэт хялбаршуулсан ба заримдаа дур зоргоороо шийдвэр гаргах хандлагатай байгаа бөгөөд авилгал өргөн тархсан талаар мэдээлэгдсээр байна.

Зээлийн хүү хэт өндөр, урт хугацаатай зээл дутагдалтай болон байгууллагын орчин учир дутагдалтай зэргээс шалтгаалан арилжааны зээл олголт хүндэрсэн байна. Дампуурал, татварын урамшууллууд болон зээлийн хэрэгслүүдтэй холбоотой шинэ хууль эрх зүйн орчин ойрын үед бий болвол эдгээр төвөгтэй асуудлуудыг шийдвэрлэхэд туслах юм. Монгол Улсын Компаний засаглалын тухай хууль болон Төр-Хувийн хэвшлийн харилцааны тухай хуулийн төсөл зэрэг шинэ зохицуулалтууд нь удаан хугацаанд тодорхой бус байсан асуудлуудыг эцэслэн шийдэх хүсэл эрмэлзлийн илрэл бололтой. Засгийн Газар нь хувийн хөрөнгө оруулалтыг хамгаалах, аюулгүй байдлыг хангахад чиглэгдсэн хууль журмыг биелүүлэхэд төвлөрч ажиллах ёстой юм. Эдгээр өөрчлөлтүүд явагдаж эхэлж байгаа гэсэн шинж тэмдэг илэрч байна.

2.1.3 Бизнесийн орчин

Бүс нутгийн хэмжээнд авч үзвэл Монгол дахь бизнесийн орчин харьцангуй сайн байгаа юм. Дэлхийн Банкнаас жил бүр эрхлэн гаргадаг Бизнес Эрхлэхүй 2009 оны тайлангийн дагуу Монгол Улс нь бүс нутгийн хөршүүд болох Хятад, Орос болон Төв Азийн бусад орнуудыг ихэнхи үзүүлэлтээр давж гарсан байна. Ялангуяа бизнес эхлэх, хөрөнгө оруулалтыг хамгаалах болон ажилд авах, халах тал дээр сайн үр дүнтэй гарсан байна. Бүхэлдээ Монгол Улс нь 2009 онд 181 орноос 58-д жагсаж байна.

Гэвч хамгийн сүүлд гарсан ЕСБХБ/Дэлхийн банкны Бизнесийн орчин болон үйлдвэрийн газрын үйл ажиллагааны судалгааны үр дүнгээс харвал олон сорилтууд хүлээгдэж байгааг гэдгийг менежерүүдийн санал бодол нотолж байна. Хөдлөх болон үл хөдлөх хөрөнгийн бүртгэлийн ажиллагаа төвөгтэй, хууль журмыг сахиулахад хүндрэлтэй болон шүүхийн систем сул гэж бизнесүүд үзэж байна. Санхүүжилт олох асуудал нь бизнесүүдийн хувьд, ялангуяа бичил болон жижиг бизнес эрхлэгчид, хамгийн том асуудал хэвээр байна. Татварын хувь хэмжээ нь бусад орнуудтай харьцуулахад бага байгаа хэдий ч бизнесүүд татварын асуудлыг бизнес хийхэд саад учруулдаг гэж үзсэн хэвээр байна.

Хүснэгт 2-1: Бизнесийн үйл ажиллагаанд нь янз бүрийн бэрхшээл учирч буй компаниудын хувь хэмжээ, 2008 он

	Бичил болон жижиг компаниуд	Жижиг болон том компаниуд
Санхүүжилтийн олдоц	64.1	58.7
Татварын түвшин	56.4	52.7
Лицензи болон тусгай зөвшөөрлүүд	51.3	50.3
Авилгал	46.2	47.9
Тээврийн дэд бүтэц	39.5	46.1
Бизнесийн хяналт шалгалт	38.0	38.3
Гааль болон худалдааны зохицуулалт	34.9	39.5
Гэмт хэрэг, хулгай дээрэм, замбараагүй байдал	31.8	35.3

Татварын хураалт	29.7	28.7
------------------	------	------

Тайлбар: Бизнес хийхэд учирч буй саад бэрхшээл нь дунд зэрэг, хатуу чанга гэж дүгнэсэн компаниудын хувь хэмжээ. Эх сурвалж: ЕСБХБ/Дэлхийн банк, Бизнесийн орчин болон үйлдвэрийн газрын үйл ажиллагааны судалгаа (2008 он).

Авилгалын асуудал нь Монголын хувьд сорилт хэвээр байна. ЕСБХБ/Дэлхийн банкны Бизнесийн орчин болон үйлдвэрийн газрын үйл ажиллагааны судалгааны дагуу бизнес эрхлэгчдийн тал орчим нь авилгалыг бизнест хүндрэл учруулдаг гэж үзэж байна. Хамгийн сүүлд гарсан Transparency International байгууллагаас гаргасан Авилгалын талаарх төсөөллийн индексийг (CPI-2008) харвал Монгол Улс нь ТТУХН-ийн бүх орнуудтай харьцуулахад илүү сайн ажилласан хэмээн, 180 орноос 100-д бичигдсэн байна.

2.1.4 Байгаль орчны асуудлууд

Монголын байгаль орчин нь маш олон төрлийн шинж төрхтэй юм. Хойд хэсэг нь ой мод бүхий уул нуруугаас бүрдсэн ба өмнөд хэсэгт говь, тал нутаг болон намхан уул толгодтой шазар байдаг. Баруун хэсэгт цасан оройтой өндөр уулнууд ба мөсөн голууд, зүүн хэсэгт өргөн уудам тал хээр, зэрлэг бут сөөгтэй нутаг зонхилдог байна. Монгол орон нь мөхөх аюулд орсон хэмээн олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн нилээн хэдэн амьтны зүйлүүд ба дэд зүйлүүдийн сүүлийн тоо толгой амьтдыг хадгалж буй эх нутаг юм. Монголын олон төрлийн, онцгой шинж бүхий ургамалын ертөнц нь Монголын Улаан Номд ховор, эсвэл мөхөх аюулд орсон гэж бүртгэгдсэн 100 гаруй ургамалын зүйлүүдийг багтаадаг байна.

Монголын хувьд байгаль орчны тал дээр санаа зовоосон нилээн олон асуудлууд байгаа юм. Үүнд ус, ой мод ба бусад нөөцийн талаархи тодорхой мэдээлэл дутагдалтай байдаг, мөн хамгаалалтанд орсон болон мөхөх аюул тулгарсан төрөл зүйлүүдийн тоо толгой тодорхойгүй, байгалийн баялгийг зохистой байдлаар удирдах төлөвлөгөө хангалтгүй зэрэг орно. Мөн биологийн олон төрөл зүйл багассан, хууль бус хулгайн агналтаас үүдэн мөхөх эрсдэлд орсон ан амьтдад устах аюул тулгарсан, ой модны сүйтгэл болон цөлжитөөс үүдэн ан амьтны оршин тогтнох орчин доройтож байгаа билээ, Үйлдвэржилтийн үйл ажиллагаанаас үүдэн (уул уурхай, томоохон хэмжээний усан цахилгаан станцууд) гүний ус болон гадаргуйн усны урсгал өөрчлөгдөж, үгүй болсон, бэлчээрийн зохисгүй практикаас шалтгаалан цөлжилт нэмэгдэн, бэлчээрийн даац хэтэрсэн, уул уурхайн үйлдвэрлэлээс болоод хөрс элэгдэж, газар нутаг хуурайших, ус бохирдох явдал ихэссэн, хууль бус хулгайн мод бэлтгэл болон хүмүүсийн тавьсан галаас шалтгаалсан ой модны сүйрэл даамжирсан зэрэг хүндрэлүүд байна.. Үүнээс гадна усны эрэлт хэрэгцээ асар хурдтайгаар нэмэгдэж байгаа тул усны нийлүүлэлт хангалтгүй болж, усны үндсэн сав газруудад эдийн засгийн үйл ажиллагаа идэвхжсэн явдал, нүүрсээр ажилладаг эрчим хүчний станцууд болон бусад үйлдвэрлэл, мөн түүнчлэн нүүрс шатаадаг гэр хорооллын оршин суугчидтай холбоотой агаарын бохирдол, хортой болон ахуйн хог хаягдлын удирдлага хангалтгүй зэрэг асуудлууд тулгамдсан хэвээр байна.

Өвөлдөө цас их орсноос, эсвэл бэлчээрийн талбай мөсөн бүрхүүлээр хучигдсанаас болоод мал амьтан задгай бэлчээрээс тэжээгдэх боломжгүй болох явдал, зундаа хэт хуурайшилтаас үүдэх ган ба хээрийн галын аюул нэмэгддэг зэрэг байгалийн гамшгийн эрсдэл Монгол оронд өндөр байдаг.

Байгаль орчны үйл ажиллагааны үндэсний төлөвлөгөө нь Засгийн Газрын тэргүүлэх чиглэлүүдийг тогтоож байгаль орчин, байгалийн нөөцийг хадгалан хамгаалах,

байгууллагын чадавхийг нэмэгдүүлэх үйл ажиллагааны хүрээнд салбар дахь шийдвэрлэвэл зохих асуудлуудыг тодорхойлох, авагдах арга хэмжээг товлон зэрэг ажлыг багтаасан бөгөөд 2010 он хүртэлх хугацааг хамарч байгаа юм. Энэ төлөвлөгөөнд цөлжилт, ойн аж ахуй, биологийн төрөл зүйл, ус, ховор ан амьтан, ургамалын зүйлийг хадгалан хамгаалах зэрэг 25 орчим байгаль орчны үндэсний хөтөлбөрүүд орсон байна.

Байгаль орчны гол хуулиуд нь Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Ашигт малтмалын тухай хууль, Хамгаалагдсан бүсийн тухай хууль, Байгалийн нөөцийг ашиглах төлбөрийн тухай хууль, Ойн аж ахуй, Зэрлэг амьтан ургамал болон ан агнуурын тухай хууль, Газрын баялгийг хамгаалах тухай хууль, Байгаль орчинд үзүүлэх нөлөөний үнэлгээний тухай хууль болон Уул уурхайн тухай хууль зэргээс бүрдэж байна. Мөн түүнчлэн Монгол Улс нь Байгаль орчны асуудлаархи олон улсын 14 конвенци болон гэрээнд оролцдог бөгөөд үүнд Биологийн төрөл зүйн конвенци, Цаг Агаарын Өөрчлөлтийн Конвенц болон Цөлжилттэй Тэмцэх Конвенц багтдаг юм.

Байгаль орчны чиглэлийн төрийн бус байгууллагуудын хөдөлгөөнийг олон улсын хандивлагчид ихээхэн дэмждэг бөгөөд эдгээр байгууллагуудын дийлэнхи нь Улаанбаатар хотод байрладаг байна. Тэд голчлон хүмүүсийн байгаль орчны талаархи ухамсарыг хөгжүүлэх, байгаль орчныг хадгалах болон ойжуулах санаачлагууд дээр төвлөрч ажилладаг юм.

2.1.5 Нийгмийн асуудлууд

Монгол Улс нь асар уудам газар нутагтай (1.6 сая хавтгай дөрвөлжин км) мөртлөө 2.7 сая орчим хүн амтай юм. Хүн ам нь нийслэл хотдоо төвлөрдөг бөгөөд нийт хүн амын тал орчим нь Улаанбаатарт амьдардаг байна. Хот суурин газруудад бизнес хийх боломж их ба амьдралын өртөг багатай учраас сүүлийн жилүүдэд хөдөө орон нутгаас хот руу чиглэсэн шилжилт хөдөлгөөн нэмэгдэж байна. Ойрын жилүүдэд ДНБ-ий хэмжээ үлэмж өсч Монгол Улс нь доод дунд орлоготой орнуудын тоонд багтсан хэмээн хамгийн сүүлд гарсан Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын Хөгжлийг дэмжих хорооны жагсаалтанд дурдсан байна.

Хэдийгээр сүүлийн 4 жилийн хугацаанд нэг хүнд ногдох орлогын хэмжээ ойролцоогоор хоёр дахин нэмэгдсэн ч гэсэн ядуурлыг бууруулах тал дээр тун бага ахиц гарсан гэж сүүлд гарсан Өрхийн орлого, зарлагын судалгаа харуулж байна. 2002-2003 онд ядуурлын түвшин 36.1 хувь байсан бол хамгийн сүүлд явуулсан санал асуулгын үр дүнг харвал нийт хүн амын 35.2 хувь нь (930,000 хүн) амьжиргааны түвшнөөс доогуур амьдарч байна (энэ нь Мянганы Хөгжлийн Зорилтоор тодорхойлсон 2015 онд 18 хувьд хүргэх хэмжээнээс хамаагүй их байгаа юм). Мөн түүнчлэн баян, ядуугийн болон хот, хөдөөгийн орлогын ялгаа нэмэгдсэн болохыг санал асуулгын тоо баримт харуулж байна. Хот суурин газруудад ядуурлын түвшин илүүтэйгээр буурсан байхад (30.3 хувиас 26.9 хувь хүртэл) хөдөө орон нутагт энэ үзүүлэлт 43.4 хувиас 46.6 хувь хүртэл өссөн байна. Эдийн засгийн өсөлтөөс нийт хүн ам, ялангуяа хөдөө орон нутгийн ард иргэд хангалттай ашиг тус хүртэхгүй байгааг эдгээр тоо баримт харуулж байгаа юм. Засгийн Газар нь өсөлт, хөгжилд хүргэх удаан хугацааны стратеги болох Үндэсний Хөгжлийн Стратегийг 2007 онд баталсан бөгөөд ядуурлыг бууруулах явдал нь тэргүүлэх чиглэлийн асуудал хэвээр байсаар байна.

Дээр дурдсан харьцангуй өндөр байгаа ядуурлын түвшинг харгалзан Банк нь нийтийн аж ахуйн төслүүдийг хэрэгжүүлэхдээ хүмүүсийн төлбөрийн чадвартай холбоотой асуудлуудыг анхаарч үзэх шаардлагатай байна. Нийтийн аж ахуйн байгууллагууд үйл ажиллагааны зардлаа дийлэхгүй байгаа өнөө үед энэ асуудлыг зохистой хөгжлийн байр сууринаас авч үзвэл тарифыг цаашид нэмэгдүүлэх шаардлагатай байгаа нь дамжиггүй

юм. Өрхийн орлого/зарлагын 10-с илүү хувь нь цахилгаан эрчим хүчинд, мөн 10-с илүү хувь нь дулааны хөлсөнд, 5-с илүү хувь нь цэвэр, бохир усны төлбөрт зарцуулагдаж байвал тухайн өрхүүд “төлбөрийн чадваргүй” гэж Банк үздэг юм. Монголын дундаж өрхийн хувьд төлбөрийн чадвартай холбоотой асуудал байхгүй мэт боловч хамгийн ядуу өрхүүдийн хүрээнд энэ нь том бэрхшээл юм (хамгийн бага орлоготой хэсэг нь 10 хувийг эзэлж байна, Хүснэгт 2-2 үзнэ үү). Цахилгаан эрчим хүчний үнэ тарифт янз бүрийн байдлаар татаас өгч байхад (i.e. ерөнхийдөө төлбөрийн чадвартай холбоотой асуудал үгүй) дулааны болон цэвэр, бохир усны хөлс нь төлбөрийн чадварын босгыг давсан байдалтай байна. Улаанбаатар хот нь дэлхийн хамгийн хүйтэн нийслэлүүдийн нэг бөгөөд гэрт амьдарч байгаа хүмүүст зөөврийн цэвэр ус шаардлагатай байгаа юм (i.e. цоргоор гоожиж байгаа устай харьцуулахад хамаагүй үнэтэй).

Хүснэгт 2-2: Улаанбаатар хотын нийтийн аж ахуйн үйлчилгээний үнэ тариф ба хэрэглэгчдийн төлбөрийн чадварын судалгаа, 2007 оны тоо

	ЕСБХБ-с тогтоосон төлбөрийн чадварын босго	Хамгийн ядуу өрхүүд - 10%	Дундаж орлоготой өрхүүд
Цахилгаан эрчим хүч	10%	7.3%	4.6%
Халаалт	10%	15.4%	9.1%
Цэвэр/бохир ус	5%	11.8%	4.1%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хорооноос гаргасан тоон дээр үндэслэн ЕСБХБ-ны багцаа тоо.

Сүүлийн жилүүдэд боловсрол болон эрүүл мэндийн үзүүлэлтүүд сайжирч байна. Насанд хүрэгчдийн дунд бичиг үсэг мэдэх үзүүлэлт 98 хувьд хүрсэн байхад бага насны хүүхдийн (5-с доош) эндэгдлийн хэмжээ ихээхэн буурсан байна. Дэлхийн Банкнаас гаргасан Дэлхийн Хөгжлийн Үзүүлэлтүүдийн дагуу 2000 онд 5-с доош насны хүүхдийн эндэгдэл 63 (1,000 төрөлт тутамд) байсан бол 2007 онд энэ үзүүлэлт 43 болж буурсан байна. Сүүлийн хэдэн жилийн хугацаанд хүн амын дундаж наслалт бага зэргээр нэмэгдсэн байна, 2000 онд энэ нь 64 нас байсан бол 2007 онд 67 болж өссөн. Бүхэлдээ, Хүний хөгжлийн индекс⁴ нь 0.72 байгаа бөгөөд Монгол Улс нь 179 орноос 112-т жагсаж байна.

⁴ Хүний хөгжлийн индекс нь хүний хөгжлийн түвшинг илэрхийлдэг гурван төрлийн үзүүлэлтийн цогц хэмжүүр юм: урт удаан бөгөөд эрүүл энх амьдрах (дундаж наслалтаар хэмждэг), боловсрол эзэмших (насанд хүрэгчдийн бичиг үсэг тайлагдалт болон бага, дунд, дээд сургуульд элсэгчдийн тоогоор хэмждэг) болон боломжийн түвшинд амьдрах (эрчим хүчний хангамж, худалдан авах чадварын паритет, орлого зэргээр хэмждэг).

2.1.6 Ажиллах хүчний асуудлууд

Албан ёсны статистикаар ажилгүйдлийн түвшин 2008 онд 3.3 хувь байгаа гэсэн нь дутуу тооцсон үзүүлэлт бололтой. Хамгийн сүүлийн хүн амын тооллогыг үндэслэвэл ажилгүйдлийн бодит түвшин 13.1 хувьтай байх тооцоо гарч байна. Хот суурин газрууд дахь (дундажаар 18.7 хувь) ажилгүйдлийн түвшин хөдөө орон нутагтай (10.0 хувь) харьцуулахад өндөр байна. Гэвч хот суурин газруудад цалингийн түвшин харьцангуй өндөр байгаа учраас (мөн ядуурлын түвшин доогуур) бага орлоготой өрхүүд хот суурин газрууд руу нүүх хандлага хэвээр байна.

Монгол Улс нь Олон улсын хөдөлмөрийн байгууллагын бүх үндсэн конвенциудыг хүлээн зөвшөөрсөн байдаг. Энэ хуулиар хүчээр тулгасан буюу албадсан хөдөлмөрийг онцлон хориглосон байдаг бөгөөд Засгийн Газраас голчлон энэ заалтыг сахиулдаг юм. 16-с доош насны хүүхдүүдийг хөдөлмөр эрхлэхийг энэ хуулиар ерөнхийдөө хориглосон байдаг хэдий ч 14-15 настай хэн боловч эцэг эхийн зөвшөөрлийн дагуу долоо хоногт 30 хүртэлх цаг ажиллаж болдог байна. Гэвч хүүхдийн хөдөлмөрийг ашиглах явдал Монголд тохиолддог бөгөөд энэ нь мал үржүүлж амьдралаа залгуулдаг өрх гэр бүхий хөдөө орон нутагт ихэвчлэн тохиолддог байна.

Үндэсний Статистикийн Газраас хийсэн хамгийн сүүлийн тооцоогоор хөдөлмөр эрхэлж буй хүүхдийн тоо 43,158 байна (бүх хүүхдийн 6.9 хувь). Энэ үзүүлэлтийг Олон улсын хөдөлмөрийн байгууллагаас тодорхойлж байгаатай харьцуулахад хүүхдийн хөдөлмөр нь Монголын хувьд асуудал биш мэт харагдаж байна. Хүүхдүүд мал хариулах байдлаар өрх гэртээ туслах явдал, ялангуяа хөдөө орон нутагт их тохиолддог байна. Гэвч ихэнхи тохиолдолд мал хариулах ажил нь улирлын шинж чанартай (i.e. жилд хэдхэн долоо хоног) бөгөөд эцэг, эхчүүд хүүхдүүдийнхээ боловсролд анхаарал тавих хандлагатай байна. Бодит байдал дээр сургуульд хамрагдсан үзүүлэлт өндөр байгаа бөгөөд Монголын боловсролын түвшин боломжийн түвшинд байгаа юм.

2.1.7 Хүйсийн асуудлууд

Монголд бусад орнуудтай харьцуулахад хүйсийн эрх тэгш байдал харьцангуй сайн байгаа юм. Эмэгтэйчүүд Монголын эдийн засагт том үүрэг гүйцэтгэж байгаа бөгөөд нийт ажиллагсдын 51.3 хувь нь эмэгтэйчүүд байна. Эмэгтэйчүүд эрэгтэйчүүдийн адил боловсролтой байна. Ажилгүйдлийн түвшинг хүйсээр нь авч үзвэл зарчимын ямар нэгэн ялгаа алга (Хүснэгт 2-3 нарийвчлан үзнэ үү).

Хүснэгт 2-3: Монгол дахь хүйсийн ялгаа

	Эрэгтэй	Эмэгтэй
Дундаж наслалт (жилээр)	62.6	69.4
Насанд хүрэгчдийн бичиг үсэг тайлагдалт (%)	98.0	97.5
Эдийн засгийн идэвхтэй хүн ам (%)	48.6	51.4
Хөдөлмөр эрхлэлт (%)	48.7	51.3
Ажилгүйдлийн түвшин (%)	14.1	14.2
Ядуурлын хамралтын хүрээ (%)	34.8	43.8
Нэг хүнд ногдох ДНБ (ХАЧП ам доллар)	3,046	2,611

Эх сурвалж: НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, Хүний хөгжлийн тайлан, 2007 он.

Гэвч өндөр цалинтай салбарууд/албан тушаалд эмэгтэйчүүдийн төлөөлөл бага байгаа гэж бодогдож байна. Эмэгтэйчүүдийн хувьд ядуурлын түвшин их өндөр байдаг бөгөөд нэг эмэгтэй хүнд ногдох орлогын хэмжээ бага байдаг байна. Энэ нь Монголд эмэгтэйчүүдийн хувьд зарим шударга бус хандлага байдаг гэдгийг илэрхийлж байгаа юм.

2.2 Шилжилтийн үеийн эдийн засгийн хөгжил ба ололт амжилт

2.2.1 Банкны үйл ажиллагааны макро эдийн засгийн нөхцөл байдал

Шилжилтийн үйл явц эхэлснээс хойш өнгөрсөн хэдэн жилийн турш Монгол Улсын эдийн засаг нь анх удаа хүчтэй ба тогтвортой өсч таатай нөхцөлд байсан байна. Сүүлийн 3 жилийн дунджаар эдийн засаг 9 хувиар өссөн байхад нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ 2005 онд 871 ам доллар байсан бол 2008 онд 1970 ам долларт хүрсэн байна. Энэ нь цалингийн өсөлтөнд нөлөөлсөн бөгөөд хот суурин газруудад ядуурлыг багасгахад тусалсан байна. Эдийн засгийн өсөлтөд зэс ба алтны өндөр үнэ болон гадаадын шууд хөрөнгө оруулалт эерэгээр нөлөөлсөн байна. Мөн түүнчлэн барилгын болон үйлчилгээний салбаруудад эдийн засгийн огцом өсөлт явагдаж энэ нь суурь эдийн засгийн хөгжил болон мөнгөний зарцуулалтанд нөлөөлсөн байна. Дотоодын хэрэглээ болон хөрөнгө оруулалтын хэрэгцээ, шаардлага огцом нэмэгдсэн учраас банкны салбар мөн л эрчимтэй өссөн байна. Гэвч 2008 оны эхний хагас жилийн турш дэлхийн зах зээл дээр хүнсний бараа болон эрчим хүчний үнэ нэмэгдэж энэ нь эдийн засагт үзүүлэх инфляцын дарамтыг хөөрөгдсөн байна. Түүгээр ч барахгүй 2008 оны сонгуулийн ажиллагаа эхлэх үед мөнгөний зарцуулалт огцом нэмэгдсэнээр мөнгөний нийлүүлэлт хэт хөөрөгдсөн гэдэг нь тодорхой болсон. 2007 оны дундуур 6 хувь байсан инфляцын түвшин 2008 оны дунд гэхэд 30 гаруй хувьтай болж өссөн байна.⁵

Банкны салбар нь 2008 оны турш ихээхэн доройтсон бөгөөд энэ хандлага нь 2009 онд мөн үргэлжилсэн байна. Өндөр инфляци нь банкинд хадгаламж байршуулах сонирхолыг бууруулахын (бодит хүүгийн хэмжээ хасагдах г.м.) зэрэгцээ зээлийн өртгийг нэмэгдүүлдэг юм. Монголын банкны салбар гадаад санхүүжилтэнд хаалттай тул (толгой банкны санхүүжилт г.м.) санхүүгийн хоёр чухал суваг болох хадгаламж болон банк хоорондын санхүүжилт эмзэг болсон байна. Банк хоорондын итгэл суларснаас үүдэн (ялангуяа Анод банкны дампуурлын дараа) банк хоорондын гүйлгээ үлэмж багассан байна. Хадгаламж эзэмшигчид банк болон валютын төрлийг сайтар сонгодог болсон ба нийт хадгаламжийн хэмжээ буурсан байна. Үүний үр дүнд арилжааны банкуудын төлбөр түргэн гүйцэтгэх чадвар буурч эхэлсэн байна. Зээл олголтын тал дээр банкууд удаан хугацааны үүрэг хүлээхээс зайлсхийж эхэлсэн (тухайлбал барилгын санхүүжилт, орон сууцны зээл) ба одоо байгаа харилцагчид дээрээ илүү төвлөрч ажилласан байна (шинээр зээл олгохоос илүү олгогдсон зээлийн хугацааг сунгах г.м.). Нийтдээ бизнес эрхлэгчид эдийн засгийн удаашрал, валютын хувирамтгай ханш зэргийн нөлөөнд нирвэгдэн хүнд байдалд байгаа тохиолдолд банкууд нь одоогийн зээлийн өндөр хүү болон зах зээлийн эрсдлийг даах чадвартай харилцагчдыг олоход бэрх болсон байна. 2008 оны 3-р улирлаас хойш шинээр зээл олгохыг ерөнхийдөө зогсоосон байна. 2008 оны 12-р сард Монголын 4 дахь том банк болох Анод банкныг Монголбанкны мэдэлд авч байгаагаа эрх бүхий байгууллагууд зарласан байна. Банкны системийн хөрөнгийн чанар аажмаар доройтсон бөгөөд

⁵ 2009 оны 7 дугаар сар хүртэлх инфляцын түвшин өмнөх жилийн мөн үеэтэй харьцуулахад 4.9 хүртэл хувиар буурсан байна.

найдваргүй зээлийн дундаж түвшин 2009 оны 5-р сар гэхэд нийт зээлийн 11.6 хувьд (90 хоног хэтэрсэн) хүрч нэмэгдсэн байна.

Бас нэгэн таагүй өөрчлөлт нь дэлхийн зах зээл дээр түүхий эдийн үнэ огцом буурсан явдал байв. Тухайлбал, 2008 оны 7-р сард нэг тонн зэсийн үнэ 8000 гаруй ам доллар байсан бол 2009 оны 3-р сард 4000 ам доллараас доош орж буурсан юм. Энэ нь урсгал төсөв болон гадаад тооцоонд муугаар нөлөөлсөн байна. 2008 онд урсгал төсөв болон төлбөрийн тэнцлийн аль аль нь алдагдалтай байсан бөгөөд 2009 онд алдагдлын хэмжээ улам нэмэгдэнэ гэсэн хүлээлттэй байна. Валютын ханшинд ирсэн дарамтаас үүдэн Төв Банк валютын зах зээл дээр байнга интервенци хийх шаардлагатай болсон бөгөөд 2008 оны 3-р сард гадаад валютын нөөц 1 тэрбум ам доллар байсан бол 2009 оны 1-р улиралд 400 сая ам доллараас (1.5 орчим сарын импортын нөөц) доош орж ихээхэн хэмжээгээр буурсан байна. Гадаад валютын нөөцийг цаашид бууруулахаас зайлсхийж Төв Банк валютын зах зээл дээр интервенци хийхээ зогсоосон байна. Үр дүнд нь 2009 оны 1-р улирлын туршид гадаадын гол валютуудтай харьцуулахад төгрөгийн ханш огцом унасан байна (2009 оны эхний 3 сарын хугацаанд нэрлэсэн үнээсээ 20 гаруй хувиар буурсан).

Эдгээр хүндрэлийг даван туулахын тулд Засгийн Газар харьцангуй шуурхай бөгөөд тодорхой алхамууд хийсэн юм. 2008 оны 11-р сард банкны хадгаламжийг төрөөс батлан даах хуулийг Их хурлаар баталсан байна (зөвхөн хугацаатай ба хуримтлуулах хадгаламж). 2009 оны 3-р сард Засгийн Газар нь Ерөнхий сайдаар толгойлуулсан хямралтай тэмцэх тусгай зөвлөлийг байгуулсан байна. Хожим нь банкны салбар болон мөнгөний ханшийг тогтворжуулах, мөн түүнчлэн газар тариалан, эрчим хүч ба бусад дэд бүтцийг санхүүжүүлэх зорилгоор ойролцоогоор 1 тэрбум ам долларын төсөвтэй эдийн засгийг эрүүлжүүлэх, сэргээх төлөвлөгөөг Их хурал баталсан байна. Энэхүү төлөвлөгөөг Их хурлаар баталсны дараахан Засгийн Газар Олон Улсын Валютын Сангаас 229 сая ам долларын зээлийг 18 сарын хугацаатай авах тохиролцоонд хүрсэн юм. Хандивлагчдын ээлжит уулзалтын үеэр 160 сая ам долларын төсвийн дэмжлэгийг гол хандивлагчдаас үзүүлэхээр болсон байна. Тэр долоо хоногт үндэсний валютыг хамгаалах болон төгрөгөөр гүйлгээ хийх сонирхолыг нэмэгдүүлэх зорилгоор төв банк бодлогын хүүгээ 9.75 хувиас 14 хувь болгож өсгөсөн байна. Эдгээр арга хэмжээ нь сайн үр дүн үзүүлсэн юм. Ам долларын ханш 1700 хүртэл хөөрөгдөж байсан бол 1400-1450 төгрөг болж харьцангуй тогтворжсон байна. Инфляцын хэмжээ ихээхэн буурч 7-р сар хүртэлх жилийн байдлаар инфляцийн түвшин 4.9 хувь болсон байна. Гадаад валютын нөөц нэмэгдэж 2-р сард ойролцоогоор 400 сая ам доллар байсан бол 5-р сард 600 сая ам долларт хүрсэн байна (1.4 сараас 2 сарын импорт тус тус).

Улс орны эдийн засгийг сэргээх, түлхэц өгөх бас нэгэн бодит зүйл бол Оюу Толгой төсөл юм. Энэ уурхай нь дэлхийн хамгийн том зэсийн болон алтны ордуудын нэг бөгөөд шаардагдаж буй хөрөнгө оруулалтын хэмжээ нь Монгол Улсын ДНБ-ий хэмжээтэй бараг ижил юм (4 тэрбум гаруй ам доллар). Засгийн Газар нь Оюу Толгойн хөрөнгө оруулалтын гэрээг стратегийн хөрөнгө оруулагчидтай байгуулж 2009 оны 10-р сард гарын үсэг зурсан байна. Хэрэв хөрөнгө оруулалт хуваарийн дагуу хийгдвэл төсөв болон төлбөрийн тэнцэлд үзүүлэх нөлөө нь ирээдүйд тун эерэг байх юм. Мөн үүнтэй ижил томоохон хэмжээний уул уурхайн төслүүд бэлтгэлийн шатандаа байгаа бөгөөд ойрын хугацаанд бодитоор хэрэгжих боломжтой юм. Голчлон уул уурхайн салбарын хөгжил дээр тулгуурлан дунд хугацаанд эдийн засгийн хүчтэй өсөлт явагдана гэж таамаглаж байна. Урт хугацаанд бол зохистой өсөлт нь бүтцийн өөрчлөлт, шинэчлэлтээс шалтгаална, үүнд эрдэс баялгийн орлогын оновчтой удирдлага, уул уурхайн бус салбарт өрсөлдөөнийг нэмэгдүүлэх болон Монгол Улс дэлхийн эдийн засгийн салшгүй хэсэг болох үйл явц зэрэг орно.

ДНБ-д эзлэх өр төлбөрийн хэмжээ дунд зэргийн түвшинд буюу 35 хувьтай байгаа бөгөөд удаан хугацаатай, хөнгөлөлттэй учраас хүү төлбөр нь ялихгүй юм. Гэвч эрх бүхий байгууллагууд янз бүрийн орнууд болон банкуудаас хөнгөлөлттэй бус зээл авахаар хэлэлцэж байна. Их хурлаас 1.2 тэрбум хүртэлх ам долларын (ДНБ-ий 25 хувьтай тэнцэх) арилжааны зээл авах эрхийг Засгийн Газарт олгосон байна. Түүгээр ч барахгүй, Олон Улсын Вавютын Сан, Дэлхийн Банк, Азийн Хөгжлийн Банк, Японоос олгох шинэ зээлүүд болон ОХУ-с өгөхөөр яригдаж байгаа зээлүүдийг авбал өрийн хэмжээ 600 сая ам доллараас давахаар байна (ДНБ-д эзлэх гадаад өрийн түвшин 10 буюу түүнээс дээш хувиар өснө). Ийм учраас өр зээлийн хянуур удирдлага шаардлагатай хэвээр байгаа юм.

2.2.2 Шилжилтийн үеийн ололт амжилт ба шийдвэрлэгдээгүй асуудлууд

2.2.2.1 Шилжилтийн үеийн ололт амжилт

Банкны шилжилтийн үзүүлэлтүүдийн дагуу Монгол Улс нь шилжилтийн хугацаанд тууштай дэвшил гаргасан бөгөөд Шилжилтийн эхний үе шатан дахь орнуудын хүрээнд өөрчлөлтийг хамгийн хурдан хийж буй орнуудын тоонд багтаж байна (График 2-1 үзнэ үү). Үнэ болон худалдааг чөлөөлөх явц, жижиг болон дунд хэмжээний хувьчлалд ахиц дэвшил илүүтэй гарсан байна. Хувьчлалд гарсан дэвшил харьцангуй түргэн байсан бол үйлдвэрийн газрын бүтцийн өөрчлөлт, шинэчлэлт удаан явагдсан байна.

График 2-1: Монгол Улс болон Шилжилтийн эхний үе шатан дахь орнуудын шилжилтийн үзүүлэлтүүд, 2008 он



Тайлбар: Индекс нь 1-с 4+ хооронд хэлбэлздэг. 1 гэдэг нь бага хэмжээний өөрчлөлттэй, эсвэл ахицгүй, 4+ гэдэг нь хөгжилтэй орнуудын эдийн засгийн стандартуудтай ижил хэмжээнд байгааг заана. Арга зүйн нарийвчилсан тайлбаруудыг Шилжилтийн тайлан 2008-с үзнэ үү. Эх сурвалж: ЕСБХБ, Шилжилтийн тайлан 2008.

Хувийн хэвшлийн хөгжил

Монголд хувьчлалын тал дээр харьцангуй хурдан ахиц дэвшил гарсан байна. 1993 он гэхэд жижиг үйлдвэрийн газруудын ихэнхи нь хувийн эзэмшилд шилжсэн бөгөөд томоохон хэмжээний хувьчлалын ажил урагштай байна. Ийм учраас ДНБ-д хувийн хэвшлийн эзлэх хувь хэмжээ өсч 2005 он гэхэд ойролцоогоор 70 хувьд хүрсэн байна. Одоо байгаа төрийн өмчийн үйлдвэрийн газруудын дийлэнхи нь хувийн хэвшлийн сонирхолыг татахгүй байгаа, аль эсвэл хувьчлахад улс төрийн хувьд хүндрэлтэй байгаа

юм. Төрийн Өмчийн Хороо хувьчлалын шинэ стратегийг боловсруулж УИХ-д өргөн барьсан байна. Хороо нь дунд хугацаанд зарим нүүрсний уурхай, МИАТ болон эрчим хүчний салбарын компаниудыг хувьчлахаар төлөвлөсөн байна.

Үйлдвэрийн газрын бүтцийн өөрчлөлт, шинэчлэлт удаан явагдсан байна. Монгол Улс төсвийн шаардлагыг чангатгах, төрийн сангийн удирдлага болон байгууллагын засаглалыг сайжруулахад чиглэгдсэн хэд хэдэн алхмыг хийсэн байна. Компанийн засаглалыг ерөнхийдөө сул гэж үздэг байна. Энэ нь зарим талаараа компанийн мэдээллийг нээлттэй, ил тод байлгах ажиллагаа дутагдалтай болон жижиг хувьцаа эзэмшигчдийг хамгаалах шаардлагатай холбоотой юм. Хөрөнгийн биржид бүртгэлтэй олон компаниуд жилийн санхүүгийн тайлангаа нийтэд зарладаггүй, аль эсвэл хувьцаа эзэмшигчдийн хурлыг хийдэггүй байна. Хувьцаат компаниудад тавьж буй шаардлагууд нь сулхан, ёс төдий шинжтэй байна. Компаниудын дийлэнхи нь аудитын шалгалтанд хамрагдаагүй байна.

Уул уурхайн салбар

Уул уурхайн салбар нь төсвийн орлого, экспорт болон ДНБ-ий ихэнхи хэсгийг бүрдүүлдэг учраас Монголын хувьд шийдвэрлэх ач холбогдолтой салбар юм. Өсөлт хөгжлийн төлөв болон ядуурлыг намдаах явдал нь уул уурхайн салбарын хөгжлийн чиг ба далайц, мөн түүний хөгжилд Монголын хувийн хэвшлийн зүгээс оруулах хувь нэмрээс ихээхэн шалтгаалах юм. Уул уурхайн салбарын шилжилт нь холимог бүтэцтэй байна. Нүүрс болон зэс үйлдвэрлэгчдийн дийлэнхи нь төрийн эзэмшилд үлдсэн. Зарим төрийн өмчит нүүрсний компаниудад халаалт болон дулааны цахилгаан станцуудын хэрэгцээнд зориулан зах зээлийн үнээс хамаагүй доогуур үнээр нүүрс нийлүүлэхийг үүрэг болгосон нь байнга алдагдалтай ажиллах нөхцлийг бүрдүүлж байна. Гэхдээ Засгийн Газар нь төрийн өмчит нүүрсний компаниудыг ойрын ирээдүйд хувьчлах хүсэлтэй байгаа юм. Төрийн эзэмшилд байдаг зэс үйлдвэрлэгч компани нь Монголын хамгийн том татвар төлөгч боловч орлогоо үлдээх эрхгүй учраас шаардлагатай хөрөнгө оруулалтаа өөрийн ашгаасаа санхүүжүүлэх боломжгүй юм. Хувиараа алт болон нүүрс олборлодог олон тооны хүмүүс байдаг бөгөөд тэд ихэвчлэн албан ёсны лиценз, зөвшөөрөлгүй ажилладаг байна. Гэвч эрх бүхий байгууллагууд нь эдгээр хүмүүсийн үйл ажиллагааг зохицуулж чадахгүй байгаа юм.

Одоохондоо гэнэтийн ашгийн 68 хувийн татвар үйлчилж байгаа учраас зэс болон алтанд хамаарах татварын дарамт өндөр байгаа юм. Бусад ашигт малтмалууд (үүнд нүүрс орно) энэ татварт хамрагдахгүй байгаа. Гэхдээ 2009 оны 8 дугаар сард парламент энэ маргаантай хуулийг хүчингүй болгосон бөгөөд энэ нь 2011 оны 1 дүгээр сараас эхлэн үйлчилж эхлэх юм. Ашигт малтмалын хуулийн дагуу Монгол Улсын нутаг дэвсгэр дээр олдсон стратегийн орд газрын 51 хүртэл хувийг (хэрэв хувийн хөрөнгө оруулалтаар ашиглавал 34 хувийг) төр эзэмших эрхтэй юм. Уул уурхайн салбарт ажиллаж буй гадаадын хөрөнгө оруулагчдын хувьд эдгээр хэмжээ нь тодорхой бус байдлыг нэмэгдүүлэхийн хамт бизнес эрхлэх бодит зардлыг өсгөсөн байна. 2009 оны 10 дугаар сард Оюу Толгойн зэс болон алтны ордыг ашиглах зорилгоор нэг талаас Засгийн Газар, нөгөө талаас Канад ба Их Британид байрладаг уул уурхайн компаниуд болох Айвэнхоу Майнс болон Рио Тинто нар хөрөнгө оруулалтын гэрээ байгуулсан байна. Төслийн дагуу асар их хэмжээний хөрөнгө оруулалт орж ирэх бөгөөд амжилттай болсон нөхцөлд энэ нь бараг одоогийн ДНБ-ий хэмжээтэй (4 тэрбум гаруй ам доллар) ижил байх юм. Энэ төсөл нь Монгол Улсын бусад томоохон хэмжээний уул уурхайн төслүүдийн эхлэлийг тавьж өгөх ёстой юм.

2005 онд Засгийн Газар нь Олборлох Үйлдвэрлэлийн Ил тод байдлын Санаачлагыг хүлээн авсан байна. Газрын тос, байгалийн хий болон уул уурхайгаас олж буй Засгийн Газрын орлого болон компанийн төлбөрүүдийг бүрэн хэвлэн нийтлэх, баталгаажуулах замаар байгалийн нөөцөөр баялаг орнуудын засаглалыг сайжруулахад энэ хөтөлбөр дэмжлэг үзүүлдэг юм. Гэвч хөтөлбөрийн биелэлт Засгийн Газар болон компанийн аль аль тал дээр удааширсан хэвээр байна.

Санхүүгийн салбарын хөгжил

Сүүлийн жилүүдэд банкны салбар нь үлэмж хэмжээгээр өссөн байна. Одоогийн байдлаар 15 арилжааны банк ажиллаж байгаа бөгөөд бүгд хувийн хэвшлийн банкууд юм (одоогоор Төв Банкны мэдэлд байгаа Анод банкыг хасаад). Энэ салбарт гадаадын хөрөнгө оруулагчдын оролцоо хангалттай байгаа юм (ОУСБ-ууд болон хандивлагчдыг оролцуулаад). Өнгөрсөн хэдэн жилийн хугацаанд санхүүгийн зуучлал огцом хөгжсөн байна. 2008 онд Засгийн Газар нь хувь хүмүүсийн авсан зээлтэй холбоотой мэдээллийг цуглуулах, хангах үүрэг бүхий Зээлийн Мэдээллийн Товчоо байгуулахыг зөвшөөрсөн байна. Барилгын салбарын 2007-2008 оны огцом өсөлтийн үеэр орон сууцны урт хугацаатай зээл буюу моргейж-ийн бүтээгдэхүүнүүд бий болсон бөгөөд эрх бүхий байгууллагууд арилжааны банкуудтай хамтран моргейж-ийн хоёрдогч зах зээлийг хөгжүүлэх оролдлого хийсэн боловч амжилтгүй болсон байна.

Банкуудын хөрөнгийн чадварыг нэмэгдүүлэх, зээл олгох үйл ажиллагааг сэргээх, компаний засаглал, Төв Банкны хяналтыг сайжруулах болон банкуудыг нэгтгэх зэрэг нухацтай сорилтууд банкны салбарын өмнө тулгарч байна. Олон банкны үйл ажиллагаанд нөлөөлж буй шийдэгдээгүй байгаа зарим системийн асуудлууд нь банк хоорондын зах зээл хувирамтгай байгаа нөхцөлд хадгаламж өсөхөд сөргөөр нөлөөлж байгаа юм. 2009 оны эхний хагаст цөөхөн банкууд шинээр зээл олгосон бөгөөд зээлийн хүү нь өндөр, хугацаа богино, олдоц ховор байсан байна. Цаашид, Банкны хууль болон Төв Банкны хуулийг чангаруулах замаар Төв Банкны зүгээс тавих хяналтыг нэмэгдүүлэх шаардлагатай байгаа юм. Эдгээр хуулиудыг Их хурлаар 2009 оны намар хэлэлцэхээр хүлээгдэж байна. Хамгийн том гурван банк нь нийт хадгаламжийн 70 хувийг бүрдүүлж байгаа нөхцөлд жижиг банкуудын орон зай хумигдаж байгаа тул тэдгээрийг нэгтгэх шаардлагатай байгаа юм. Цөөн тооны банк байвал Төв Банкны хараа хяналтыг сайжруулахад дөхөм болох юм.

Банк бус санхүүгийн систем нь сайн хөгжөөгүй хэвээр байна. Хараат бус зохицуулагч болох Санхүүгийн Зохицуулах Хороог 2006 онд байгуулснаас хойш шаардлагатай хөрөнгийн доод хэмжээг нэмэгдүүлсэн байна. Үүний үр дүнд банк бус санхүүгийн зуучлагчдын тоо эрс буурсан юм. Гэсэн хэдий ч эдгээр байгууллагуудыг цаашид нэгтгэх шаардлагатай байна. Даатгалын 20 орчим компани ажиллаж байгаа боловч зах зээл дээр хэт өндөр хувь эзэмшдэг хуучны улсын монополь байдал хэвээр байгаа бөгөөд зах зээл дээр зөвхөн цөөн тооны даатгалын бүтээгдэхүүнүүд байна. Хувийн санхүүжилттэй тэтгэвэрийн систем хараахан үүсээгүй байна. Монголд хязгаарлагдмал тооны лизингийн компаниуд болон хөрөнгө оруулалтын сангууд ажиллаж байна. Хөрөнгийн зах зээл нь бүрэн хэмжээгээр ажиллаж чадахгүй байгаа боловч сүүлийн жилүүдэд энэ зах зээл дээр эргэлдэж буй хөрөнгийн хэмжээ ихээхэн нэмэгдсэн байна. Тухайлбал, энэ нь 2006 онд 112 сая ам доллар байсан бол 2008 онд 723 сая ам долларт хүрч өссөн байна (ДНБ-ий 3.5 хувиас 16 хувь хүртэл тус тус). 2007-2008 онуудад анхны нийтийн арилжааны (IPOs) тоо нэмэгдсэн байна. Хөрөнгийн бирж дээр харьцангуй олон компаниуд бүртгэгдсэн байдаг боловч арилжааны хэмжээ бага хэвээр байна.

Дэд бүтцийн өөрчлөлт, шинэчлэлт

Дэд бүтцийг хөгжүүлэхэд үлэмж хэмжээний хөрөнгө оруулалт шаардлагатай байгаа, гэвч энэ нь төрийн хязгаарлагдмал нөөц болон хөнгөлөлттэй бус нөхцлөөр санхүүжилт авах боломж хомс зэрэг нөхцөл байдлаас үүдэлтэй байна. Хувийн хэвшлийн оролцоо хязгаарлагдмал хэвээр байхад дэд бүтэц дахь хөрөнгийн дийлэнхи хэсэг нь төрийн эзэмшилд хэвээр байна. Нийтийн аж ахуйн байгууллагуудад бүтцийн өөрчлөлт хийж арилжааны хэлбэрт оруулах шаардлагатай байна. Сүүлийн хэдэн жилийн хугацаанд зарим салбарын тарифууд ихээхэн нэмэгдсэн ч гэсэн цаашид тарифын өөрчлөлт хийх орон зай байсаар л байна.

Монголын Төмөр Замыг 50:50 хувийн үндсэн дээр Монголын Засгийн Газар болон Оросын Төмөр Зам эзэмшдэг бөгөөд энэ нь хувьчлалын асуудал биш юм. Иргэний нисэхийн салбарт, бүх онгоцны нисэх буудлууд болон олон улсын нислэгийн компанийг төр эзэмшиж ажиллуулдаг бол дотоодын нислэгүүдийг цөөн тооны жижиг хувийн компаниуд гүйцэтгэдэг байна. Эрчим хүчний салбарт, цахилгаан станцууд болон эрчим хүч түгээх сүлжээг монополь байдлаас гаргаж зохион байгуулалтын өөрчлөлт хийсэн боловч дараагийн хувьчлалын төлөвлөгөөг түр зогсоогоод байна. Цахилгаан эрчим хүчний тарифууд нь өртөг, зардлаа нөхөх хэмжээнээс доогуур байгаа бөгөөд компаниуд их хэмжээний өртэй байгаа тул шинээр хөрөнгө оруулалт хийхэд хүндрэл учруулж байгаа юм.

Харилцаа холбооны салбарт, 2007 онд суурин шугам сүлжээний компанийг бүтцийн өөрчлөлтөд оруулж сүлжээний компани болон үйлчилгээний компанийг (40 хувийг нь Корея Телеком эзэмшдэг) байгуулсан байна. Эдгээр компаниудыг цаашид хувьчлах хэлэлцээрүүд одоогоор явагдаж байна. Үүрэн холбооны зах зээл нь хувийн хэвшлийн оролцоотой учраас хамгийн их хөгжсөн юм. Гар утасны зах зээл дээрхи өрсөлдөөн ихээр нэмэгдсэн байна. Үүрэн холбооны хамгийн том оператор болох Мобиком нь нэг хэсэг хугацаанд зах зээл дээр ноёрхож байсан боловч шинэ операторууд лицензи авч үйл ажиллагаа нь сүүлийн жилүүдэд өссөнөөр Мобикомын зах зээл дээр эзлэх хувь хэмжээ 2008 он гэхэд 60 орчим хувь болж буурсан байна. Өрсөлдөөн нэмэгдсэний үр дүнд тарифууд их хэмжээгээр буурсан бөгөөд Монголын үүрэн холбооны үнэ бүс нутгийн хэмжээнд хамгийн доогуурт орж байна.

Салбарын зохицуулалтын тал дээр, бодлого боловсруулах үүрэг, үйл ажиллагаанаас зохицуулах үүргийг тусгаарлан салгасан байна. Сүүлийн жилүүдэд нилээн хэдэн хараат бус зохицуулагчид байгуулагдсан ба үүнд харилцаа холбооны зохицуулагчаар Харилцаа Холбооны Зохицуулах Хороо, эрчим хүчний зохицуулагчаар Эрчим Хүчний Зохицуулах Газар болон төмөр замын салбарын зохицуулагчаар Төмөр Замын Удирдах Газар тус тус ажиллаж байна. Гэхдээ эдгээр газруудын үйл ажиллагаа нь хөгжлийн эхний шатандаа явж байгаа бөгөөд зохицуулах хүчин чадал, үр ашгийг цаашид сайжруулах шаардлагатай байгаа юм. Бусад орны нэгэн адил, Монголд тарифын өөрчлөлт хийх нь улс төрийн хувьд эмзэг асуудал бөгөөд биелүүлэхэд хүндрэлтэй байдаг. Төмөр зам (ачаа тээвэр) болон харилцаа холбооны байгууллагууд ашигтай ажиллаж байхад эрчим хүч ба усны ихэнхи компаниуд болон бусад нийтийн аж ахуйн компаниуд орлогоороо зардлаа нөхөх хэмжээнд л үйл ажиллагаагаа явуулж байна. Салбарын санхүүгийн удирдлага болон зохицуулалтын тогтолцоо байгуулах нь Монголд нэн шаардлагатай байгаа дэд бүтцийг хөгжүүлэхэд чухал ач холбогдолтой юм.

2.2.2.2 Шилжилтийн үеийн сорилтууд

Монгол Улсын хувьд дараагийн стратегийн хугацаанд дор дурдсан таван чиглэл нь шилжилтийн үндсэн сорилтууд болно:

- **Үйлдвэрийн газрын бүтцийн өөрчлөлтийг дэмжих ба компаний засаглалыг сайжруулах:** Хувьчлалын процесс харьцангуй хурдан явагдсан хэдий ч үйлдвэрийн газрын бүтцийн өөрчлөлт болон компаний засаглалын стандартыг сайжруулах ажил хоцорч байна. Бүтээмжийг сайжруулахын тулд томоохон бүтцийн өөрчлөлт хийх шаардлагатай байна. Түүгээр ч барахгүй, ил тод байдал (үүнд нягтлан бодох бүртгэлийн стандартууд орно) болон компаний засаглалыг цаашид боловсронгуй болгох шаардлагатай байна.
- **Санхүүгийн системг нэгтгэх ба бэхжүүлэх:** Хэдийгээр банкны салбар нь сүүлийн жилүүдэд ихээхэн өссөн ч гэсэн хямралаас үүдэн одоо энэ салбарт хэд хэдэн томоохон сорилтууд тулгарч байгаа бөгөөд эдгээр нь олон банкуудад нөлөөлж мэдэх юм. Нөгөө талаар Монголын эрх бүхий байгууллагууд энэ боломжийг ашиглаад илүү зохистой, бат бөх санхүүгийн системг бий болгох нь чухал юм. Хөрөнгийн зах зээл нь хөгжлийн эхэн шатанд байгаа бөгөөд түүнийг бүх талаар нь, ялангуяа ил тод байдал, засаглал болон зохицуулалттай холбоотой асуудлын хүрээнд эрчимтэй хөгжүүлэх шаардлагатай байна.
- **Эрдэс баялагийг удирдах ба эдийн засгийг олон төрлийн суурьтай болгох:** Ойрын ирээдүйд хэрэгжих хэд хэдэн томоохон хэмжээний уул уурхайн төслүүд хүлээгдэж байгаа өнөө үед Засгийн Газар нь эрдэс баялаг болон энэхүү салбараас орж ирэх орлогыг ухаалгаар удирдаж мэдээллийг ил тод байлгах шаардлагатай байна. 2009 оны 10 дугаар сард Оюу Толгойн хөрөнгө оруулалтын гэрээнд гарын үсэг зурснаар (мөн Таван Толгойн нүүрсний уурхайн төслийн гэрээ хүлээгдэж буй) энэ асуудал нь гарцаагүй болж байгаа бөгөөд аль аль нь ирэх жилүүдэд бодит хөрөнгө оруулалтыг Монгол руу татах юм. Уул уурхайн нөөц нь хязгаарлагдмал байдаг учраас эрх бүхий байгууллагууд уул уурхайн салбарыг урт хугацаанд, зохистой байдлаар хөгжүүлэх төлөвлөгөө гаргах ёстой юм (түүхий эдийн үнэ огцом өсч буурах мөчлөгтэй байдаг тул). Мөн уул уурхайтай холбоотой орлогоос эдийн засаг ашиг тусаа хүртэж байх хугацаанд эдийн засгийн сууриа олон төрөлжүүлэх, гүнзгийрүүлэх шаардлагатай байгаа юм.
- **Бизнесийн орчныг сайжруулах:** Монгол дахь бизнесийн орчныг ТТУХН-ийн орнуудын шилжилтийн эдийн засагтай харьцуулахад сайн гэж үздэг. Гэсэн хэдий ч гадаадын хөрөнгө оруулагчид болон дотоодын хувийн хэвшлээс эдийн засагт үзүүлж буй ач холбогдлыг дурдахын хамт бизнесийн орчныг цаашид улам сайжруулах хэрэгтэй юм. Уул уурхайн салбарт, бараа түүхий эдийн үнэ доогуур байгаа нөхцөлд Засгийн Газар нь гадаад орны стратегийн хөрөнгө оруулагчдад таатай нөхцлийг бүрдүүлж Монголд хөрөнгө оруулах сонирхолыг татахуйц бизнесийн орчныг бий болгох шаардлагатай байна.
- **Нийтийн үйлчилгээний дэд бүтэц дахь хувийн хэвшлийн оролцоо болон арилжааны шинж чанарыг нэмэгдүүлэхийг дэмжих:** Зах зээл рүү чиглэсэн өөрчлөлт, шинэчлэлт дутагдалтай байгаагийн зэрэгцээ үлдэж буй улсын үйлдвэрийн газруудад бүтцийн өөрчлөлт хийх, арилжааны хэлбэрт оруулах шаардлагатай байна. Тарифуудыг өртгөө нөхөх хэмжээнд хүртэл нэмэгдүүлж зохицуулах агентлагуудын зүгээс үр нөлөөтэй хяналт тавих ёстой юм. Цаашид орлого бүрдүүлэлтийг сайжруулахын хамт зайлшгүй шаардлагатай нөхцөлд татаас өгөх шударга ба ил тод системг бий болгох шаардлагатай байна. Дэд бүтцийн салбарт асар их хэмжээний хөрөнгө оруулалт шаардлагатай байгаа боловч хөрөнгө оруулалтын зардлыг хэрэглэгчдийн төлбөрөөр нөхөх боломжтой юм. Үйлчилгээг

хүргэх өртөг, зардал өндөртэй, мөн ихэнхи хүмүүс нь ядуу амьдралтай гэр хорооллын хувьд бол энэ нь үнэхээр хүндрэлтэй асуудал юм. Монгол нь сэргээгдэх эрчим хүчний хувьд, ялангуяа салхины далайц хэмжээ, нөөцөөрөө их боломжтой орон юм. Гэхдээ эдгээр нөөцийн ашиглалтыг нэмэгдүүлэх зорилгоор дэмжих үүрэгтэй зохицуулах нэгж байгуулах шаардлагатай байна.

2.3 Хөрөнгө санхүүгийн хүртээмж

Сүүлийн хорин жилийн хугацаанд дэд бүтцийн салбарт хөрөнгө оруулах асуудал орхигдсон байна. Үүний уршгаар зохистой зам тээврийн сүлжээ болон бусад зайлшгүй хэрэгтэй дэд бүтцийг байгуулахад үлэмж хэмжээний хөрөнгө оруулалт шаардлагатай болсон байна. Төрийн хөрөнгө оруулалт нь голчлон хоёр талын хандивлагчид болон олон улсын санхүүгийн байгууллагуудын албан ёсны санхүүжилтээс хамааралтай хэвээр байна. Өнгөрсөн хугацаанд Монгол Улс нь Зөвлөлдөх уулзалтуудыг хэд хэдэн удаа амжилттай зохион байгуулсан бөгөөд хандивлагчдын нийгэмлэг нь Монгол улсын хөгжлийг дэмжих амлалт авсан байна. Монгол Улс нь хөгжлийн албан ёсны тусламж байдлаар жил бүр 200-250 сая ам доллар (ДНБ-ий 5 гаруй хувь) авдаг байна. Монгол Улс нь гадаад валютын зээлийн түвшнээр Фитч байгууллагаас В/хасах, Стандарт ба Пүэрс-ээс ВВ-/хасах болон Мууди-гаас В1/сөрөг болох магадлалтай үнэлгээг тус тус авсан байна. Гэвч Засгийн Газар нь олон улсын бондууд хараахан гаргаагүй байна.

Хүснэгт 2-4: Хөрөнгө оруулалтын болон санхүүжилтын үзүүлэлтүүд

	2004	2005	2006	2007	2008 (е)
Үндсэн хөрөнгийн нийт хуримтлал					
Үндсэн хөрөнгийн нийт бүрдүүлэлт, сая ам доллар	472	666	1,029	1,229	2,077
Төрийн мэдлийн үндсэн хөрөнгийн бүрдүүлэлт, сая ам доллар	87	74	151	394	493
ДНБ-д эзлэх хувь, %	4.8	3.2	4.8	10.0	9.4
Хувийн хэвшлийн үндсэн хөрөнгийн бүрдүүлэлт, сая ам доллар	386	593	878	834	1,584
ДНБ-д эзлэх хувь, %	21.2	25.7	27.9	21.2	30.1
Хөрөнгийн урсгалууд					
Гадаадын шууд цэвэр хөрөнгө оруулалт, сая ам доллар	129	258	290	360	682
ДНБ-д эзлэх хувь, %	7.1	11.2	9.2	9.2	13.0
Цэвэр хөрөнгө оруулалтын багц, сая ам доллар	-53	1	1	75	-13
ДНБ-д эзлэх хувь, %	-2.9	0.1	0.0	1.9	-0.2
Албан ёсны хөрөнгийн урсгал, сая ам доллар	103	60	46	47	14
	8.5	4.9	4.0	4.0	1.1
Хувийн хэвшлийн гүйлгээ, сая ам доллар	146	134	77	84	100
ДНБ-д эзлэх хувь, %	8.0	5.8	2.4	2.1	1.9
Дотоодын зээл, сая ам доллар	549	740	718	1,234	1,420
ДНБ-д эзлэх хувь, %	30.2	32.1	22.8	31.4	27.0

Эх сурвалж: Олон улсын валютын сан, Дэлхийн эдийн засгийн тойм, 2009 оны 4 дүгээр сар.

Хувийн хэвшилд мөн бодитой хөрөнгө оруулалт шаардлагатай байна. Энэ нь ялангуяа одоо байгаа ордуудын дийлэнхи нь ашиглагдаж амжаагүй байгаа байгалийн нөөцийн салбарт хамаатай юм. Сүүлийн жилүүдэд гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээ жил бүр өсч ирсэн бөгөөд дийлэнхи хэсэг нь уул уурхайн салбарт орсон байна.

Худалдаа, барилга, аялал жуулчлал, мал аж ахуйн үйлдвэрлэл зэрэг салбарууд мөн л өсч байгаа боловч дунд болон удаан хугацааны санхүүжилт авах боломж нь харьцангуй хязгаарлагдмал байна. Дотоодын ихэнхи зээлүүд бага хугацаатай бөгөөд өндөр хүүтэй хэвээр байгаа юм. Алслагдсан бүс нутагт байрладаг бизнесийн газрууд болон бичил ба жижиг үйлдвэрийн газруудын хувьд банкнаас зээл авахад хүндрэл учирдаг байна. Монголын Хөрөнгийн бирж нь хувьцаа болон бондын аль алиныг нь арилжаалдаг боловч зах зээлийн хөрвөх чадвар тун хязгаарлагдмал байдаг ба компаниудад шаардлагатай нэмэлт хөрөнгийг босгох хөшүүрэг байдлаар ажиллаж чадахгүй байгаа юм. Түүхэнд ганц удаа олон улсын бонд гаргасан боловч дараах оролдлогууд нь ихэвчлэн бүтэлгүйтсэн бөгөөд цаашид шинэ бонд гаргах боломж хязгаарлагдмал байна.

3. Стратегийн үндсэн чиглэл

3.1 Банкны тэргүүлэх чиглэл

Хувийн хэвшлийн хөгжлийн санхүүжилт

Хувийн хэвшлийг хөгжүүлэх явдал Банкны стратегийн хамгийн чухал асуудлуудын нэг мөн. Банктай хамтран ажиллаж буй улс орнуудад дэлхий нийтээр эдийн засгийн хямралтай байгаа болон санхүүжилтийн бусад эх үүсвэрүүд бараг үгүй болчихоод байгаа өнөөгийн нөхцөлд санхүүжилт шаардлагатай болбол хэрхэн ажиллах бизнесийн мөн чанар, бизнесийн байгууллагын ил тод засаглалын шилдэг загваруудыг харуулж дэмжин ажиллах болно. Банк нь Монгол Улсын эдийн засгийн салбаруудыг төрөлжүүлэх, ажлын байр буй болгох, ядуурлыг бууруулахад зохих хувь нэмрээ оруулах хүнсний үйлдвэрлэл, ноолуур, нэхмэл, зочид буудал, аялал жуулчлал, үл хөдлөх хөрөнгө, үйлчилгээ гэх мэт чухал салбаруудад өөрийн хөрөнгийн шууд санхүүжилт хийх боломжийг судлана. Банк хүчтэй, нэр хүндтэй олон улсын хөрөнгө оруулагчдын анхаарлыг татахыг зорьж ажиллах болно.

Монгол Улсыг Шилжилтийн Эхний Үе Шатан дахь Орнуудыг Дэмжих Санаачилгад (ETC Initiative) хамруулснаар Дунд Хэмжээний Хамтран Санхүүжүүлэх Хэрэгсэлд (MCFF) нэмж оруулах гэх мэт дундаас том хэмжээний аж ахуйн нэгжийг тусгай төсөл хөтөлбөрт бүрэн утгаар нь хамруулах боломж олгож байгаа юм. ЖДҮ-ийн хөгжлийг дэмжих үйл ажиллагааныхаа хүрээнд, Банк нь Удирдлагын Өөрчлөн Байгуулах Хөтөлбөр (ТАМ) болон саяхан боловсруулсан Бизнесийн Зөвлөгөө Өгөх Үйлчилгээ Хөтөлбөр (BAS)-ийн туршлагад тулгуурлан ажиллана.

Банкны зүгээс бичил бизнесийг тусгайлан анхаарч, дотоодын хамтрагч банкуудаас олгож буй бичил, жижиг бизнесийн зээлийн шугамыг бэхжүүлэн хөгжүүлэх, нэн ялангуяа илүү алслагдсан бүс нутагт хийгдэж буй үйл ажиллагааг хөгжүүлэх нь нэн тэргүүний зорилт байх болно.

Санхүүгийн салбарыг бэхжүүлэх, нэгтгэх үйл ажиллагааг дэмжих

Банкны салбарт тулгараад буй бэрхшээлтэй асуудлууд болон Монгол Банкнаас бүх оролцогч талуудыг бүхий л хүчин чармайлтаа дайчлан ажиллах, ялангуяа Монгол Банкны удирдлага, хяналт шалгалтын тухай хууль тогтоомжийг бэхжүүлэхийг шаардаж байна. Банкны зүгээс энэ чиглэлээр Монгол Банктай бодлогын яриа хэлэлцүүлэг өрнүүлэх, техникийн туслалцаа үзүүлэх замаар туслахаар бэлтгэж байна. Улмаар зохих нөхцөл бүрдсэн тохиолдолд сонгосон банкуудын хөрөнгийн чадварыг нэмэгдүүлэхийг бэхжүүлэх, шинээр байгуулагдсан банкуудтай хувь эзэмших, зээлийн шугамын болон хамтран санхүүжилт хийх хэрэгслийн хэлбэрээр хувь эзэмших замаар банкны харилцааг буй болгох замаар санхүүгийн салбарт хэрэгжүүлэх үйл ажиллагаагаа эрчимжүүлэхийг зорино.

Банкны бас нэгэн стратегийн зорилго нь салбарын нэгдэл нягтралыг хөхиүлэн дэмжих, Банкны санхүүжүүлж буй буюу Банкнаас санхүүжилт авах болзлыг хангасан бие даасан арилжааны банктай байгууллагыг бүрэлдүүлэн буй болгох явцыг бэхжүүлэхэд голлон анхаарч ажиллана. Тодорхой сонгосон тохиолдолд шинээр капитал хөрөнгөөр хангах буюу урт хугацаатай санхүүжилт хийхээс гадна Банк санхүүгийн салбар эсвэл бие даасан арилжааны банкуудын байгууллагыг бүрэлдүүлэн буй болгох тогтолцоонд шийдвэрлэх шаардлагатай асуудлыг шийдэхэд туслахад чиглэсэн техникийн туслалцааг

үзүүлнэ. Банкны компанийн засаглалын дүрмийг нарийн нягт баримталдаг арилжааны банкуудтай Банк хамтран ажиллаж тодорхой санал, төсөл нэг бүрээр тухайн арилжааны банкуудыг хөрөнгийн чадварыг хангалттай хэмжээнд байлгахад чиглэсэн тусламжийг үзүүлэхээр санал болгож ажиллана.

Банк нь Худалдааг дэмжих хөтөлбөрийг (Trade Facilitation Programme) үргэлжлүүлэн идэвхтэй дэмжиж арилжааны банкууд болон банк бус байгууллагуудад, ялангуяа орон нутагт зээлийн шугам нээх замаар, бичил болон жижиг бизнесүүдийн санхүүжилтийг нэмэгдүүлнэ.

Банкны зүгээс банк бус бичил санхүүгийн байгууллагууд, лизинг, даатгал, тэтгэврийн байгууллагууд гэх мэт банк бус санхүүгийн байгууллагуудыг хөгжүүлэхийг дэмжин ажиллана. Үүний зэрэгцээ эрчим хүчний эцсийн хэрэглээ, бага оврын тогтвортой эрчим хүчний салбар тухайлбал эрчим хүчний үр ашиг, сэргээгдэх эрчим хүчний зээлийн шугам зэрэг санхүүгийн шинэ хэлбэрүүдийг мөн дэмжих болно. Банкнаас Санхүүгийн Зохицуулах Хороотой бодлогын яриа хэлэлцүүлэг өрнүүлэх, зохицуулах тогтолцоо, хяналт шалгалтын чадавхыг боловсронгуй болгох явцыг дэмжиж туслах, компанийн засаглал, санхүүгийн тайлагнал, мэдээлэх явдлыг сайжруулахад хувь нэмрээ оруулах замаар хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэхэд бодит дэмжлэг үзүүлж ажиллана.

Байгалийн баялгийн салбарын тогтвортой хөгжил

Банк нь уул уурхайн болон газрын тосны салбарт зээлийн санхүүжилт болон шууд хөрөнгө оруулалтын санхүүжилт хийн хувийн хэвшилд оролцох өргөн боломжтой төдийгүй анхнаасаа тус салбарт хувийн хэвшлийн оролцоог дэмжих шилжилтийн үеийн нөлөөлөл эерэг чиг хандлагатай байх боломжийг тодорхойлсон байна. Дотоодын болон олон улсын хувийн хэвшлийн уул уурхайн салбарыг хөгжүүлэх, салбарын өсөлтийг дэмжих үйл ажиллагаагаа Банк үргэлжлүүлэх болно. Стратегийн томоохон ордуудад хувийн хэвшлийн салбарыг хөгжүүлэх явдлыг дэмжихэд Банк идэвхтэй оролцоно. Хэдийгээр дэлхийн зах зээл дээр бүтээгдэхүүний одоогийн үнэ ханш доогуур, цаашдаа ч тодорхой хугацаанд доогуур байх чиг хандлагатай ч стратегийн томоохон ордод төр илүү оролцож, цаашид эзэмших эрх давуутай байх зорилго, сонирхолтой байгаа нь тодорхой. Монгол Улсын эрдэс баялгийг экспортлоход тулгамдаж буй хүндрэлүүдийг шийдэх, үүнд одоогийн экспортын гарцын үйл ажиллагааг сайжруулах, шинээр экспортын гарцуудыг нээхийг Банкны зүгээс дэмжинэ.

Монголын Засгийн Газар болон Рио Тинто/Айванхоу Майнс дэлхийн хамгийн том зэсийн ордуудын нэг болох Оюу Толгойн хөрөнгө оруулалтын гэрээнд (үүнтэй ижил хэлбэрийн хөрөнгө оруулалтын гэрээг Таван толгойн нүүрсний ордыг ашиглах хоёр ба түүнээс дээш компанитай байгуулах дүгнэлт гараад байгаа) гарын үсэг зурсантай холбогдуулан 2009 сарын 10 сард болох бөгөөд Монгол Улсын ирээдүйд чухал байр суурь эзэлж байгаа уул уурхайн салбарын төсөл хөтөлбөрийг дэмжих санхүүгийн боломж бололцоог ЕСБХБ идэвхтэй судална.

Эрдэс баялагийг олборлоход цахилгааны эрэлт хэрэгцээ, хангалт асар их шаардлагатай байдаг учраас Банк Монгол Улсын эрчим хүчний дэд бүтцийг шинэчлэх ялангуяа Монголын сэргээгдэх эрчим хүчний нөөцийг буй болгох, ашиглах талаар дэмжиж ажиллана.

Үндсэн дэд бүтцийн хөгжлийг дэмжих

Дэд бүтэц дэх хөрөнгө оруулалтын хэрэгцээ шаардлага асар их боловч улсын төсвийн хөрөнгө хязгаарлагдмал, концепцын бус нөхцлөөр зээл авах чадваргүй зэргээс хязгаарлагддаг юм. Дээрх нөхцөл байдлыг харгалзан, Банк нь сэргээгдэх эрчим хүч, харилцаа холбоо, иргэний агаарын тээвэр гэх мэт хувийн хэвшлийн төслүүдийг санхүүжүүлэх боломжийг судалж үзээд байна. Иймд Банкны зүгээс зээлийн эргэн төлөлт хийх чадвартай ивээн тэтгэгч бүхий тодорхой сонгогдсон төслүүдийг хэрэгжүүлэхэд анхаарч ажиллаж байгаа хувийн хэвшлийн санал санаачилгыг нэн тэргүүнд дэмжиж ажиллана. Төр, Хувийн Хэвшлийн Түншлэлийн асуудал хариуцсан байгууллагын тогтолцоо төдийлөн сайн боловсруулагдаагүй боловч (байгууллага үүсгэн байгуулах гэх мэт) боломж олгосон нөхцөлд Банк аливаа санал санаачилгыг дэмжихэд ямагт бэлэн байх болно. Банк нь Монголд нүүрс төрөгчийн эрчимжилтийн түвшин өндөр, эрчим хүчний үр ашиггүй байгаа явдлыг бууруулахад чиглэгдсэн тодорхой төслүүдийг онцгойлон анхаарч ажиллана.

Банк улсын салбарт санхүүгийн хязгаарлагдмал боломжийн хүрээнд сонголт хийн туслалцаа үзүүлж ажиллана. Монгол Улс удахгүй бага орлоготой орнуудын бүлгээс хасагдах учраас (Олон улсын хөгжлийн агентлаг-IDA болон Азийн Хөгжлийн Сангийн-ADF санхүүжилт авах болзол хангах) хөнгөлтгүй нөхцлөөр санхүүжилт авахыг хориглосон, улсын болон хотын захиргааны байгууллагууд шууд зээл авах явдлаас урьдчилан сэргийлэх эрх зүйн бодлого баримталж байгааг нэн даруй өөрчлөх шаардлагатай. Энэ нь Банк цаашид улсын салбарт илүү өргөн цар хүрээтэй ажиллах боломжийг нээх магадлалтай.

АХБ, ДБ болон бусад хоёр талын гол хандивлагч байгууллагуудтай хамтран ажилласнаар ЕСБХБ цаашид улсын салбарт хэрэгжүүлж буй төслийг санхүүжүүлж ажиллах явдлыг дэмжих нь дамжиггүй. Банкны зүгээс тээвэр, эрчим хүч, худалдааны зохицуулалтын салбарт Төв Азийн бүсэд хамтран ажиллах үйл ажиллагааг дэмжихэд чиглэсэн АХБ-ны хөтөлбөртэй (CAREC) нягт хамтран ажиллах болно.

Бодлогын түвшинд хийгдэх яриа хэлэлцүүлэг

Банкны салбарын хяналт шалгалтыг сайжруулах, нэгдэл нягтралыг хөхүүлэн дэмжих, мөнгө угаах үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлэх зэрэг тодорхой асуудлын тухай Монгол Банк, Банк хооронд бодлогын яриа хэлэлцүүлэг өрнүүлнэ. 2008 оны дундуур төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа болон шийдвэр гаргах, хэрэгжүүлэх, хариуцлага тооцох механизмын тухай зөвшилцөх, Хөрөнгө Оруулалтын Орчны Зөвлөлдөх Зөвлөлийг Банк амжилттай эхлүүлсэн бөгөөд өмнө Монголын төрийн удирдах байгууллага болон хөрөнгө оруулагчдын хооронд энэ тухай зөвшилцөн яриа хэлэлцүүлэг ямагт дутагдалтай байжээ. Хэдийгээр тус Зөвлөл статус, ач холбогдлын хувьд тодорхой байр суурьтай болж чадсан ч тус стратегийн хэрэгжилтийн хугацаанд үйл ажиллагааг нь улам сайжруулах шаардлагатай.

Техникийн туслалцаа болон бодлогын яриа хэлэлцүүлгийн үр дүнд Банк Улаанбаатар хотын агаарын бохирдол, сэргээгдэх эрчим хүчний замын зураглал, уул уурхайн олборлолтыг нэмэгдүүлэх газрын кадастрын нарийвчлал гаргах гэх мэт Монгол Улсын хувьд урт хугацаанд шийдвэрлэх шаардлагатай тулгамдсан нарийн асуудлуудыг анхаарч ажиллах хүчин чармайлтанд ЕСБХБ оролцсоор байна.

Монгол Улсын Эрдэс Баялаг, Эрчим Хүчний Яам, Уул Уурхайн Хэрэг Эрхлэх Газар, болон Газрын Тосны Хэрэг Эрхлэх Газартай хийх байгалийн нөөцийн салбар дахь эрх

зүйн орчинг сайжруулах (татвар гэх мэт), Олборлох Үйлдвэрүүдийн Ил Тод Байдлын тухай Санаачилгыг зохих ёсоор хэрэгжүүлэх тухай бодлогын яриа хэлэлцүүлгийг үргэлжлүүлж энэ чиглэлээр ДБ, Засгийн Газар, аж үйлдвэрийн салбарын төлөөлөл, ТББ-уудын нийгэмлэгтэй үргэлжлүүлэн нягт холбоотой ажиллана. Банкны зүгээс Засгийн Газар, Улсын Их Хуралд уул уурхайн аж үйлдвэрийн хөгжлийг хангах урт хугацааны тогтвортой шударга шийдэл эрэлхийлэх явдлыг дэмжих хүсэлтээ илэрхийлсэн билээ. Мөн эрдэс баялагийн боловсруулах үйлдвэр байгуулах, боловсруулсан эрдэс баялагийг экспортлоход шаардлагатай дэд бүтцийг хөгжүүлэх боломжийг судлах Монголын Засгийн Газрын санал санаачилгыг Банк дэмжиж ажиллана.

Банк ОУСБ-ууд, хандивлагч байгууллагууд, бизнесийн төлөөлөлтэй үргэлжлүүлэн хамтран ажиллана. Банкны Орчны Бодлого, Олон Нийтийн Мэдээллийн Бодлого нь Монголд хэрэгжүүлж буй бүх төсөл хөтөлбөрт хамаарна.

3.2 Салбарын шийдвэрлэвэл зохих асуудлууд ба Банкны үйл ажиллагааны зорилтууд

3.2.1 Аж ахуйн нэгж, хувийн хэвшил

Шилжилтийн үеийн сүүлийн хорин жилд Монгол Улсад бизнес эрхлэх явдал хүчтэй өрнөж дотоодын эрч хүчтэй, хөгжингүй аж ахуйн нэгжүүд бий болж тэдний удирдлагын чадвар эрс сайжирсан төдийгүй хэтийн зорилгоо бүрэн тодорхойлон ажиллаж байна. Банкны гол стратеги зорилго бол урт хугацааны зээл олгох (шууд хөрөнгө оруулалт), компанийн засаглалыг сайжруулах, аж ахуйн нэгжүүдэд бүх стандартаа олон улсын түвшинд хүргэхэд туслах зэргээр бизнес эрхлэгчдийн санал санаачилгыг дэмжих явдал мөн. Ажиллах хүчний дийлэнх хувь нь бичил, жижиг, дунд үйлдвэрийн компаниудад ажилладаг явдлыг энд цохон тэмдэглэх нь зүйтэй. Бизнесийн элементийг хөгжүүлэх нь ажлын байр буй болгох, ядуурлыг бууруулахад зохих хувь нэмрээ оруулдаг. Цаашилбал Банкны үйл ажиллагаа болон ДНБ-нд уул уурхайн салбар голлох хувь нэмэр оруулж байгаа ч уул уурхайн бус бизнесийн салбарт бизнесийн боломжийг бүрдүүлэх, улмаар ЕСБХБ-ны үйл ажиллагаа болон эдийн засгийн бүрэлдэхүүнийг төрөлжүүлэхэд чухал ач холбогдолтой.

Банк агробизнес, нэхмэл, эм зүй, үл хөдлөх хөрөнгө, аялал жуулчлал, барилгын материал гэх мэт төрөл бүрийн салбарт зээлийн болон өөрийн хөрөнгийн санхүүжилт хийх боломжийг үргэлжлүүлэн судлах болно.

Монголын бизнесийн салбарт Банк нэр хүнд бүхий гадаадын хөрөнгө оруулалтын анхаарлыг татах, бизнесийн үйл ажиллагааны стандартыг дээшлүүлэхэд туслах чиглэлээр зорьж ажиллана. Шилжилтийн Эхний Үе Шатан дахь Орнуудыг Дэмжих Санаачилга (ETCI) буюу Удирдлагын Өөрчлөн Байгуулах Хөтөлбөр (ТАМ), Бизнесийн Зөвлөгөө Өгөх Үйлчилгээ Хөтөлбөр (BAS) нь Банкны үйл ажиллагаа амжилттай хэрэгжихэд чухал ач холбогдолтой. Шууд Хөрөнгө Оруулалтын Хэрэгсэл (DIF) ба Зээлийн Шууд Санхүүжилтын Хэрэгсэл (DLF) батлагдсан бөгөөд шинээр Дунд Хэмжээний Хамтран Санхүүжүүлэх Хэрэгсэл (MCFF) боловсруулагдаж байна.

Дотоодын бизнесийн байгууллагуудад учирч буй гол бэрхшээлтэй асуудал бол урт хугацаатай зээл авах, дотоод гадаадын зах зээлд нэвтрэх боломжийг нэмэгдүүлэх, улмаар мэдээллээр хангагдах явдал, шийдвэр гаргах, ил тод байдлыг сайжруулах,

бүтээлч удирдлага, хувьцаа эзэмшигчдийн харилцааг хангах зэрэгт чиглэсэн компанийн бүтцийн өөрчлөлт хийх зэрэг асуудал байдаг.

Жишээлбэл, Монголын уламжлалт үйлдвэр болох ноолуурын салбар эцсийн зах зээлд хүрэх өргөн боломжтой, бүтээгдэхүүний дизайн загвар өнөөгийн эдийн засгийн бэрхшээлтэй орчинд амжилтанд хүрэх гол орц, хөдөлгөх хүч нь болж байна. Банк тус салбарт тусламжийн гараа сунгаснаар шинэ хөрөнгө, тоног төхөөрөмж худалдан авах, үр ашгийг нэмэгдүүлэхийн тулд бүрэн компьютержүүлэх, загвар дизайны чадавх, маркетингийн ур чадварыг сайжруулах, хилийн чанад дахь зах зээлд илүү өргөн фронтоор нэвтрэх боломжийг олгож байгаа юм.

Агро бизнесийн салбарт ялангуяа хүнсний захууд, спиртийн бус төрлийн ундаа үйлдвэрлэх зэрэг үйл ажиллагаанд Банк өөрийн хөрөнгийн болон шууд хөрөнгө оруулах хэлбэрээр өнөөг хүртэл идэвхтэй ажилласаар ирсэн билээ. Гол бэрхшээлтэй асуудал нь нийт хэрэглэгчдийн ихээхэн хувийг эзэлдэг уламжлалт хар захаас худалдаа хийдэг хэрэглэгчдэд хүрэх асуудал байдаг. Иймд Улаанбаатар хотод шинээр хайпермаркет хэлбэрийн хүнсний дэлгүүрийг хөгжүүлэхээр ажиллаж байна. Цаашилбал экспортонд гаргах мах махан бүтээгдэхүүн, арьс ширийг байгаль орчны стандартанд бүрэн нийцүүлж боловсруулах асуудал тулгараад байгаа билээ. Ус ундааны зах зээлийн хувьд Банк Кока Кола компанийн савлах үйлдвэрт усны шинэ төхөөрөмж суурилуулсан нь байгаль орчны стандартыг дээшлүүлэхэд чухал нөлөө үзүүлсэн алхам болжээ.

Үүний зэрэгцээ тус салбарт үйл ажиллагаагаа явуулж буй бусад бизнесийн байгууллагатай холбоо тогтоов. Банкны зүгээс жижиглэнгийн болон ундааны салбарт голлон анхаарч ажиллах ба нийлүүлэгчдийг Шилжилтийн Эхний Үе Шатан дахь Орнуудыг Дэмжих Санаачилгын (ETCI) хүрээнд хүлээн зөвшөөрөгдсөн арга хэрэгслийг ашиглан санхүүжүүлэх боломжийг судална. Мөн ЕСБХБ нь гадаадын хөрөнгө оруулалт болон мэдлэгийг шилжүүлэх явдлыг дэмжихийн тулд агро боловсруулах үйлдвэрт хамтарч ажиллах дотоодын болон гадаадын стратеги хамтрагчтай хамтарч ажиллах боломжийг судалж үзнэ. Салбарын үйл ажиллагааг дэмжихийн тулд Банк дотоодын агро зээлдэгч, дотоодын арилжааны банкуудтай эрсдлийг тэнцүү хуваах замаар агробизнесийн санхүүжилтийн хэлбэрийг ашиглах боломжийг судалж ажиллана

Дотоодын арилжааны банкууд төслийн эрсдлийг үнэлж дүгнэх туршлага байхгүй, шаардлагатай үнэлгээ хийх чадавхгүйн улмаас үл хөдлөх хөрөнгө болон аялал жуулчлалын салбарт урт хугацааны зээл авах явдал бизнесийн байгууллагуудын хувьд туйлын бэрхшээлтэй байсаар байна. Банк холимог хэрэглээ бүхий хөрөнгийн хөгжил тодруулбал аялал жуулчлал, бизнес аялалын зах зээлийг Монгол Улсад хөгжүүлэхийн тулд зочид буудал (өнөөгийн зах зээлийн нарийн шалгуурын дагуу) ялангуяа нэр хүнд бүхий дотоодын ивээн тэтгэгчтэй хамтран олон улсын туршлагатай сүлжээ зочид буудал барих, улмаар зочид буудал цаашилбал холбогдох хурал уулзалтын төвийн үйлчилгээнд шинэ шат ахиулахад чиглэсэн санхүүжилт хийгээд байгаа билээ.

3.2.2 Санхүүгийн байгууллагууд

Арилжааны банкууд одоогоор ОУСБ-уудаас өөр эх үүсвэрээс хугацаат санхүүжилт авах боломж одоогоор хязгаарлагдмал байгаа энэ үед Монгол Улсын санхүүгийн салбарыг дэмжих нь Банкны тэргүүлэх чиглэл байх болно. Арилжааны банкуудын байгууллагын болоод иргэдийн харилцагчид боломжийн нөхцлөөр зээл авахад хүндрэлтэй тулгардаг учир шинээр бизнес эхлэх, үйл ажиллагаагаа өргөжүүлэх, үл хөдлөх хөрөнгө худалдан авах буюу шинэчлэх зэрэг боломжийг нь хязгаарлаж байна. Банкны санхүүгийн болоод

шударга байдлын шалгуурыг хангасан арилжааны банкуудад төрөл бүрийн зээлийн шугам нээх болон зээлийн бүтээгдэхүүнийг олгох замаар санхүүгийн зуучлалыг бэхжүүлэх, улмаар санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэхийг зорино. Дунд, жижиг бичил бизнесийн байгууллагуудад зориулсан хугацаат санхүүжилт нэн тэргүүнд тавигдах боловч бусад зээлийн хэлбэр болох компанийн ерөнхий зорилгод зориулсан зээл, Дунд Хэмжээний Хамтарсан Санхүүжилтийн Хэрэгслийн хүрээнд хамтарч санхүүжүүлэх буюу эрсдэл хуваах сонголтыг санал болгох болно. Орон сууцны барьцаат зээлийн тухай холбогдох хууль батлагдан хүчин төгөлдөр болох ба дотоодын чадавхи бий болсон нөхцөлд Банк моргейжийн зээл буюу орон сууцны барьцаат зээлийг санхүүжүүлэх асуудлыг судалж үзэж болох юм.

Банкны зүгээс Бүсийн Худалдааг Дэмжих Хөтөлбөрийг (TFP) хэд хэдэн банкуудтай хамтран хэрэгжүүлэх чиглэлээр идэвхтэй ажиллах болно. Худалдааны санхүүжилт хийх зорилгоор арилжааны банкуудаас зээлийн шугам авах боломж хомс байгаа тул Худалдааг Дэмжих Хөтөлбөр өндөр эрэлт хэрэгцээтэй байна. Одоо хамтран ажиллаж байгаа арилжааны банкуудад тусгай дэмжлэг үзүүлэх явдал нь тус стратегийг хэрэгжүүлэх хугацаанд тулгарах гол асуудал байх бөгөөд эдгээр банкуудын хөрөнгийг нэмэгдүүлэх, улмаар байгууллагыг бүрэлдүүлэн буй болгоход туслах шаардлагатай болно. Банк арилжааны банкуудад хувь эзэмших боломжийг эрэлхийлж, ингэснээр эдгээр банкуудын өөрийн хөрөнгийн суурийг бэхжүүлэн компанийн засаглалыг сайжруулна. Үүнийг шууд өөрийн хөрөнгийн санхүүжилтийн хэлбэрийн зэрэгцээ, хувь эзэмших болон холимог хэлбэрээр оролцох (quasi equity) бусад хэлбэрийг мөн судалж үзнэ. Хоёрдогч зэрэглэлийн ба хөрвөх зээлийн хэлбэр, түүний дотор хувийн хөрөнгө оруулалтын санд (private equity fund) оролцох хэлбэрийг мөн харгалзан үзэх болно. Цаашилбал банкны салбарын нэгдэх үйл явцыг дэмжин зээлийн болон өөрийн хөрөнгийн санхүүжилт хийх хэлбэрээр тухайн санал санаачилга нэг бүрээр техникийн туслалцаа үзүүлэхэд Банк ямагт бэлэн байх болно. Энэ чиглэлээр Банк нь ОУСБ-ууд (Дэлхийн Банк, ОУСК, АХБ) болон Монгол Банктай нягт хамтран ажиллана. Арилжааны банкууд нэгдэх үйл явцад гадаадын нэр хүндтэй банк оролцох явдлыг дэмжинэ.

ЕСБХБ нь байгууллагыг бүрэлдүүлэн бий болгох, шилжүүлсэн ур чадварын тогтвортой байдлыг хангах зорилгоор хандивлагчдаас техникийн туслалцааны санхүүжилт хүсэх болно. Бичил, жижиг ба дунд үйлдвэрийн санхүүжилтын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй банкуудыг дэмжихэд техникийн туслалцаа зориулагдана. Өнөөдрийн байдлаар бичил жижиг бизнесийн санхүүжилтыг зөвхөн хоёр банк гол төлөв барьцааны үндсэн дээр хийж байгаа бөгөөд ЖДҮ-ийн санхүүжилт тус улсад богино түүхтэй юм. Худалдааг Дэмжих Хөтөлбөрийг дэмжих зорилгоор Худалдааны Санхүүжилтын талаар Зөвлөгөө Өгөх Хөтөлбөрийг хэрэгжүүлэх шаардлагатай болно. Аливаа өөрийн хөрөнгийн санхүүжилт хийхэд техникийн туслалцаа шаардагдах бөгөөд үүнийг олон улсын банкттай хамтран ажиллах хөтөлбөрийн ('twinning' programme) хүрээнд хэрэгжүүлэх болно.

Цаашилбал лизинг, хэрэглэгчийн санхүүжилт, даатгал, тэтгэвэр, банк бус бичил санхүүгийн байгууллага зэрэг банк бус санхүүгийн байгууллагуудыг Банк дэмжиж ажиллахыг хичээнэ. ББСБ-уудыг санхүүжүүлэх үндсэн арга бол өөрийн хөрөнгийн санхүүжилтын хэлбэр байх боловч хугацаат зээлийн санхүүжилтыг лизинг, ахуйн хэрэглээний санхүүжилт, банк бус бичил санхүүгийн байгууллагын хувьд мөн харгалзан үзнэ. Банк бус санхүүгийн байгууллагууд хөгжлийн эхэн үедээ байгааг харгалзан, энэ хүрээнд Банкны зүгээс гаргах санаачилгыг дэмжих зорилгоор техникийн туслалцааг үзүүлэх шаардлагатай болно. Цаашилбал ББСБ, үнэт цаасны зах зээл (жишээ нь дотоодын хөрөнгийн бирж), нэн ялангуяа өөрийн хөрөнгө, бонд, моргежийн

зээл буюу ипотек, даатгалын зах зээлийн чадавхийг бэхжүүлэх, үндэсний валютаар санхүүжилт хийх зэрэг асуудалд анхаарлаа төвлөрүүлнэ.

Монголбанк, Санхүүгийн Зохицуулах Хороотой бодлогын түвшинд яриа хэлэлцүүлэг өрнүүлж удирдлага, хяналт шалгалтыг боловсронгуй болгох, банкууд Монгол Банктай болон стратегийн хөрөнгө оруулагчид хоорондоо нэгдэхийг дэмжих, түүнчлэн мөнгө угаахаас сэргийлэх, алан хядах ажиллагааг санхүүжүүлэхээс сэргийлэх зэрэг онцгой асуудалд анхаарлаа төвлөрүүлнэ. Эцэст нь тохиромжтой төслүүдийг тодорхойлсон нөхцөлд дотоодын эх үүсвэрээс үндэсний валютаар дунд хугацааны санхүүжилт хийх боломжийг судлах болно. Банк нь Санхүүгийн Зохицуулах Хороотой хамтран зах зээлийн мэдээлэлд тулгуурлан хөрөнгө оруулагчдад шийдвэр гаргах боломж олгохын тулд санхүүгийн бус байгууллагууд болон хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх явдлыг эрх зүйн орчин бүрдүүлэх, байгууллагын чадавх, засаглал, ил тод байдлыг сайжруулах замаар дэмжиж ажиллана.

3.2.3 Байгалийн нөөцийн салбар

Байгалийн нөөцийн салбарт дэмжлэг үзүүлэх нь Монгол Улсад явуулах Банкны үйл ажиллагааны нэн тэргүүний чиглэл байх болно. Монгол Улс ашигт малтмалын их нөөцтэй бөгөөд түүнийг арилжааны хэлбэрээр ашиглах томоохон үйл ажиллагаа хүлээгдэж байгаа билээ. Нүүрс, зэсийн олборлолтын салбарт улсын үйлдвэр давамгайлж байгаа бөгөөд бүтээгдэхүүний үнэ болон бизнесийн үйл ажиллагаа нь арилжааны үндэслэлтэй болж хараахан чадаагүй байна. Харин алт олборлолтын салбар харьцангуй арилжааны хэлбэртэй төдийгүй сүүлийн жилүүдэд илүү ил тод болж бизнесийн үйл ажиллагаа өсөх чиг хандлагатай байна. Сүүлийн хоёр жилд Банкны зүгээс ил тод байдал, нийгэм, байгаль орчны стандартын чиглэлээр чадварлаг хэд хэдэн хувийн компанийг дэмжиж ажилласан нь Банкны нэр хүндийг өргөж байгаа билээ. Олон улсын үнийн орчин тогтворгүй, дэлхийн эдийн засгийн уналт зэргийг харгалзан туршлагатай, санхүүгийн хувьд боломжтой стратегийн хөрөнгө оруулагчдын анхаарлыг татах явдал тус салбарын тулгамдсан асуудал хэвээр байсаар байна. Дотоодод болон олон улсын хэмжээнд арилжааны хэлбэрийн санхүүжилт авах явдал туйлын хэцүү байгаа энэ үед Банк тус стратегийг хэрэгжүүлэх хугацаанд томоохон үүрэг гүйцэтгэх болно.

Чадварлаг стратегийн хөрөнгө оруулагчидтай хамтран томоохон хэмжээний төслийг дэмжиж оролцох явдал Банкны нэн тэргүүний зорилго хэвээр үлдэнэ. Мөн Банкнаас дотоодын эрч хүчтэй, өрсөлдөх чадвар, ажлын дадлага туршлагаа харуулж чадсан уул уурхайн нэр хүндтэй компанийг санхүүжүүлэх асуудлыг судална. Банк Шилжилтийн Эхний Үе Шатанд байгаа Орнуудын тогтолцооны (ETC framework) хүрээнд зарим дунд хэмжээний уул уурхайн компанитай хязгаарлагдмал хүрээнд хамтран ажиллана.

Хувийн хэвшлийн салбарын үйл ажиллагааг чухалчлан анхаарч ажиллана. Оюу толгойн төсөл, Таван толгойн төсөл гэх мэт томоохон хэмжээний стратегийн уурхайтай холбогдуулан Банкны стандартыг хангасан дотоод гадаадын компаниудад санхүүжилт олгох явдлыг судална. Эрчим хүчний станц, төмөр замын сүлжээ байгуулах (дэд бүтцийн хэсгийг үзнэ үү) гэх мэт уул уурхайтай холбоо бүхий дэд бүтцийн төслийг дэмжих асуудлыг мөн судалж үзнэ.

Монгол Улсын нэмүү өртгийн үйлдвэрлэлийг боловсронгуй болгох, өрсөлдөөнийг нэмэгдүүлэх бодлого зохицуулалтын хүрээнд Засгийн Газраас санаачлан эрдэс баялгийг боловсруулах үйлдвэр байгуулахад хувийн хэвшлийн салбарыг дэмжих бодлогыг Банк дэмжинэ. Ийм төслийг санхүүжүүлэхдээ Банк тухайн төслийг ивээн

тэтгэгч байгууллагаас Хэдийг төлснөө нийтэд мэдэгдэх (PWYP) буюу Олборлох Үйлдвэрүүдийн Ил Тод Байдлын тухай Санаачилгын (EITI) зарчмыг хэрэгжүүлэн дагаж мөрдөхийг шаардах замаар сайн засаглал, ил тод байдал, орлогын удирдлагын стандартыг дэмжиж ажиллана. Цаашилбал байгалын баялгийг захиран зарцуулах төсөл хөтөлбөрт хөрөнгө оруулалт хийснээр Банк эрчим хүчний үр ашиг, цаг уурын өөрчлөлтийн чиглэлээр хэрэгжиж буй санал санаачилгыг дэмжихийг зорьж ажиллана.

Засгийн Газар сүүлийн үед төрийн өмчит нүүрсний компаниудыг хувьчлах тухай хэлэлцэж байна. Эдгээр компаниудын ихэнх нь арилжааны бус хэлбэрээр үйл ажиллагаагаа явуулдаг, хангалттай ашигтай ажиллаж чаддаггүй (жишээлбэл, нүүрсний салбарт төрийн бодлогоор нүүрсний үнийг доогуур тогтоодог.) Банкнаас нүүрсний компаниудыг хувьчлах бэлтгэл ажлыг хангахад зориулж тодорхой хүрээнд зээл болон техникийн туслалцаа үзүүлэх асуудлыг судална. Хувьчлалын үеэр нэр нөлөө бүхий хөрөнгө оруулагчид оролцох шийдвэр гаргавал Банк тухайн санал санаачилгыг дэмжих болно.

Газрын тос, байгалийн хий, үйлчилгээний салбар, байгаль орчны нөхөн сэргээлтэд чиглэсэн төслийг санхүүжүүлэх нь Банкнаас Монгол Улсад хэрэгжүүлж буй үйл ажиллагааны нэгэн чухал бүрэлдэхүүн хэвээр үлдэнэ. Энэ чиглэлээр хэрэгжүүлсэн үйл ажиллагаагаараа Банк өөрийн нэр хүндээ олж зохих байр суурийг эзэлсэн. Банкны зүгээс шинэчлэлийг эрэлхийлдэг, ил тод, чадварлаг үйл ажиллагаа явуулдаг дотоодын газрын тосны компаниудтай үргэлжлүүлэн хамтран ажиллана.

Монгол Улсын Эрдэс Баялаг, Эрчим Хүчний Яам, Ашигт Малтмалын Хэрэг Эрхлэх Газар, болон Газрын Тосны Хэрэг Эрхлэх Газартай хийх байгалийн нөөцийн салбар дахь бизнесийн орчинг сайжруулах, лиценз зөвшөөрөл олгох, хянах үйл явцыг шударга, ил тод байлгах арга замыг танилцуулах, Олборлох Үйлдвэрүүдийн Ил Тод Байдлын тухай Санаачилгыг зохих ёсоор хэрэгжүүлэх тухай бодлогын яриа хэлэлцүүлгийг үргэлжлүүлж, энэ чиглэлээр ДБ, Засгийн Газар, уул уурхайн салбарын төлөөлөл, ТББ-уудтай үргэлжлүүлэн нягт холбоотой ажиллана.

3.2.4 Дэд бүтэц

Одоо ашиглагдаж байгаа дэд бүтцийн дийлэнхийг 1990 оноос өмнө барьж байгуулсан ба олон жил сэргээн засварлаагүй байна. Үүний зэрэгцээ Өмнөд Говийн бүсэд уул уурхай, болон уул уурхайтай холбоотой бизнес эрхлэх томоохон хэмжээний бизнесийн шинэ боломж буй болоод байна. Тээвэр, эрчим хүч, нийтийн аж ахуйн салбарт дор дурдсаны дагуу дэд бүтцийн асар их эрэлт хэрэгцээ бий болсон боловч хувийн хэвшлийн салбарын үйл ажиллагаа өсөн нэмэгдэх явдал хязгаарлагдмал байна. Дэлхийн Банкны саяхан хэвлүүлсэн материалаас үзэхэд Өмнөд Говийн бүсэд шаардлагатай байгаа санхүүжилт 5.2 тэрбум ам долларт хүрчээ. Зарим төслийг хувийн хэвшлийнхэн санхүүжүүлэх ч дийлэнхийг төрийн санхүүжилтээр шийдвэрлэх шаардлагатай болно.

Монгол Улс улсын салбарт зээл авах талаар туйлын хатуу чанд бодлого баримталдаг. 2003 оны 6 дугаар сард батлагдсан “Монгол Улсын Гадаадын зээл тусламжийг зохицуулах тухай хуулинд” тусгасаны дагуу Засгийн Газар зөвхөн концевцийн нөхцлөөр л зээл авах боломжтой. Хуулинд “концевци”-ийн тодорхойлолтын талаар дурдаагүй боловч ОУВС-ын шаардлагатай харьцуулбал зээлийн 35-аас доошгүй хувь нь буцалтгүй тусламж хэлбэртэй байх ёстой ажээ. Орон нутаг, бүсийн эрх бүхий байгууллагууд зөвхөн Засгийн Газраас зээлж болно (Улсын төсвийн удирдлага, санхүүжилтын тухай хуулийн 57-р зүйл). Өөрөөр хэлбэл орон нутаг, хотын захиргаа шууд зээл авах боломжгүй гэсэн үг. Орон нутгийн захиргаанаас баталгаа гаргах тухай

хуулинд заалт ороогүй ч орон нутгийн захиргаа зээлийн баталгаа гаргах эрхгүй гэж Сангийн Яам үздэг бөгөөд өнөөг хүртэл ОУСБ буюу хоёр талт хөнгөлөлттэй аливаа зээлийн баталгааг гаргасан орон нутаг, бүсийн засаг захиргаа байхгүй байна.

Эдгээр шаардлагууд нь түрүүчийн стратегийн баримт бичгийн хугацаанд Банкны дэд бүтцийн салбарт хэрэгжүүлэх үйл ажиллагаанд томоохон саад болж байсан бөгөөд Банк төрийн салбарт ямар ч төсөл хэрэгжүүлж чадаагүй юм. Гэвч байдал өөрчлөгдөж болох талтай. Сүүлийн хэдэн жил нэг хүн амд ногдох орлогын хэмжээ асар ихээр нэмэгдсэн учраас Монгол Улс удахгүй Дэлхийн Банк, Азийн Хөгжлийн Банкнаас (Олон улсын хөгжлийн агентлаг-IDA болон Азийн Хөгжлийн Сан-ADF) хөнгөлттэй нөхцлөөр санхүүжилт авч чадахгүй болно гэдгийг төрийн удирдлагууд ойлгож байгаа ажээ. Төрийн салбарт оруулж байгаа хөрөнгө оруулалтын эрэлт хэрэгцээ асар их байдгаас хоёр талт хандивлагч байгууллагуудаас авах хөнгөлттэй санхүүжилтэд хэт найдах нь боломжгүй зүйл болно. Иймд Засгийн Газар хуулиндаа нэмэлт өөрчлөлт оруулахаар хэлэлцэж байна. Улсын Их Хурлаас Засгийн Газарт олон улсын хөрөнгийн зах зээлээс 1.2 тэрбум ам. долларын хөрөнгө босгохыг үүрэг болгосон билээ. Одоо хэрэгжиж байгаа ОУВС-ын хөтөлбөрийн хүрээнд Засгийн Газар хөнгөлттэй нөхцлөөр 200 сая ам доллар хүртэл санхүүжилт авах боломжтой.

Улсын салбарт Банктай хамтарч ажиллах хүсэлтээ байгууллагууд ирүүлээд байна. Хэрвээ боломжтой төслийн санал боловсруулбал 200 сая ам долларт багтаан Банкнаас Засгийн Газарт шууд зээл олгох буюу төрийн байгууллагуудад Засгийн Газрын баталгааг үндэслэн зээл олгох асуудлыг шийдвэрлэж болно.

Хувийн хэвшлийн салбарт төсөл хэрэгжүүлэх замаар бизнесийн боломж нэмэгдэж байгаа нь төр, хувийн хэвшлийн түншлэл бодитой хэрэгжих боломжтойг харуулж байна. Засгийн Газар Төр, Хувийн Хэвшлийн Түншлэлийн тухай эрх зүйн баримт бичиг батлахаар бэлтгэж байгаа бөгөөд тус үйл ажиллагаанд АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлаг тусалжээ. Дотоодын компаниудад төмөр зам барих 2 зөвшөөрлийг олгосон байна. Засгийн Газрын харьяа Төр, Хувийн Хэвшлийн Түншлэл хариуцсан нэгж байгуулагдаж байна. Засгийн Газрын чадавхи хязгаарлагдмал байгаа учраас тохиромжтой нөхцөл бүрдсэн тохиолдолд Банк тухайн хувийн хэвшлийн төслүүдийг дэмжиж болох талтай.

3.2.4.1 Тээвэр

Тээврийн дэд бүтцийн салбарт тулгараад байгаа шийдвэрлэвэл зохих үндсэн асуудал нь тээврийн дэд бүтцийн чанарыг сайжруулах бөгөөд үүнийгээ төсвийн хөрөнгийн хязгаарлагдмал байдалд нийцүүлэн, боломжтой тохиолдолд хувийн хөрөнгө оруулалтыг татах замаар дэд бүтцийн аж ахуйн нэгжүүдийн ирээдүйн тогтвортой үйл ажиллагааны үндэс суурийг бий болгохуйц байдлаар хэрэгжүүлэх явдал юм. Тээврийн дэд бүтцийг сайтар хөгжүүлэх нь дотоод, гадаадын гол зах зээлд холбоо харилцааг буй болгож, худалдааг зохицуулахад чухал үүрэгтэй байдаг. Гэвч хүн амын орлого газар нутгийн хэмжээтэй харьцуулбал харьцангуй бага байгаа тус орны нөхцөлд чанартай дэд бүтцийг буй болгох туйлын хэцүү бэрхшээлтэй байгаа билээ. Иймд Банк нь тус улсын зээл авах чадавхи хязгаарлагдмал байгааг харгалзан шинэ хөрөнгө оруулалтыг сайтар сонгон шалгаруулалт хийсний үндсэн дээр дэмжих болно.

Иргэний агаарын салбар

Монгол Улсын хувьд аялал жуулчлал чухал салбар учраас агаарын тээвэр гол үүрэгтэй. Одоогийн байдлаар авто замын сүлжээ дутагдалтай учраас агаарын тээвэр Монголын бүс нутгуудыг холбох гол үүрэг хүлээж байна. Үндэсний Хөгжлийн Стратегийн хүрээнд Монголын Засгийн Газар агаарын тээврийг хөгжүүлэх асуудлыг тэргүүлэх чиглэлд багтаасан байна. Банк дотоодын хувийн агаарын тээврийн нэг компанид удирдлага, аюулгүй байдлын стандартыг сайжруулахад чиглэгдсэн тусламж үзүүлэхээр зорьж байна. Дотоодын иргэний агаарын тээврийн компаниудын хувьд өрсөлдөөн бага эсвэл бараг байхгүй гэж хэлж болох учраас Банк өөр бусад санал санаачилгыг дэмжих боломжийг судална.

Олон улсын агаарын тээврийн компаниудын хувьд төрөөс МИАТ буюу Монгол Улсын Иргэний Агаарын Тээврийн компанийг ирээдүйд хувьчлах асуудал хэлэлцэгдэж байна. Банкнаас МИАТ компанид удирдлагын чиглэлээр мэргэжлийн туслалцаа үзүүлж байсан бөгөөд стратегийн хөрөнгө оруулагчид нь хамтран хөрөнгө оруулахыг хүсвэл тус компанийн хувьчлалын үеэр буюу хувьчлалаас өмнө хувьчлалтай холбоотой асуудлаар, эсвэл онгоц худалдах зэрэг тодорхой сонгосон хөрөнгийн гүйлгээний үйл ажиллагааг дэмжин ажиллах боломжтой.

Онгоцны буудлын хувьд асар их хөрөнгө оруулалт шаардах бөгөөд олон улсын болон бүсийн онгоцны буудал барих, сэргээн засварлах чиглэлээр дотоодын болон хандивлагч бусад байгууллагууд санал хүсэлтээ илэрхийлсэн. Иймд Банк энэ чиглэлээр ажиллах шаардлага хязгаарлагдмал болж байна.

Төмөр замын салбар

Төмөр замын гол шугамыг (2215 км Оросын өргөн хэмжээтэй зам) Транс-Монголын Төмөр Зам ажиллуулдаг бөгөөд эзэмшлийн 50 хувийг Монголын тал, 50 хувийг Оросын Төмөр Зам эзэмшдэг байна. Компанийг 1940-өөд оны сүүлчээр гэрээгээр байгуулсан бөгөөд өвөрмөц эрх зүйн статустай юм. Шинээр төмөр зам барих хэд хэдэн төсөл хэрэгжиж байгаа ч Оросын Төмөр Зам Засгийн Газрын баримталж буй хүчин чармайлтыг төдийлөн дэмжихгүй байна. Монголын төмөр замын эрх зүйн өвөрмөц статус, эзэмшлийн хэлбэр нь одоогоор ЕСБХБ-ийг шууд хамтран ажиллах боломжгүй болгож байгаа юм.

Үүнээс гадна хувийн төмөр зам барьж байгуулах хэд хэдэн санаачилга гарсан билээ. Дэлгэрэнгүй мэдээлэл батлагдаагүй ч гэсэн эрдэс баялагийг Хятад уруу төмөр замаар тээвэрлэх төслийг Төр, Хувийн Хэвшлийн Түншлэлд тулгуурлан хэрэгжүүлэх ажээ. АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлаг болон Азийн Хөгжлийн Банк Засгийн Газрын Төр, Хувийн Хэвшлийн Түншлэлийн санаачилгыг дэмжиж байгаа юм. Хэрвээ тус санаачилгыг хариуцлагатайгаар олон улсын туршлагад тулгуурлан хэрэгжүүлж чадвал Банкны зүгээс дэмжих боломжтой.

Авто замын салбар

Нийт 49,250 км авто замын сүлжээнээс зөвхөн 15 хувийг хатуу хучилттай зам эзэлж байна. Замын нягтрал нэг дөрвөлжин км-т 0.03 км байгаа нь маш доогуур үзүүлэлт учир энэ салбар дахь хөрөнгө оруулалтын хэрэгцээ шаардлага асар их юм. Гэвч хөрөнгө оруулалтыг улсын төсвийн хязгаарлалт, зээлийн хязгаарлалтаар хаан боогдуулдаг. Цаашилбал хүн ам сийрэгжилт, замын ачааллын хэмжээнээс шалтгаалан шинээр барьж байгуулсан авто замын эдийн засгийн үзүүлэлт сөрөг гарч болох юм. Гэвч бүс нутгийг

хооронд нь холбох, бүс хоорондын нэгдмэл байдлыг хангах гэх мэт эргэх үр ашгийн тооцоололд төдийлөн тооцоологддоггүй эдийн засгийн үр ашгийг харгалзан авто замын төслийг санхүүжүүлэх явдал зарим тохиолдолд гарч болохыг үгүйсгэхгүй. Банк тус салбарын өөрчлөлт шинэчлэлийг хамтран хангах чиг хандлагад түшиглэн бусад ОУСБ-уудтай хамтран төсөл хөтөлбөр санхүүжүүлэх боломжийг анхаарч үзнэ.

3.2.4.2 Эрчим хүч

Монголын эрчим хүчний салбарт дараах үндсэн дөрвөн бэрхшээлтэй асуудлууд тулгарч байна. Үүнд: (i) эрчим хүчний өнөөгийн үр ашиггүй, хэт эрчимжсэн байдлыг бууруулахад чиглэгдсэн эрчим хүчний салбарт тодорхой арилжааны хөшүүрэг бий болгосон зах зээлийн бүтээлч загварын боловсруулах, энэ чиглэлээр ажиллах шинэ хөрөнгө оруулалтыг тодорхойлох, (ii) цахилгааны туслах тогтолцооноос өртгөөс шалтгаалсан тарифын бүрэн тогтолцоонд шилжих, (iii) Монгол Улсын хурдацтай хөгжиж байгаа эрдэс баялгийн салбарын өсөн нэмэгдэж буй эрэлт хэрэгцээг хангах, одоогийн ашиглаж буй дэд бүтцийн найдвартай байдал, байгаль орчны гүйцэтгэлийг сайжруулахын тулд хуучирч элэгдсэн халаалтын генераторын хүчин чадал, дамжуулах сүлжээг солих, шинэчлэх (хамгийн залуу генератор л 28 жил ажиллажээ) болон (iv) салхи, бага хэмжээний усны сэргээгдэх эрчим хүчний томоохон боломж, бололцоог ашиглах зэрэг болно.

Эдгээр тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд учирч буй гол бэрхшээл бол өргөн уудам газар нутагт хүн ам цөөн байгаа явдал юм. Цөөн хүн ам түүнээс улбаалан эрчим хүчний эрэлт хэрэгцээ бага байх (харьцангуй ойлголт) явдал эрчим хүчний салбарын нэгж бүрэлдэхүүнд ногдох тогтмол зардлыг өсгөх, цаашилбал хэмжээ том байхын хирээр тогтмол зардал өндөр байхад хүргэдэг. Ялангуяа шинэ, эрчим хүчээр баялаг эрдэс баялгийн төслүүдийг хэрэгжүүлэх эсвэл Монгол Улсын сэргээгдэх эрчим хүчний боломжийг ашиглах нь хугацаа, өртөг зардал, шаардлагатай дамжуулах холбоо зэргээс шалтгаалж байна.

Дээр дурдсан дөрвөн тулгамдсан асуудлын (i) ба (ii) нь байгууллагын түвшинд шийдвэрлэгдэх бодлогод тулгуурласан асуудал юм. Энэ чиглэлээр АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлаг тэргүүтэй баг ажиллаж байгаа учраас Банкны зүгээс энэ асуудлыг шийдвэрлэхэд оролцох ёстой ч шаардлагагүй гэж үзэж байна. Харин (iii) дахь асуудлыг шинэ СНР-5 эрчим хүчний үйлдвэр барьснаар шийдвэрлэх боломжтой бөгөөд саяхан тендер зарласан ч төдийлөн амжилттай явагдаагүй. Банк тухайн ивээн тэтгэгч болон үйл ажиллагааны журмыг хүлээн зөвшөөрч байгаа тохиолдолд төслийг дэмжих арга замыг эрэлхийлэх ёстой. Засгийн Газраас баталгаа гаргуулж хөрөнгө оруулалтыг шилжүүлэх, хуваарилах явдлыг санхүүжүүлэх боломжийг Банк судална. (iv) дүгээрт дурдсан асуудал бол сэргээгдэх эх үүсвэрийн тогтолцоог хөгжүүлэхэд чиглэсэн техникийн туслалцааг Банкнаас үзүүлэх нь хамгийн нарийн чухал асуудал болоод байгаа бөгөөд Салхитын салхин ферм байгуулах Ньюком компанитай хамтран ажиллахад Банк хэрхэн оролцохыг тодорхойлох нь чухал байна. Банкны зүгээс сэргээгдэх эрчим хүчийг эхний ээлжинд Төвийн Эрчим Хүчний Тогтолцоонд үйлдвэрлэн, ашиглах явдлыг дэмжих зорилготой бөгөөд ингэснээр төслийн хамрах хүрээг тохиромжтой хэмжээнд байлгах боломж бүрдэх юм. Цаашид Монголын алслагдсан хөдөө орон нутагт энэ чиглэлээр төсөл санхүүжүүлэхдээ эрчим хүчний тээвэрлэлтийн өртөг өндөр, эрчим хүчний тээвэрлэлтийн дэд бүтцийн нөхцөл бүрэн хангагдаагүй зэргийг харгалзан үзэх нь зүйтэй. Мөн Банкнаас GHG утааг багасгахын тулд Монголын нөхцөлд био түлш боловсруулан ашиглыхыг дэмжих асуудлыг судална. Сэргээгдэх эх үүсвэрийн тогтолцоог хөгжүүлэх явдал нь Банкны нэн тэргүүний зорилго хэвээр байх болно.

Эрчим хүч, байгалын баялгийн салбар хооронд хамтын ажиллагаа, ялангуяа дамжуулах буюу эх үүсвэрийг буй болгох төслийг санхүүжүүлэх боломжийг судалж энэ чиглэлээр тодорхой хөрөнгө оруулалтыг дэмжинэ, жишээлбэл, Өмнөд Монголын уул уурхайн олборлолтын төслүүдийг эрчим хүчээр хангах эрчим хүчний станц барьж байгуулах зэрэг асуудлыг хамтран шийдвэрлэх нь зүйтэй. Өмнөд Говийн бүсэд хувийн хэвшлийн оролцоотой хэд хэдэн шинэ төсөл хэрэгжиж байгаа билээ. (Дэлхийн Банк тус бүсэд шаардагдах цахилгааны хөрөнгө оруулалтанд нийт 2.7 тэрбум ам доллар шаардагдана хэмээн тодорхойлжээ.) Төр, Хувийн Хэвшлийн Түншлэлийн төсөлтэй ажиллах төрийн чадавхи хязгаарлагдмал байгааг харгалзан боломжтой тохиолдолд Банк эдгээр санал санаачилгыг дэмжин оролцох асуудлыг судалж үзнэ.

3.2.4.3 Нийтийн аж ахуй ба байгаль орчин

Монголын Хотын Захиргаа нь бие даасан байдал, санхүүгийн чадавхийн хувьд хязгаарлагдмал юм. Төвлөрлийг сааруулах оролдлогыг сүүлийн жилүүдэд түлхүү анхаарч ажиллаж байгаа ч хотын дэд бүтцийн хөгжлийн асуудлыг шийдвэрлэхэд төвлөрсөн Засгийн Газар голлох үүрэг гүйцэтгэсэн хэвээр байна. Автобус бааз, усан хангамжийн компаниуд гэх мэт нийтийн ахуйн үйлчилгээний төрийн хэд хэдэн компани үйл ажиллагаа явуулж байгаа ч хотын захиргаа буюу компаниуд санхүүжилт хийх хангалттай хөрөнгөгүй учраас өөрийн хөрөнгийн дийлэнхийг төрөөс хангадаг байна. Тарифыг нэмэх асуудал улс төрийн хувьд туйлын эмзэг асуудал байдгаас ихэнх компаниуд зардал өртгөө нөхөж чаддаггүй, нийтийн ахуйн үйлчилгээний тогтвортой байдал хангалтгүй байдаг ажээ.

Эдгээр нөхцөл байдлын улмаас Улаанбаатар хотын тээврийн салбар томоохон асуудалтай тулгараад байгаа юм. Замын бөглөрөл, авто замын хөдөлгөөний аюулгүй байдал, хотын агаарын бохирдол зэрэг нь хүн амын санааг зовоосон томоохон асуудал болжээ. Төрөөс энэ талаар арга хэмжээ авах санаачилга гаргаж АХБ-ны тусламж дэмжлэгтэйгээр Улаанбаатар хотын тээврийн тогтолцоо болон Говийн бүсийн олон нийтийг хөгжүүлэх төсөл хэрэгжүүлж байна. Хөрөнгө оруулалтын ихэнхи хэсгийг улсын салбараас гаргах бөгөөд зарим үйл ажиллагааг хувийн хэвшлийн салбар хийж гүйцэтгэх юм. (лизинг буюу удирдлагын гэрээний үндсэн дээр) Банк үүнтэй төстэй санал санаачилгыг бусад ОУСБ-тай хамтран дэмжиж ажиллана.

Улсын салбарыг санхүүжүүлэх боломжийн хувьд хязгаарлагдмал хэвээр байна. Нийтийн аж ахуйн үйлчилгээнд зориулж ОУСБ-уудаас болон хоёр талын гэрээгээр асар их зээл (төв Засгийн Газраас эцсийн зээлдэгчид дамжуулан зээлдүүлэх хэлбэрээр) авсан билээ. Нийтийн аж ахуйн үйлчилгээний тариф зардал өртгийг нөхөж чадахгүй маш доогуур хэмжээнд байгаа нь нийтийн аж ахуйн үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудыг тогтворгүй байдалд оруулж улмаар нийтийн аж ахуйн үйлчилгээний өрийн түвшинг тогтворгүйжүүлэхэд хүргэж байна. Энэ тохиолдолд Банк өнөөгийн төлбөрийн чадварын хязгаарлалтын хүрээнд үйлчилгээний чанар хүртээмж, өртөг зардлын хяналтыг сайжруулахад арилжааны чиг хандлагыг нэвтрүүлэх, нөгөөтэйгүүр зардлаа нөхөх хэмжээний үнэ тарифыг аажмаар нэвтрүүлж үйлчилгээний төлбөр хураалтын тогтолцоог боловсронгуй болгох замаар хотын нийтийн аж ахуйн ба үйлчилгээний байгууллагуудын санхүүгийн тогтвортой ажиллагааг дунд хугацаанд хангах зорилтыг дэмжинэ. Шинэ хөрөнгө оруулалтыг авч хэрэгжүүлэхийн тулд нийтийн аж ахуйн компани болон Хотын Захиргаанд төслийн хэрэгжилт, хяналт шалгалтын чадавхийг зохистой түвшинд бүрдүүлсэн байх явдлыг Хотын Захиргаа хангасан байх учиртай тул бүтэц зохион байгуулалтын томоохон ажил хийгдэх болно.

3.2.4.4 Харилцаа холбоо

Засгийн Газар, харилцаа холбооны салбарын хувийн операторууд (дотоодын болон гадаадын), үүрэн телефоны хувийн операторууд, интернетын үйлчилгээ үзүүлэгчид, дуу бичлэгийн студи гэх мэт компаниудтай Банк өөрийн баримталж буй үйл ажиллагааны чиглэлийн хүрээнд хамтран ажиллах, санхүүжүүлэх боломжийг тодорхойлох талаар яриа хэлэлцүүлгээ үргэлжлүүлэн хийнэ. Мөн Банк нь Засгийн Газартай харилцаа холбооны салбарт хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг дэмжих, тус салбарыг өргөн хүрээтэй хөгжүүлэхэд гол хөдөлгөх хүч болох эрх зүйн болон зохицуулалтын орчинг сайжруулах талаар яриа хэлэлцүүлгээ үргэлжлүүлэх болно.

Төрөөс Монголын харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа явуулж байгаа операторуудыг үйлчилгээ үзүүлэх этгээд (МТ), сүлжээ ажиллуулах этгээд (ICNC), эсвэл эдгээр хоёр үйлчилгээг хувьчлан авч нэгдмэл байдлаар хүргэх анхны нэгдсэн оператор гэсэн ангиллаар тусгаарлах арга хэмжээ авчээ. Банкнаас 2004-2006 онд хэрэгжүүлсэн (Монголын харилцаа холбооны салбарын хувьчлалын хувилбар нэртэй) техникийн туслалцааны төслийн хүрээнд энэ бүтцийг боловсронгуй болгох үйл ажиллагааг дэмжин ажилласан билээ. Тус салбарт бүтцийн өөрчлөлт хийх, хувьчлах хувилбаруудыг техникийн туслалцааны төслийн хүрээнд санал болгосон боловч Засгийн Газар санал зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх явцыг 2 жилээр хойшлуулсан нь тухайн бүтцийн өөрчлөлтөөс гарах бодит үр дүнг асар ихээр бууруулсан юм. Гэвч зөвхөн үйлчилгээ үзүүлэгч оператор, зөвхөн сүлжээ ажиллуулах операторуудын аль алиныг хувьчлах, улмаар хосолсон нэгдмэл үйлчилгээ үзүүлэх боломжийг судлахад чиглэсэн Банк Засгийн Газар хоорондын яриа хэлэлцүүлэг үргэлжлэх болно. Нөхцөл бүрдсэн тохиолдолд дээр дурдсан хоёр төрлийн операторуудын аль нэгийг эсвэл хоёуланг санхүүжүүлэх, эсвэл зохих хувьчлалын явцад эдгээр компаниудын хувьцааг худалдан авч буй хувьчлалын хамтрагч байгууллагыг санхүүжүүлэх боломжтой.

Салбарын бүтцийн өөрчлөлт хийх, хувьчлах үйл явцыг дэмжих техникийн туслалцааны хүрээнд Банк Эрх Зүйн Шилжилтийн Баг байгуулж дараах үндсэн гурван чиглэлээр зохицуулалтыг боловсронгуй болгоход төслөөс анхаарч ажиллажээ. Үүнд: эрх зүйн болон зохицуулалтын бодлогыг боловсронгуй болгох; салбарын байгууллагуудад бүтцийн өөрчлөлт хийх; техникийн хэрэгжилтийг хангах зэрэг болно. Техникийн туслалцааны төслийн техникийн хэрэгжилтийг хангах бүрэлдэхүүн амжилттай хэрэгжсэн байхад эрх зүй, бодлогын зохицуулалтыг боловсронгуй болгох, байгууллагын бүтцийн өөрчлөлт хийх бүрэлдэхүүнүүд төдийлөн амжилтанд хүрч чадаагүй ажээ. Ялангуяа Засгийн Газар тус салбарт бодлогын шинэ зохицуулалт хийх, ЕСБХБ-ны туслалцаатайгаар цахим харилцаа холбооны тухай хууль боловсруулах, хэрэгжүүлэхэд шийдмэг алхам хийхгүй байгаа нь туйлын удаашралтай байна. Гэвч бодлогын түвшинд хууль эрх зүй, зохицуулалтын шинэчлэл ямар ахицтай байгаа талаар Банк Засгийн Газар хоорондын яриа хэлэлцүүлэг үргэлжлэх бөгөөд тус салбарт хөрөнгө оруулалтын орчин буй болгох, хөгжүүлэх явдлыг сайжруулахад чиглэсэн техникийн туслалцааны нэг хэсэг болох хуулийг боловсруулан санал болгоод байна.

3.2.5 Эрчим хүчний үр ашиг

ЕСБХБ-ны үйл ажиллагааны орнууд дотроос эрчим хүчний асуудал хамгийн чухалд тооцогддог орнуудын нэг нь Монгол Улс юм. Улаанбаатар хот дэлхийн хамгийн хүйтэн нийслэл хот учраас асар их халаалт шаарддаг. Хэдийгээр эрчим хүчний тарифыг доогуур тогтоосон ч (сүүлийн жилүүдэд өсөж байгаа боловч өртөг нөхөх хэмжээнээс доогуур) эрчим хүчний үр ашгийг нэмэгдүүлэх олон хөшүүрэг байхгүй байна. Энэ тохиолдолд тогтвортой эрчим хүчээр хангах техникийн чадавхи байгаа ч бодлогын

зохицуулалт дутмаг, төрийн байгууллага, мэргэжлийн байгууллагын хүчин чадал хангалтгүй, мэдээлэл жигд бус, технологийн хангалт хязгаарлагдмал гэх зэрэг эрчим хүчний үр ашгийг нэмэгдүүлэх боломж бололцоонд саад тогтор болж байгаа зүйл их байна.

Энэ салбарын зах зээлд хөл тавих хамгийн тохиромжтой стратеги бол бага, дунд оврын эрчим хүчний үр ашгийг сайжруулах болон бага хэмжээний сэргээгдэх эрчим хүчний төслийг дэмжихэд чиглэгдсэн хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэх боломж бололцоог нэмэгдүүлэх, эрчим хүчний үр ашгийн зээлийн хэмжээг тогтоох дотоодын санхүүгийн байгууллагуудтай хамтран ажиллах явдал мөн. Зах зээлийн эрэлт хэрэгцээний судалгааг хийгдэж байгаа ба энэ нь эдийн засаг дахь эрчим хүчний ядмаг байдлыг хэрхэн шийдвэрлэх санхүүгийн арга хэрэгслийг тодорхойлоход чухал алхам болно.

Банк сэргээгдэх эрчим хүчний үр ашиг, зээлийн хэмжээг (Тогтвортой Эрчим Хүчийг Санхүүжүүлэх Байгууламжийн загвар) Монгол Улсын банкны салбараар дамжуулан шаардлагатай техник мэргэжлийн хамтын ажиллагааны дэмжлэг тусалцаатайгаар анхаарч үзнэ. Эдгээр санхүүгийн дэмжлэг тусалцааг (i) аж үйлдвэрийн ялангуяа жижиг дунд үйлдвэрийн эрчим хүчний үр ашгийг нэмэгдүүлэх; (ii) бага оврын сэргээгдэх эрчим хүчний төслийг санхүүжүүлэх; (iii) одоо ашиглагдаж байгаа барилга байгууламжийн эрчим хүчний үр ашгийг сайжруулах болон (iv) эрчим хүчийг тусгаарлах, эрчим хүчний үр ашигтай халаалтын хэрэгслийг суурилуулах замаар орон сууц, айл өрхийн эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэхэд чиглэгдэнэ.

Цаашилбал барилгын салбарт анхаарч ажиллана. Хуучирч, материаллаг элэгдэлд орж байгаа барилга байгууламжид халаалтын хамгаалалтын түвшин доогуур, эрчим хүчний алдагдал ихтэй байдаг учраас голлон анхаарах нь зүйтэй. Засвар үйлчилгээний зохих шаардлагыг хангаагүй, он удаан жил орхигдуулсан, энэ талаар ойлголт байхгүй учраас ийм нөхцөл үүсч байна. Эрчим хүч хэрэглэгчдийн гол үйлчлүүлэгчийн хувьд барилгын салбарт шинэчлэл хийх шаардлагатай тул ЕСБХБанк барилга байгууламжид тогтвортой эрчим хүчний хөрөнгө оруулалт хийх арга хэрэгсэл, шийдлүүдийг санал болгох хэд хэдэн санал санаачилгуудыг боловсруулахаар бэлтгэж байна. Үүнд:

- Барилгын салбарт эрчим хүчийг зохицуулах тогтолцоог сайжруулахад чиглэгдсэн бодлогын дэмжлэг үзүүлэхдээ Киргизстан, Молдавт хэрэгжүүлсэн ижил төрлийн төслийн туршлагаас нэвтрүүлэх
- Бүсийн хэмжээнд эрчим хүчний үр ашиг, зах зээлийн гүйцэтгэлийг хянахад чиглэгдсэн E2C2, ESD болон P&T багуудын хамтын санаачилга болох Эрчим Хүчний Хөтөлбөрт Монгол Улс хамрагдсан. Ингэснээр зах зээлийн саад бэрхшээлийн талаарх дэлгэрэнгүй судалгаа дүн шинжилгээ хийх, эрчим хүчний үр ашгийн боломж бололцоог үнэлэх бүтээлч арга хэрэгслээр хангах боломжтой болох юм;
- Хэрэгжиж байгаа байгаль орчны төслүүдийн эрчим хүчний тогтолцоог судалснаар тэдгээрээс суралцах, туршлага нэвтрүүлэх боломжтой төслүүдийг тодорхойлох боломж олгоно;

Улмаар айл өрх, албан байгууллагууд урт хугацаанд эрчим хүчний үр ашгаас үр шимийг нь хүртэх боломжтой болох боловч орон сууцны салбарт төлбөрийн чадварын асуудал томоохон бэрхшээл болж байгаа юм.

ЕСБХБ Монгол Улсад хэрэгжүүлж байгаа төслийн үйл ажиллагааны улмаас учирч болох байгаль орчны болон нийгмийн асуудал, нөлөөллийн талаар нэгдсэн судалгаа хийх юм. ЕСБХБ нь төслийн үйл ажиллагааны улмаас учирч болох аливаа сөрөг нөлөөллийг багасгах, Монгол Улсын үндэсний байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй байдал, хөдөлмөрийн тухай хууль тогтоомж, стандарт болон 2008 батлагдсан ЕСБХБ-ны Ажлын гүйцэтгэлийн шаардлагуудыг дагаж мөрдөхөд чиглэсэн Байгаль Орчин, Нийгмийн Үйл Ажиллагааны Төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлэхэд үйлчлүүлэгч орны Засгийн Газартай нягт хамтран ажиллана. ЕСБХБ эрчим хүчний үр ашгийг нэмэгдүүлэх, хог хаягдлын удирдлага, байгаль орчны удирдлага болон бусад олон салбарт үйл ажиллагаагаа сайжруулах боломжийг эрэлхийлэн ажиллана.

4. Олон Улсын Санхүүгийн Байгууллагууд болон Олон талт хандивлагч байгууллагууд

ЭЗХАХБ-ын мэдээгээр Монгол Улс жил бүр ойролцоогоор 200-250 сая ам долларын хөгжлийн тусламжийг хилийн чанад, гадаадын байгууллагаас авдаг байна. 2006-2007 оны статистик мэдээг харахад Япон Улс хамгийн их санхүүжилт, удаахад нь Герман, Азийн Хөгжлийн Банк, Дэлхийн Банк, АНУ орж байна. Сүүлийн жилүүдэд Орос, Хятад улстай харилцах Монгол Улсын харилцаа сэргэж хоёр талт хамтын ажиллагааны гэрээ, зээлийн хэлэлцээр байгуулах явдал нэмэгдлээ. Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банк Албан Ёсны Хөгжлийн Туслалцаа үзүүлж буй хандивлагчдын жагсаалтанд ороогүй ч 2008 онд жилд үзүүлсэн хандив тусламжийн хэмжээгээр олон улсын хандивлагч байгууллагуудыг тэргүүлсэн байна.

Хямралыг даван туулахын тулд гол хандивлагч байгууллагууд хамтран ажиллаж, хүчин чармайлтаа нэгтгэн Монголын Засгийн Газарт өнөөгийн бэрхшээлтэй хэцүү хүнд нөхцөл байдлаас гарахад тусалсан байна. ОУВС 229 сая ам доллартай тэнцэх 18 сарын хугацаатай байнгын санхүүжилтын зохицуулалт хийхээр зөвшөөрч буйгаа мэдэгдэж мөн 2009- 2010 онд төсвийн алдагдлыг нөхөхөд зориулан 205 сая ам долларын санхүүжилт өгөх урьдчилсан тооцоолол гаргажээ. Цаашилбал Азийн Хөгжлийн Банк, Дэлхийн Банк, Японы Засгийн Газар гэх зэрэг гол хандивлагчид гуравдугаар сарын дундуур болсон Монгол Улсын гадаадын хамтран ажиллагч түншүүдийн уулзалтаар 160 сая ам долларын тусламж үзүүлэхээр амалсан байна. Хэдийгээр санхүүгийн алдагдал байсаар байгаа ч Монгол Улсад үзүүлэх зээл тусламжийн талаар мэдээлээгүй байгаа бусад гол хандивлагч байгууллагуудын тусламж дэмжлэгийг авбал өнөөгийн санхүүгийн хүндрэлтэй нөхцөл байдлаас бүрэн гарах, санхүүгийн зохицуулалтыг сайжруулах Засгийн Газрын оролдлого, чармайлтыг үргэлжлүүлэх боломжтой гэж үзэж байна.

Гол Олон Улсын Санхүүгийн Байгууллагууд болон Олон Улсын Байгууллагуудын үйл ажиллагааг дор тоймлон өгүүлээ.

4.1 Олон Улсын Валютын Сан (ОУВС)

Монгол Улс 1991 онд ОУВС-нд нэгдэн орсон билээ. ОУВС Монгол Улсын Засгийн Газрын эдийн засгийн шинэчлэл хийх, ядуурлыг бууруулах хүчин чармайлтад ямагт дэмжлэг тусалцаа үзүүлсээр ирсэн юм. 1993 оны 6 сард нийт 40.8 сая ЗТЭ –тэй тэнцэх хэмжээний санхүүжилт бүхий ОУВС-ын гурван жилийн хугацаатай Бүтцийн Өөрчлөлтийг Эрчимжүүлэх Хөтөлбөр батлагдсан боловч 1996 оны 7 сард өөрчлөгдсөн юм. Улмаар 1997 оны 7 сард ОУВС-ийн Гүйцэтгэх Зөвлөл 33.4 сая ЗТЭ-тэй тэнцэх

санхүүжилт бүхий гурван жилийн хугацаатай Бүтцийн Өөрчлөлтийг Эрчимжүүлэх Хөтөлбөр/ Ядуурлыг Бууруулах, Өсөлтийг Хангах Хөтөлбөр баталсан юм. 2001 онд ОУВС-ийн Зөвлөлөөс 28.5 сая ЗТЭ-тэй тэнцэх санхүүжилт бүхий мөн гурван жилийн хугацаатай Ядуурлыг Бууруулах, Өсөлтийг Хангах Хөтөлбөр баталжээ. Гэхдээ тус хөтөлбөр нь 2005 оны 7 сард гурав дахь санхүүжилт, түүний үнэлгээ дүгнэлт хийх боломж олгоогүй давхацсан байна. 2009 оны 4 сард ОУВС Монгол Улсын эдийн засгийг тогтворжуулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор 229 сая ам доллартай тэнцэх 18 сарын хугацаатай байнгын санхүүжилтын зохицуулалт хийхээр зөвшөөрч албан ёсоор баталгаажуулсан байна. Үүнээс 51.1 сая ЗТЭ буюу ойролцоогоор 76.4 сая ам долларыг Монголын Засгийн Газарт нэн даруй шилжүүлсэн байна. Үлдсэн хөрөнгийг улирлын тайлан мэдээг үндэслэн шат дараатайгаар санхүүжүүлэх ажээ.

4.2 Дэлхийн Банкны Бүлэг

Монгол Улс 1991 оны 2 сард Олон Улсын Сэргээн Босголт Хөгжлийн Банк, Олон Улсын Хөгжлийн Агентлаг (ОУХА) болон Олон Улсын Санхүүгийн Корпорацийн гишүүнээр элссэн юм. Дэлхийн Банк Групп нь Монгол Улсад ядуурлыг бууруулах, хувийн хэвшлийг хөгжүүлэх, санхүүгийн салбарыг шинэчлэх, дэд бүтцийг хөгжүүлэх чиглэлээр тусламж дэмжлэг үзүүлэн ажилладаг. ОУХА нь Монгол Улсад техник мэргэжлийн зөвлөгөө, тусламжийг оролцуулан нийт 469 сая ам долларын тусламж үзүүлээд байгаа билээ. Дэлхийн Банк тус улсад нийт 265 сая ам доллар бүхий зээлийн 15 төсөл хэрэгжүүлжээ. 2008 оны 12 сарын 31-ний байдлаар Монгол Улсад үзүүлсэн зээл тусламжийн үзүүлэлт 156.6 сая ам доллар байсан бөгөөд түүнээс 59 сая ам доллар нь буцалтгүй тусламж байв. Дэлхийн Банкны зээл тусламжийг дэд бүтэц, нийгэм, хөдөө орон нутаг, санхүү, хувийн хэвшлийн салбарыг хөгжүүлэх, засаглал, эдийн засгийн удирдлагын төслүүдэд түлхүү зарцуулжээ.

Олон Улсын Санхүүгийн Корпораци нь Монгол Улсад хувийн хэвшлийн салбарт 11 төсөл хэрэгжүүлж нийт 68 сая ам долларийг санхүүжилтийг дараах дөрвөн үндсэн салбарт зарцуулжээ. Үүнд: (i) санхүүгийн салбар, (ii) байгалын баялаг, (iii) дэд бүтэц болон (iv) аж үйлдвэр агро бизнесийн салбарын хөгжил. ОУСК-ын анхны хөрөнгө оруулалтыг 1996 онд арьс шир боловсруулах байгууламжид хийсэн байна. (1.8 сая ам доллар) 2002 онд ОУСК нь жижиг бизнес эрхлэгчид, жижиг дунд үйлдвэрийг санхүүжүүлэх үйл ажиллагааг дэмжихэд зориулан Хасбанкад (0.4 сая ам доллар) хөрөнгө оруулалт хийсэн байна. 2004 онд 5 сая ам долларын үүнээс 1.5 сая ам долларыг өөрийн хөрөнгийн хөрөнгө оруулалтаар болон 3.5 сая ам долларын зээлийг Худалдаа Хөгжлийн Банканд олгох хөрөнгө оруулалтын хоёр гэрээнд гарын үсэг зуржээ. Мөн 2004 онд ОУСК нь Монгол Улсын жижиг бизнес эрхлэгчдэд олгох зээлийг дэмжих зорилгоор Хаан Банкад 1.2 сая ам долларын өөрийн хөрөнгийн болон 1.8 сая ам долларын зээлийн гэрээнд гарын үсэг зурсан билээ.

2008-2011 онд Монгол Улсад үзүүлэх Зээл Тусламжийн Стратеги боловсруулах үйл явц удаашралтай байсан бөгөөд өнөөгийн тулгараад буй хямралыг даван туулах шаардлагын улмаас Дэлхийн Банк 2009-2010 онд Монгол Улсад үзүүлэх тусламжийн дунд шатны баримт бичгийг 2009 оны 5 сард батлан гаргажээ. Тус дунд шатны стратеги нь Монгол Улсад дараагийн 18 сарын хугацаанд үзүүлэх тусламж дэмжлэгийг цар хүрээг тодорхойлсон байна. Гол зорилго нь цаашид гэнэтийн цочмог нөхцөл байдлын улмаас гарч болзошгүй нөлөөллийг бууруулахад шаардлагатай урт хугацааны шинэчлэлийн үйл явцыг анхаарахын зэрэгцээ хямралын нөхцөл байдлыг яаралтай даван туулахад Засгийн Газарт туслах явдал юм. Тус стратеги нь дараах гурван гол салбарт онцгойлон анхаарах юм. Үүнд: байгалын баялагт тулгуурласан эдийн засгийн нөхцөлд санхүүгийн тогтвортой байдлыг сайжруулах; ядуу, эмзэг бүлгийнхнийг хамгаалах; ил

тод, шударга хөрөнгө оруулалтын уул уурхайн салбарт дэмжих, илүү өрсөлдөөнтэй, тогтвортой дунд шатны бизнесийн хөрөнгө оруулалтын орчинг дэмжих зэрэг болно.

4.3 Азийн Хөгжлийн Банк (АХБ)

Монгол Улс 1991 онд Азийн Хөгжлийн Банкны (АХБ) гишүүнээр элсчээ. 1991 оноос хойш АХБ Монгол Улсад нийт 662 сая ам долларын 39 зээл (төсөл) олгожээ. Тус улс 2007-2008 онд Азийн Хөгжлийн Сангаас 100%-ийн буцалтгүй тусламж авах нөхцлийг хангасан байна. Энэ хугацаанд нийт 88.3 сая ам долларын буцалтгүй тусламж бүхий таван төсөл, нэг хөтөлбөр хэрэгжихээр батлагдсан билээ. 2008 оны 12 сарын 31-ний байдлаар Монгол Улсад нийт 175.9 сая ам доллар бүхий 11 зээлийн төсөл идэвхтэй хэрэгжиж байна. Азийн Хөгжлийн Сангаас олгосон буцалтгүй тусламжийн хүрээнд одоо 5 төсөл, 1 хөтөлбөр буюу нийт 6 төсөлд 88.3 сая ам доллар зарцуулагдаад байна. Зээлийг хөдөө аж ахуй, байгалийн баялаг, боловсрол, эрчим хүч, санхүү% эрүүл мэнд, үйлдвэр худалдаа, тээвэр холбоо, усан хангамж, эрүүл ахуй, хог хаягдлын удирдлага гэх мэт төрөл бүрийн салбарт олгожээ. Азийн Хөгжлийн Банкнаас нийт 70.1 сая ам доллар бүхий санхүүгийн болон мэргэжлийн туслалцаа бүхий төслийг (техникийн тусламж) төрөл бүрийн салбарт хэрэгжүүлээ.

2009-2010 онд Монгол Улсад хэрэгжүүлэх Үйл Ажиллагааны Бизнес Төлөвлөгөөг 2009 оны 2 сарын 18 нь Засгийн Газартай зөвшилцөн тохиролцож нийт 147.1 сая ам долларын хөрөнгө оруулалт (зээл болон буцалтгүй тусламж), 8.5 сая ам долларын техникийн тусламж, 11.8 сая ам доллар бүхий Ядуурлыг Бууруулах Японы Сангийн хоёр жилийн төсөл хэрэгжүүлэхээр шийдээд байна. Эдгээр санхүүжилтийг тээвэр, хот байгуулалт, боловсрол, нийгмийн хамгааллын салбаруудад онцгойлон төвлөрүүлэх юм. Тухайлбал, Говийн бүсийг хөгжүүлэх (Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хөтөлбөрийг оролцуулан) логиستيкийн төвүүд байгуулах зэрэг үйл ажиллагаануудыг дурдаж болно. Ихэнх төслийг АХБ-ны зээл болон буцалтгүй тусламжийн хамтарсан санхүүжилтээр санхүүжүүлнэ. АХБ-ны хувийн хэвшлийг дэмжих нэгжээс хувийн хэвшлийн салбарт зориулан 4-5 сая ам долларын санхүүжилт үзүүлэхээр төлөвлөөд байна. Тус хуваарилалтанд бүсийн хэмжээнд хэрэгжиж байгаа төслүүдийг хамааруулаагүй болно

4.4 НҮБ-ийн Хөгжлийн Хөтөлбөр (НҮБХХ)

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөр нь (НҮБХХ) 1973 оноос хойш Монгол Улсад үйл ажиллагаагаа явуулж иржээ. НҮБХХ-ийн Монгол Улсад хэрэгжүүлэх хөтөлбөр болон Монгол Улсад 2007-2011 онд хэрэгжүүлэх Хөтөлбөрийн Үйл ажиллагааны Төлөвлөгөөг 2005 онд тус улсад хийсэн Нэгдсэн Үнэлгээнд тулгуурлан боловсруулсан бөгөөд 2007-2011 онд Нэгдсэн Үндэсний Байгууллагаас Монгол Улсад үзүүлэх Хөгжлийн Хөтөлбөр, Тусламжийн баримт бичгийг 2006 онд Засгийн Газар баталсан юм. 2007 оны 2 дугаар сард Монгол Улсын Засгийн Газар, НҮБХХ тус улсад хэрэгжүүлэх НҮБХХ-ийн Үйл ажиллагааны Төлөвлөгөөнд гарын үсэг зуржээ. Тус төлөвлөгөө нь дараах үндсэн таван хөтөлбөрийг багтаасан байна. Үүнд: (i) МХЗ-ийг хэрэгжүүлж, хүн амын ядуурлыг бууруулах, (ii) арчдилал, хариуцлага, ил тод байдал, (iii) шударга ёс, хүний эрхийг эрхэмлэн дээдлэх, (iv) эрчим хүч, байгаль орчны тогтвортой байдал болон (v) хямралаас урьдчилан сэргийлэх, түүнийг даван туулах. Эдгээр хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд нийт 28.5 сая ам долларын санхүүгийн эх үүсвэрийг зарцуулахаар тооцоолоод байна.

4.5 Европын Холбоо

Монгол Улсын нэг хүнд ногдох орлогын түвшин болон ядуурлын түвшин болон 1990-ээд онд Европын Холбооны ТАСИС хөтөлбөр бүрэн утгаараа хэрэгжиж байсан үетэй харьцуулбал Европын Хороо болон Монгол Улсын хамтын ажиллагаа өнөөдөр харьцангуй хязгаарлагдмал түвшинд байгаа гэж хэлж болох юм. Сүүлийн жилүүдэд хөдөөгийн хөгжил, хөдөөгийн иргэдийн орлогыг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн хоёр талт хамтын ажиллагааны хоёр шинэ хөтөлбөр хэрэгжиж эхлээд байна. Эхний хөтөлбөр нь хөдөөгийн хөдөлмөр эрхэлж буй хүн амын дийлэнх нь малчид байгааг харгалзан хэрэгжүүлж буй Европын Хорооны 9 сая евроны санхүүжилттэй малын эрүүл мэнд, мал аж ахуйн маркетингийн хөтөлбөр юм. Удаах хөтөлбөр нь хөдөөгийн тогтвортой хөгжил, тогтвортой амжиргааг хөхүүлэн дэмжихэд чиглэсэн Европын Хорооны 10 сая евроны санхүүжилттэй хөтөлбөр юм. Эхний хөтөлбөрийг Монголын тал хариуцан хэрэгжүүлж байгаа бөгөөд хоёр дахь хөтөлбөрийг Дэлхийн Банкны итгэлцлийн сангаар дамжуулан Дэлхийн Банк хэрэгжүүлж байгаа билээ. Европын Хороо нь Монгол Улстай харилцах цаашдын хамтын ажиллагааны хувьд 2007-2010 оны хөтөлбөрийн хүрээнд жилд 3.5 сая евро байсан жилийн тусламжийн хэмжээг нэмэгдүүлэхээр төлөвлөж байгаа бөгөөд ялангуяа ядуурлыг бууруулах, улмаар орлогын эх үүсвэр буй болгох, Мянганы Хөгжлийн Зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн бодлого боловсруулах хэрэгжүүлэх байгууллагын чадавхыг дээшлүүлэхэд илүү анхаарч ажиллахаар төлөвлөж байна.

ХАВСРАЛТУУД

ХАВСРАЛТ 1 УЛС ТӨРИЙН НӨХЦӨЛ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ

ХАВСРАЛТ 2 ЭДИЙН ЗАСГИЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

ХАВСРАЛТ 3 БАЙГАЛЬ ОРЧНЫ ҮНДСЭН АСУУДЛУУД

ХАВСРАЛТ 4 ХУУЛЬ ЗҮЙН ШИЛЖИЛТ

ХАВСРАЛТ 5 ЕСБХБ-НААС БАТЛАГДСАН ҮЙЛ АЖИЛЛАГАА

ХАВСРАЛТ 6 ЦААШИД ХЭРЭГЖИХ ТӨСЛҮҮД

ХАВСРАЛТ 7 ТЕХНИКИЙН ХАМТЫН АЖИЛЛАГАА

ХАВСРАЛТ 8 ТЕХНИКИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ТӨСЛҮҮД

**ХАВСРАЛТ 9 УДИРДЛАГЫГ ҮНДСЭЭР НЬ ӨӨРЧЛӨХ/БИЗНЕСИЙН ЗӨВЛӨХ
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР**

ХАВСРАЛТ 10 ХОЁР ТАЛТ ТУСЛАЛЦАА

ХАВСРАЛТ 11 ШИЛЖИЛТИЙН ҮЕИЙН СОРИЛТЫН ҮНЭЛГЭЭ

ХАВСРАЛТ 12 МОНГОЛ УЛСЫН ГАЗРЫН ЗУРАГ

Хавсралт 1 – Улс төрийн нөхцөл байдлын үнэлгээ

1 дүгээр заалтыг дагаж мөрдөж байгаа байдал

Монгол Улс нь ЕСБХБ-ийг үүсгэн байгуулах тухай гэрээний 1 дүгээр зүйлд заасан олон намын тогтолцоотой ардчилал, олонч үзэл, зах зээлийн эдийн засгийн зарчмыг хэрэгжүүлэх бодлогыг тууштай баримталж, тодорхой хэмжээний ахиц дэвшил гаргаж байна. Эдгээр зарчмуудыг хэлбэрэлтгүй дагаж мөрдсөнөөр тус улсын ардчиллын салбарт олсон ололт амжилтыг бататган бэхжүүлж чадна.

Монгол Улсын ардчиллын салбарт гаргасан ололт амжилтын илрэл нь 2009 оны 5 дугаар сард болсон ерөнхийлөгчийн сонгуулийн үр дүнгээр сөрөг хүчнээс нэр дэвшигч ялалт байгуулсан явдал болсон бөгөөд ажиглагчид уг сонгуулийг шударга, чөлөөтэй болсон гэж дүгнэсэн.

Монгол Улс бол олон намын тогтолцоотой, парламентын засаглалтай ардчилсан орон. Шилжилтийн үйл явц эхэслнээс хойш тус улс чөлөөт ардчилсан Үндсэн хуулийг батлан гаргаж, улс төрийн намын өрсөлдөөнт тогтолцоог бүрдүүлж, идэвх санаачлага дүүрэн иргэний нийгэм цогцлууль, зах зээлийн баримжаатай шинэчлэлийг хэрэгжүүлэхэд ахиц дэвшил гаргаж чадсан билээ. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл төрөл бүрийн асуудлуудыг мэдээлэх боломжтой бөгөөд эрх зүйт төрийг хүлээн зөвшөөрч, даган мөрдөн хүний эрхийг хүндэтгэх явдал нэмэгдэж байна.

Ийнхүү онцгой амжилт гаргасан хэдий ч Монгол Улсад олон сорилт бэрхшээл тулгарсаар байна. Тухайлбал, Засгийн Газрыг өөрчлөхөд хүргэж буй улс төрийн хямрал ойр ойрхон тохиолдож, Засгийн Газрууд нийтийг хамарсан ядуурал, амьжиргааны доогуур түвшин, авилга, ашигт малтмалын арвин их баялгийг захиран зарцуулах, эрүүл мэнд, боловсролын үйлчилгээнээс хүртэх боломж нэн ялангуяа хөдөө орон нутагт хязгаарлагдмал байгаа зэрэг чухал асуудлуудтай нүүр тулж байдаг.

Улс төрийн орчин

Монгол Улс бол ОХУ, БНХАУ-тай хил залгаа орших далайц гарцгүй орон юм. Энэ хоёр том гүрэнтэй харилцах харьцаагаа тэнцвэртэй байлгах үүднээс Монгол Улс “туравдагч хөрш” хэмээх ойлголтыг гарган ирж, бүс нутаг, дэлхийн хэмжээний харилцаагаа өргөжүүлэх замаар гадаад харилцаагаа хөрш орнуудаас гадна төрөлжүүлэх зорилго тавьсан.

Тус улс эрс тэс уур амьсгалтай бөгөөд нийгмийн суурь үйлчилгээнд хамрагдах боломж асуудалтай хэвээр байгаа. Монгол Улсын хөгжилд сорилт болж буй томоохон асуудлууд нь ядуурал, ажилгүйдэл, хөдөө орон нуутаг, хот суурин газрын хооронд байгаа үлэмж ялгаа зэрэг болно.

Энэ нөхцөл байдалд Монгол Улс олон намын тогтолцоотой ардчилал, олонч үзэлтэй нийгмийг цогцлоон байгуулах чиглэлээр батлагдахуйц дэвшил гаргаж чадсан. Тус улсад олон улс төрийн намууд үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд жинхэнэ сөрөг хүчин болж чадаж байгаа. Мөн түүнчлэн идэвх санаачлага дүүрэн ТББ-уудын сүлжээ бий болж, тус улсын хөгжилд идэвхтэй оролцож байна. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл ерөнхийдөө чөлөөтэй бөгөөд хүний эрхийн стандартуудыг дагаж мөрдөх явдал нэмэгдэж байна.

1992 онд батлагдсан Үндсэн хуулиар парламентын засаглалын тогтолцоог бүрдүүлсэн. Ерөнхийлөгч нь аливаа хууль тогтоомжид хориг тавих бүрэн эрхтэй хэдий ч 76 гишүүнтэй нэг танхимтай парламентын 2/3-ын саналаар Ерөнхийлөгчийн хоригийг хүлээн авахгүй байж болно. 1990 он гарснаас хойш Монгол Улсад УИХ болон Ерөнхийлөгчийн таван удаагийн сонгууль болж ардчиллын салбарт олсон ололт амжилтаа бататгаж авсан. Эдгээр сонгуулиуд ардчилсан сонгуулийн олон улсын стандартыг нийцсэн гэсэн дүгнэлтийг өгдөг. 2008 оны 10 дугаар сард болсон орон нутгийн сонгуулийн үеэр бага хэмжээний зөрчил бүртгэгдсэн.

Сөрөг хүчин болох Ардчилсан намаас (АН) нэр дэвшсэн Ерөнхий сайдын албыг хоёр удаа хашиж байсан Цахиагийн Элбэгдорж 2009 оны 5 дугаар сарын 24-нд болсон Ерөнхийлөгчийн сонгуулиар 51 хувиар ялимгүй дээгүүр санал авч ялалт байгуулсан. Хараат бус бие даасан ажиглагчид уг сонгуулийг шударга болсон гэж дүгнэсэн. Монгол Ардын Хувьсгалт Намаас (МАХН) нэр дэвшсэн Ерөнхийлөгч Намбарын Энхбаяр 47 хувийн санал авч, Сонгуулийн ерөнхий хорооноос сонгуулийн урьдчилсан дүнг танилцуулахаас өмнө ялагдлаа хүлээн зөвшөөрсөн. Сонгогчдын ирц 74 орчим хувьтай байв.

Сонгууль ойролцоо үр дүнд хүрч, өмнөх оны УИХ-ын сонгуулийг сэвтээсэн иргэдийн үймээн давтагдаж болзошгүй гэсэн айдас биелээгүй. 2008 оны 7 дугаард сонгуулийн үр дүнг зарласны дараа үймээн дэгдээгчид МАХН сонгуульд маргаантайгаар ялалт байгуулсныг эсэргүүцэн гудамжинд гарч жагсаж байсан бол Ерөнхийлөгчийн сонгуулийн үр дүнг зарласны дараа улс оронд амар тайван байдал хадгалагдсан.

Ерөнхийлөгчийн сонгуулийн хоёр нэр дэвшигчийн мөрийн хөтөлбөр төстэй байсан бөгөөд санал асуулгаар маш бага зөрүүтэй өрсөлдөөн болохыг урьдчилан хэлж байсан. Дахин сонгогдохоор нэр дэвшсэн Н. Энхбаяр сонгуулийн өмнөх дөрвөн жилд харуулсан манлайлал нь ялалт байгуулахад туслана гэж найдаж байсан. МАХН ер нь хөдөө орон нутагт сайн дэмжлэг авдаг билээ. Ц. Элбэгдоржийн сонгуулийн кампанит ажил өөрчлөлт, авилгатай тэмцэх асуудлууд дээр төвлөрч, нийслэл хотын сонгогчил уруу түлхүү хандаж ажилласан. МАХН, АН-аас гадна УИХ-д суудалтай Иргэний зориг нам, Ногоон нам гэсэн жижиг намууд Цахиагийн Элбэгдоржийг дэмжиж байгаагаа мэдэгдсэн.

Үндсэн хуульд зааснаар Ерөнхийлөгч нэг удаа дахин сонгогдож болно. Ерөнхийлөгч нь Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг даргалж, зэвсэгт хүчний командлагч байдаг. Засгийн Газар ойр ойрхон солигдох болсноор Ерөнхийлөгчийн үүрэг роль нэмэгдсэн.

Тус улсын үндэсний парламент болон Улсын Их Хурлын гишүүд дөрвөн жилийн хугацаатайгаар шууд сонгогддог. УИХ-ын сонгууль хамгийн сүүлд 2008 оны 6 дугаар сард болж өнгөрсөн бөгөөд хараат бус бие даасан ажиглагчид эцсийн дүндээ шударга, чөлөөт болсон гэж дүгнэсэн.

Монгол Улсын улс төрийн үйл явц МАХН, АН гэсэн хоёр том намын шууд нөлөөн дор явагдаж ирсэн. Ерөнхийлөгч, УИХ-ын хамгийн сүүлийн сонгуулиуд ч онцгой тохиолдолд байгаагүй. УИХ-ын 2008 оны 6 дугаар сард болсон сонгуулийн дүнгээр МАХН хууль тогтоох байгууллага дахь олонхийн байр сууриа нэмэгдүүлсэн хэдий энэхүү үр дүнг АН (тухайн үед АН-ын дарга байсан Цахиагийн Элбэгдорж) нилээд эсэргүүцсэн. Олон мандаттай томсгосон тойргоор явуулсан сонгуульд улс төрийн жижиг намууд төдийлөн амжилттай оролцож чадаагүй.

2008 оны 6 дугаард болсон УИХ-ын сонгуулийн дараахь тодорхойгүй байдал хоёр сар гаруй үргэлжилж АН шинээр сонгогдсон УИХ-д бойкот зарлахаа болисноор 2008 оны 8 дугаар сард дуусгавар болсон. МАХН бие даан Засгийн Газар байгуулахад хангалттай олонхийн суудал авсан хэдий ч АН-ыг бага түнш болгон эвслийн Засгийн Газар байгуулахаар шийдсэн. Эвслийн Засгийн Газрыг МАХН-ын Санжаагийн Баяр тэргүүлж байна.

Засгийн Газрыг шинээр байгуулахдаа тус улсын улс төрийн томоохон хоёр нам эвссэнээр Монгол Улс илүү уялдаа зохицуулалттай хөдлөх боломжийг бүрдүүлсэн. Мөн түүнчлэн дэлхийн санхүү эдийн засгийн хямралын нөлөөгөөр эдийн засаг, нийгмийн тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх шаардлага нүүрлэсэн үед Засгийн Газрыг тогтвортой ажиллуулах нөхцөл бүрдсэн. Гэхдээ АН-ын зарим тэргүүлэгч гишүүд АН эвслийн Засгийн Газарт орох шаардлагагүй байсан хэмээн үзэж, МАХН-ыг эсэргүүцсэн хэвээр байв. Дэлхийн санхүү, эдийн засгийн хямрал, бараа түүхий эдийн үнийн уналтаас улбаалан эдийн засгийн нөхцөл байдал доройтож, хүнд үе ирсэн хэдий ч эвслийн Засгийн Газар ажилласан хэвээр байлаа.

Үндэсний арвин их нөөцийг эдийн засгийн эргэлтэнд оруулах нь Монгол Улсын аль ч Засгийн Газрын хувьд томоохон сорилт байх болно. Ядуу оронд үндэсний болон салбарын эрх ашгийн алтан дундажийг олох нь амаргүй ажил билээ. Төр засгийн уул уурхайн салбарын хөрөнгө оруулагчдын итгэлийг аль болох багаар сөхөрдүүлж, нийт ард иргэдэд нийцсэн тэнцвэртэй шийдлийг олохыг зорьж байна.

Эрх зүйт төр ба хүний эрхийн хамгаалалт

Монгол Улсын ардчилсан шилжилтийн нэг томоохон онцлог бол тус улсын тууштай байр суурь, эрх зүйт төр, хүний эрхийн стандартуудыг дагаж мөрдөж явдал нэмэгдэж байгаа байдал юм. Монгол Улс хэдийгээр ардчиллыг хөгжүүлэх чиглэлээр магтууштай ахиц дэвшил гаргасан ч цаашид сайжруулж бэхжүүлэх зүйлүүд байгаа. Тухайлбал, хариуцлага, ил тод байдал, ардчилсан засаглалыг сайжруулж, төрийн захиргааны төвлөрлийг сааруулах зэрэгтэй холбоотой асуудлууд юм.

Монгол Улс хүний эрхтэй холбоотой бүхий л томоохон гэрээ, протоколд нэгдэн орсны дотор Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын (ОУХБ) үндсэн найман конвенци багтаж байна. Хөдөлмөрийн эрхийн асуудлаар томоохон асуудлууд байхгүй.

Монгол Улс НҮБ-ын Авилгатай тэмцэх конвенцид нэгдэж орж, авилгатай тэмцэх хууль эрх зүйн орчинг бүрдүүлсэн. Авилгатай тэмцэх газар нь авилгын хэргийн мөрдөн байцаалт хийх үндсэн үүрэгтэй. Монгол Улсын хувьд авилга томоохон асуудал байгаа бөгөөд авилгатай тэмцэх илүү бодит үр дүн авчирдаг аргыг хэрэглэх хэрэгтэй байна. Ц. Элбэгдорж Ерөнхийлөгчийн сонгуульд өрсөлдөхдөө авилгатай тэмцэнэ гэсэн уриан ажилласан нь олон сонгогчдын хүссэн зүйл байсан нь мэдээж.

Засгийн Газар иргэдийнхээ хүний эрхийг ерөнхийдөө хүндэтгэдэг. Хараат бус бие даасан хяналтын байгууллагууд дараахь асуудлуудыг тайландаа дурьдсан байдаг. Үүнд: хүүхдийг эрхийг зөрчих, эмэгтэйчүүдийг эсрэг хүчирхийлэл, олон улсад хүн наймаалах, шүүх тогтолцоон дахь авилга, хорих газар, саатуулах байрууд дахь цагдаагийн байгууллагын хэрцгийлэл эдгээр болно.

Хэвлэл мэдээлэл ерөнхийдөө чөлөөтэй бөгөөд төр засгийн бодлогыг хатуу шүүмжилдэг. Интернетийн ашиглалтанд ямар нэгэн хязгаарлалт байхгүй. Хэвлэл мэдээллийн хэрэгслийн хараат бус бие даасан ажиглалтаас харахад хэвлэлийн эрх чөлөөг зөрчих нь

ховор хэдий ч төр засаг өөрийн эзэмшлийн үндэсний телевиз, радиогоор дамжуулан үйл ажиллагаагаа сурталчилж байна. Сонгуулийн дараа нийслэл хотод үймээн дэгдсэнтэй холбогдуулан 2008 оны 7 дугаарын 1-4-ний өдрүүдэд онцгой байдал зарласан үед зөвхөн төрийн өмчит телевиз, радио үйл ажиллагаагаа явуулж байсан. 7 дугаар сарын 1-ний үйл явдлын үеэр сурвалжлагчдын эсрэг хүчирхийлэл гарсан. Монгол Улсад олон сонин хэвлэл байдаг ч гол төлөв цөөхөн тоогоор хэвлэгддэг.

Хавсралт 2 – Эдийн засгийн зарим үзүүлэлтүүд

	2003	2004	2005	2006	2007	2008	2009
Үйлдвэрлэл, Зардал	<i>(Өөрчлөгдсөн хувь бодит утгаар)</i>						
ДНБ	5.9	10.1	7.3	8.6	10.2	8.9	1.0
Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл	3.0	15.0	9.6	7.0	6.9	1.5	na
Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэл	3.7	17.7	10.7	7.5	15.8	5.0	na
Ажил эрхлэлт	<i>(Өөрчлөгдсөн хувь)</i>						
Ажиллах хүчин /жилийн эцсээр/ ¹	6.4	2.7	1.5	4.2	1.1	1.3	na
Ажил эрхлэлт /жилийн эцсээр/	6.4	2.6	1.9	4.3	1.4	1.7	na
Ажилгүйдэл /жилийн эцсээр/ ²	3.5	3.6	3.3	3.2	2.8	2.8	na
Үнэ ба цалин хөлс	<i>(Өөрчлөгдсөн хувь)</i>						
Хэрэглээний үнэ /жилийн дундаж/	5.1	8.3	12.7	5.1	9.0	26.7	8.1
Хэрэглээний үнэ /жилийн эцсээр/	4.7	11.0	9.5	6.0	15.1	23.2	7.5
Нийлүүлэгчийн үнэ /жилийн дундаж/	na	na	na	na	na	na	na
Нийлүүлэгчийн үнэ /жилийн эцсээр/	na	na	na	na	na	na	na
Эдийн засаг дахь сарын нийт орлогын дундаж	22.0	30.4	5.4	26.2	35.5	58.5	na
Улсын хэвшил	<i>(ДНБ-д эзлэх хувь)</i>						
Улсын төсвийн алдагдал/ашиг[3]	-3.7	-1.9	2.6	3.3	2.8	-5.0	-6.0
Улсын төсвийн зардал[3]	37.1	35.0	27.5	33.3	38.1	40.2	na
Засгийн Газрын өр[4]	87.7	72.2	56.6	43.0	36.3	33.2	na
Мөнгөний салбар	<i>(Өөрчлөгдсөн хувь)</i>						
Нийт Мөнгө M2 /жилийн эцсээр/	49.6	20.5	37.2	30.8	57.3	-5.5	na
Дотоодын зээл /жилийн эцсээр/	160.8	19.9	35.9	-7.4	72.5	24.6	na
Нийт Мөнгө M2 /жилийн эцсээр/	42.4	39.3	41.8	40.9	52.0	36.9	na
Хүү, Валютын ханш	<i>(жил хувиар, жилийн эцсээр)</i>						
Төв банкны бондын хүү	11.5	15.8	4.8	6.4	9.9	14.8	na
Хадгаламжийн хүү ⁵	14.0	13.2	12.6	13.5	13.4	11.7	na
Зээлийн хүү ⁵	25.5	24.0	21.6	20.0	17.1	18.6	na
Валютын ханш /жилийн эцсээр/	1,168.3	1,211.8	1,221.0	1,165.0	1,170.0	1,267.0	na
Валютын ханш /жилийн дундаж/	1,142.7	1,185.2	1,205.2	1,179.7	1,169.8	1,165.7	na
Гадаад орчин	<i>(сая доллараар)</i>						
Урсгал данс	-99	26.6	29.2	222.0	265.0	(721.9)	-262
Худалдааны тэнцэл	-199	(149.1)	(155.0)	29.0	(54.0)	(612.5)	-201
	627.3	872.0	1,069.0	1,545.0	1,949.0	2,534.5	1858
	826.6	1,021.1	1,224.0	1,516.0	2,003.0	3,147.0	2059
Гадаадын шууд хөрөнгө оруулалт, цэвэр	131.5	129.0	258.0	290.0	360.0	585.5	410
Нийт нөөц, алт оруулахгүйгээр /жилийн эцсээр/	178	208.0	333.0	718.0	1,001.0	657.0	na
Гадаад өр	1287	1,429.0	1,433.0	1,529.0	1,703.0	1,961.0	na
				<i>(импортын бараа үйлчилгээ сараар)</i>			
Нийт нөөц, алт оруулахгүйгээр /жилийн эцсээр/	2.0	1.8	2.5	4.6	5.0	2.2	na

Өрийн үйлчилгээ	34.0	7.4	(экспортын бараа үйлчилгээ сараар)				na
			2.9	2.2	2.1	2.0	
Гол үзүүлэлтүүд							
Хүн ам /жилийн эцсээр, сая/	2.6	2.6	2.6	2.6	2.6	2.7	na
ДНБ /сая төгрөгөөр/	1,660.4	2,154.2	2,780	3,715	4,600	6,130	6,294
Нэг хүнд ногдох ДНБ /ам доллараар/	562.7	695.2	871	1191	1489	1970	na
ДНБ-д аж үйлдвэрийн эзлэх хувь /хувиар/	25.3	20.9	31.1	36.0	35.3	34.0	na
ДНБ-д хөдөө аж ахуйн эзлэх хувь /хувиар/	20.1	20.9	21.7	19.5	20.5	18.8	na
Урсгал данс/ ДНБ /хувиар/	(6.8)	1.5	1.3	7.0	6.7	-13.7	-6.0
Гадаад өр - нөөц /сая ам доллараар/	1,109.0	1,221.0	1100	811	702	1304	na
Гадаад өр/ДНБ /хувиар/	88.6	78.6	62.1	48.6	43.3	37.3	na
Гадаад өр/ бараа үйлчилгээний экспорт /хувиар/	154.1	118.2	96.6	75.3	67.5	65.3	na
¹ Хөдөлмөр эрхлэлтийн газар бүртгэлтэй хөдөлмөрийн чадвартай хүн амын тоо							
⁴ Төв засгийн газрын шууд болон тооцоолсон өр, засгийн газрын шууд болон баталгаатай зээл							
² Албан ёсоор бүртгэгдсэн.							
⁵ Бүх хугацааны зээлийн жигнэсэн дунджаар							
[3] Улсын төсвийн орлого, зарлага/нийт зээл, буцалтгүй тусламж/							

Хавсралт 3 – Байгаль орчны асуудлууд

Байгаль орчны гол асуудлууд

Монгол Улсыг зургаан бүсэд хувааж авч үзэж болно. Үүнд: уулархаг, уулархаг тайга, тайга, уулархаг ой тал, хуурай тал болон элсэн цөл. Монгол Улс газар зүйн хувьд олон бүсэд хуваагдаж байгаа учраас түүний ургамал, амьтан ч олон төрөл зүйтэй. Уулархаг бүсэд зарим устах аюулд орсон амьтад (тухайлбал аргал, угалз, цоохор ирвэс, хадны сойр, ятуу), ургамал (тухайлбал, Сибирийн одой нарс, цагаан дэгд) байдаг. Тайган ой Монгол Улсын хойд хэсэгт байдаг бөгөөд нутаг дэвсгэрийн 5 орчим хувийг эзэлдэг. Энэ хавийн ой модонд Сибирийн нарс, хар мод давамгайлан ургасан бөгөөд Монгол Улсын улаан номонд орсон амьтны төрөл зүйлүүд тухайлбал, заарт буга, хандгай, шилүүс, Евразийн халиу байдаг. Уулархаг ой, талын бүс нийт нутгийн 25 хувийг эзэлдэг ба дэлхийд устах аюулд орсон амьтад болох мануул, хар ятуу зэрэг, мөн алтан хундага зэрэг үгүй болох аюулд орсон ургамал ургадаг. Монголын талд олон төрлийн өдлөг өвс ургаж, бөхөнгийн орчинг бүрдүүлж өгдөг. Цөлөрхөг тал нь хулан, цагаан зээр, хар сүүлт зээр, жороо тоодогийн амьдрах орчин болдог. Цөлийн бүс тус улсын өмнөд болон баруун өмнөд хэсэгт оршдог бөгөөд эртний үеийн амьтан ургамал, ашигт малтмал байдаг. Мөн түүнчлэн хавтгай, мазаалай, замба гүрвэл зэрэг усгах аюулд орсон амьтны зүйл байдаг.

Монгол Улсын ургамал, амьтны ач холбогдлыг харуулан хадгалж үлдээхийн тулд Засгийн Газраас 28 дархан цаазат газрыг байгуулсан. Тусгай хамгаалалттай газар нутаг нийт хатуу газрын 13.1 хувийг эзэлж байна. Зэрлэг байгаль дээр байгаа ургамал, амьтны төрөл зүйл, экосистемийн одоо байгаа төрлийг тогтвортой байлгахын тулд

Байгаль орчны яамнаас 2030 он гэхэд нийт хатуу газрын 30 хувийг тусгай хамгаалалтанд авах, түүний дотор үндэсний хүрээлэн болгох зорилт дэвшүүлээд байна.

Монгол Улсад тулгараад байгаа, анхаарлаа хандуулан арга хэмжээ шуурхай авах шаардлагатай хэд хэдэн асуудлууд байна. Уул уурхайн үйл ажиллагаа өргөн цар хүрээтэй явагдсаны улмаас хөрс доройтсон, хөрсний нөхөн сэргээлт хийгдэхгүй байх; суурин газрын ойролцоох бэлчээр талхлагдаж, газар тариалангийн зориулалттай газар шавхагдсан нь эдгээр асуудлуудын жишээ юм. Хохирол учирч шавхагдсан газрын нийт хэмжээ 121.7 сая га болсон гэсэн тооцоо байдаг.

Монгол Улсад тулгарч буй өөр нэг сорилт нь цөлжилттэй тэмцэх явдал юм. Цөлжилт дараахь байдлаар илэрч байна. Үүнд: өвс ургамын давхарга цөлжих, намаг бүхий экосистем хатах, элсэрхэг газар нутгийн хэмжээ нэмэгдэх. Өнөөдөр Монгол Улсын нутаг дэвсгэрийн 42.5 хувь нь цөлийн ангилалд багтаж байна. Ой устаж байгаа нь хууль бус мод бэлтгэл, зохистой бус ойн менежмент, хүн судлалын сөрөг нөлөөлөлтэй холбоотой.

Монгол Улсын нутаг дэвсгэрийн 11.8 хувийг ойн сангийн бүрхүүлтэй гэж үздэг боловч ойн сангийн дөнгөж 69.4 хувь нь шигүү ой, модлог буттай байна. Харин нийт нутаг дэвсгэрийн 8.2 хувь нь сийрэг ой, бутлаг ургамалтай байна.

Монгол Улс усны нөөцөөр хязгаарлагдмал юм. Хэрэглээний усны нөөц 34.6 куб километрээс бүрдэж байгаагийн 4.96 куб километр нь гадаргын ус, 0.4 куб километр эх гүнийн ус байна. Үйлдвэрлэлийн хэрэглээ нэмэгдэж, уул уурхайн үйл ажиллагаанаас бохирдол үүсч, бохир ус цэвэршүүлэх зохих стандартын байгууламж байхгүй байгаагаас усны нөөц багасч байна (улсын хэмжээнд бохир ус цэвэршүүлэх байгууламжийн 60 хувь нь бохир усыг бүрэн цэвэрлэж чаддаггүй эсвэл ашиглалтаас гарсан байна). Амьдрах орчин нь алдагдсан, хэт их ашигласан, хууль бус агнуурын улмаас биологийн төрөл зүйлд нүүрлэж буй аюул нь мөн томоохон асуудал болж байна.

Монгол Улсын хот суурин газарт, нэн ялангуяа Улаанбаатар хотод агаарын чанар үлэмж том асуудал юм. Агаарын бохирдлын үндсэн шалтгаан нь 3 дулааны цахилгаан станц, нэгдсэн халаалтын системийн 200 орчим жижиг, дунд хэмжээний нам даралтын зуухнууд, гэр хорооллын уламжлалт зуух юм. Нам даралтын зуух галладаг улиралд 11 мянган тонн үнс, нүүрсний хаягдал агаарт хаягддаг. Тээврийн хэрэгслийн тоо нэмэгдэж байгаа нь агаарын бохирдолд нэрмээс болж байна; Монгол Улсад бүртгэлтэй 140 мянган тээврийн хэрэгслийн 70 хувь нь 7-оос дээш жилийн ашиглалтын хугацаатай бөгөөд экологи, аюулгүй байдлыг стандартуудыг хангахгүй байна. Хатуу хог хаягдлыг оновчтой зайлуулж чадахгүйгээс хот суурин газарт томоохон асуудал болоод байна. Улсын хэмжээнд 447 хогийн цэгт жилдээ 10,730 мянган куб метр хатуу хог хаягдал хуримтлагдаж байгаагийн 220 цэг нь зөвхөн нийслэл Улаанбаатарт байна. Монгол Улсад эрүүл ахуйн шаардлага хангасан хогийн оршуулга гэж байхгүй учраас хатуу хог хаягдал эхлээд хот суурин газрын захаар байдаг овоонууд дээр хуримтлагдаж, дараа нь гурван задгай хогийн оршуулгын аль нэгэн үрүү нь зөөвөрлөгддөг.

Монгол Улсад зөвхөн өвлийн улиралд болдог байгалийн аюул (зуд гэх) нүүрлэж олон тооны мал хорогдоход хүргэдэг. Зун их гантай, өвөл нь хүйтэн бөгөөд их цастай байх үед ийм гамшиг тохиолддог; зарим нутагт бэлчээр талхлагдаж, тал үгүй болж, байгалийн ерөнхий доройтлын улмаас байдал улам хүндэрдэг.

Байгаль орчны үндэсний хөтөлбөр (БОҮХ)

Монгол Улс Байгаль орчны үндэсний хөтөлбөрийг 1993 онд боловсруулж гаргасныг 2000 онд шинэчилж, 2010 он хүртэлх авах арга хэмжээг багтаасан байдаг. Үндэсний хөтөлбөрт Засгийн Газрын тэргүүлэх чиглэлийг тогтоон асуудлуудыг гаргаж ирэн байгаль орчны чанарыг хангах, байгалийн нөөцийг хамгаалах, институцийн чадавхийг бэхжүүлэх арга хэмжээнүүдийг зааж өгсөн. Үндэсний хөтөлбөр үндсэн гурван хэсэгтэй. (1) байгаль орчны гол асуудлууд. Энэ хэсэг дөрвөн дэд хэсэгтэй: байгаль орчны хамгаалал, байгалийн нөөцийн удирдлага, хамгаалал, байгалийн гамшигтай тэмцэх; (2) нийгмийн болоод эдийн засгийн асуудлууд; (3) бусад механизм ба хариу арга хэмжээ. Үндэсний хөтөлбөрт цөлжилт, ойжуулалт, биологийн тархац, ус, амьтан ургамлын ховор зүйлийг хамгаалж үлдээх зэрэгч чиглэлийн 25 орчим байгаль орчны дэд хөтөлбөрүүд багтсан. Дэд хөтөлбөрүүд бодлогын баримжаатай болон арга хэмжээний хөтөлбөрүүдэд хуваагддаг. Санхүүгийн асуудлын улмаас үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт, мөрдөлт муу байна. Үндэсний хөтөлбөрт нарийвчилсан ажлын төлөвлөгөө тусгагдсан боловч зардал төсвийн тооцоолол байхгүй байна. Хөрөнгө мөнгө дутагдалтай байгаа учраас хөтөлбөрийн хэрэгжилтэнд саад болж байна. Үндэсний хөтөлбөрт багтсан 25 дэд хөтөлбөрийн дөнгөж 2-3 нь л салбар дамнасан шинжтэй учраас УИХ-ын түвшинд хэлэлцэгдэн батлагддаг, илүү их анхаарлын төвд байдаг, хөрөнгө мөнгө илүү хуваарилагддаг. Төслүүдийн заримыг Засгийн Газрын түвшинд баталдаг учраас яам тамгын газар, холбогдох талууд хоорондын хамтын ажиллагааг, улмаар хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг хангаж өгдөг. Харин арга хэмжээний хөтөлбөрүүдийг өөрийн болгон хэрэгжүүлэх чин эрмэлзлээс гадна салбарын хоорондын хамтын ажиллагаа хязгаарлагдмал болдог.

Байгаль орчны хууль тогтоомж

Одоогоор байгаль орчны 28 бие даасан хууль, 160 орчим журам, стандарт хүчин төгөлдөр мөрдөгдөж байна. Байгаль орчны гол хуулиуд гэвэл Байгаль орчны хамгааллын тухай хууль (1995 он), Тусгай хамгаалалттай газрын тухай хууль (1997 он); Байгалийн нөөц ашиглалтын төлбөрийн тухай хууль (1995-1997 онууд), Ой мод, ан амьтад, агнуурын тухай хууль (1995 он), Газрын нөөцийг хамгаалах тухай хууль (1995 он) болон Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний тухай хууль (1997) юм. 2006 оны 7-р сарын дундуур УИХ Ашигт малтмалын тухай хуулийн шинээр батлан гаргасан. Байгаль орчны яамны хэлж байгаагаар уул уурхайн компанид тусгай зөвшөөрөл олгохоос өмнө байгаль орчны нөлөөллийн үнэлгээг заавал хийлгэсэн байхаар Ашигт малтмалын хуулинд заажээ. Гэхдээ шинэ хуулинд уул уурхайн компани уурхайг хаах, орхин гарах төлөвлөгөөг заавал гаргах эсвэл уурхайг хаах, орхин гарах санг байгуулах эсэх асуудал тусгагдсан эсэх нь тодорхойгүй байна.

Монгол Улс Озоны давхаргыг хамгаалах тухай Венийн конвенци, Озоны давхаргыг устгадаг элементийн тухай Монреалийн протокол, Биологийн тархацын конвенци, Уур амьсгалын өөрчлөлтийн конвенци, Цөлжилттэй тэмцэх конвенци, Хүрээлэн буй орчны устах аюулд орсон амьтан, ургамлын зүйлийн олон улсын худалдааны конвенци, Ауялтай хог хаягдал хил давуулан тээвэрлэх, устгах тухай Базелийн конвенци, Намгийн тухай Рамсарын конвенци, Нүүдлийн зэрлэг амьтны зүйлийг хамгаалах конвенци болон Киото протоколд нэгдэн орсон. Гэхдээ Хил дамнасан байгаль орчны нөлөөллийн үнэлгээний тухай Эспүүгийн конвенци, Мэдээлэл олж авах, шийдвэр гаргалтан дахь олон нийтийн оролцоо, байгаль орчны асуудлаар хууль зүйг ашиглах тухай Аархусын конвенцид одоогоор нэгдэн ороогүй байна.

Байгаль орчны төрийн бус байгууллагууд (ТББ)

Төрийн бус байгууллагын тухай анхны хууль 1997 онд батлагдаж, Монгол Улсад ТББ-ын хөдөлгөөн үүсэж эхэлжээ. Байгаль орчны чиглэлийн ТББ-уудын хөгжлийн хамгийн идэвхтэй үе нь 2000-2001 онууд бөгөөд олон улсын хандивлагчид ихээхэн дэмжлэг үзүүлдэг байна. Байгаль орчны ТББ-ын ихэнх нь Улаанбаатар хотод байдаг хэдий ч сүүлийн үед аймгийн түвшинд идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг ТББ-ууд гарч ирж байна. Гэхдээ ТББ-уудын удирдлагын чадавхи муу байна. Байгаль орчны ТББ-ын ихэнх нь голдуу байгаль орчны боловсрол, сургалтын үйл ажиллагаа явуулж, байгаль хамгаалал, ойжуулалтын талаар төдийлөн ажиллахгүй байна.

Бусад олон улсын байгууллагуудын үйл ажиллагаа

Монгол Улсад хэд хэдэн байгаль орчин, хөгжлийн олон улсын байгууллага, хөтөлбөрүүд хэрэгжиж байна.

НҮБХХ-өөс Монгол Улсын Байгаль орчны засаглалын бэхжүүлэх төслийг хэрэгжүүлж байна. Төслийн зорилго дараахь болно. Үүнд: (1) байгаль орчин, төсвийн гол хууль тогтоомж, бодлогыг нийцүүлж, байгаль орчны зөв засаглалыг бүх түвшинд хөгжүүлэх, (2) институцийн механизмыг бэхжүүлж, байгаль орчны бодлогыг орон нутаг, төвийн түвшинд хэрэгжүүлж хяналт тавих, (3) олон нийтийн оролцоо, мэдээллийг нээлттэй болгох явдлыг бүх шатанд хэрэгжүүлэх замаар оролцогч талуудын байгаль орчны шийдвэр гаргалт, мониторинг дахь оролцоог нэмэгдүүлэх. Тус улсад нүүрлэсэн байгаль орчны ноцтой гамшигийн дараагаар НҮБХХ Люксембургийн Засгийн Газартай хамтран Монгол Улсын гамшигтай үр дүнтэй тэмцэх чадавхийг бэхжүүлж байна. НҮБХХ-ийн дэмжлэгтэйгээр 2004 онд Улсын Онцгой Байдлын Газрыг байгуулж, гамшигтай тэмцэх институцийн болоод хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэхэд чиглэсэн НҮБХХ-ийн дэмжлэг үргэлжилсээр байна. Мөн түүнчлэн НҮБХХ байгалийн нөөцийн тогтвортой ашиглалт, удирдлага чиглэлээр нутгийн иргэдийн болоод орон нутгийн байгууллагад эрх мэдэл олгох, мөн Алтай, Саян, Говийн бүсийн нутагт биологийн тархацыг хамгаалах санал санаачлагыг дэмжихийн зэрэгцээ эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдэд ур чадвар олгох сургалт зохион байгуулах, харилцааны хүрээ үүсгэх, мэдлэгийн менежмент, байгаль орчинд хохиролгүй орлогын эх үүсвэр бий болгох үйл ажиллагаануудыг хэрэгжүүлж байна.

Дэлхийн Банк Уул уурхайн салбарын институцийг бэхжүүлэх техник туслалцааны төслийг хэрэгжүүлж байна. Төсөл дөрвөн бүрдэл хэсэгтэй. Үүнд: (а) уул уурхайн орлогыг удирдах, эдийн засаг, салбарын бодлого боловсруулах чадавхийг бэхжүүлэх; (б) уул уурхайн салбарын хөгжлийг удирдан зохицуулах чадавхийг сайжруулах; (в) төрийн хувь оролцоог удирдах чадавхийг бий болгох; (г) төслийн удирдлага.

Дэлхийн байгаль хамгаалах сангийн 2003-2010 оны хөтөлбөр нь тус сангийн дэлхийн хөтөлбөр болон Алтай, Саяны экологийн бүсэд хэрэгжүүлэх арга хэмжээний хөтөлбөрт тодорхойлогдсон байгаль хамгаалах тэргүүлэх чиглэлтэй нийцэж байна. Энэ хүрээнд биологийн тэргүүлэхийг зүйлийг хамгаалах, цэнгэг усны экосистемийг хамгаалахад чиглэж, амьтдын хууль бус наймаа, уул уурхайн тогтвортой бус ашиглалт, талхлагдсан бэлчээр, байгалийг нөөцийг ашиглах санаархлын улмаас биологийн зүйл, тархацад нүүрлэж буй аюул заналыг судалж байна.

Хавсралт 4 – Хууль эрх зүйн шилжилт

Монгол Улсын Арилжааны эрх зүй


ЕСБХБ нь өөрийн үйл ажиллагаа нь явагдаж буй улс орнуудын хууль эрх зүйн шилжилтийн үнэлгээг хийх аргачлал боловсруулж, хэд хэдэн удаа үүнийгээ шинэчлээд байна. Үнэлгээ хийхдээ хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд хамаарах дараахь чиглэлд анхаардаг. Үүнд: хөрөнгийн зах зээл, компанийн хууль ба компанийн засаглал, концесси, төлбөрийн чадваргүйдэл, барьцаатай гүйлгээ ба харилцаа холбоо. Үнэлгээнд ашиглагдаж буй арга хэрэгсэл нь “хүчин төгөлдөр мөрдөгдөж буй” хууль тогтоомийн чанар (мөн “далайц” гэж хэлдэг) болон тэдгээр хууль тогтоомжийн бодит хэрэгжилт (мөн “үр дүнтэй байдал” гэж хэлдэг) үнэлдэг. Эдгээр үнэлгээний бүх үр дүнг www.ebrd.com/law хаягаар орж харах боломжтой. Энэхүү хавсралтанд Монгол Улсын үнэлгээний үр дүнг тоймлон танилцуулсан бөгөөд үнэлгээг гардан хийсэн ЕСБХБ-ны хуулийн шинжээчдийн шүүмж дүгнэлтийг мөн багтаасан.

Компанийн тухай хууль ба компанийн засаглал

Компанийн засаглалын асуудлуудыг үндсэндээ 1999 оны 7-р сарын 2-нд анх батлагдаж, хэд хэдэн удаа нэмэлт өөрчлөлт орсон Компанийн тухай хуулиар зохицуулдаг. 2007 оны 12-р сард Санхүүгийн зохицуулах хорооноос Монгол Улсын Компанийн засаглалын кодыг боловсруулж гаргасан. Компанийн засаглалын код нь заавал болон сайн дураар дагаж мөрдөх заалтуудтай бөгөөд сайн дураар дагаж мөрдөх заалтуудыг “даган мөрд эсвэл тайлбарла” гэдэг горимоор хэрэгждэг.⁶

ЕСБХБ 2007 оны 11-р сард компанийн засаглалын хууль тогтоомжийн чанарт үнэлгээ хийж, Компанийн засаглалын салбарын 2008 оны үнэлгээний тайланг гаргасан бөгөөд уг тайланд дурьдсанаар, (доорхи зургийг үзнэ үү) Монгол Улс олон улсын холбогдох стандартуудыг (ЭЗХАХБ-ын Компанийн засаглалын зарчмууд) “дунд зэргээр дагаж мөрддөг” дүн гарчээ. Тайланд онцлон тэмдэглэсэн дутагдалтай асуудлуудын дунд хувьцаа эзэмшигчдийн эрхийг тодорхойлох хууль тогтоомж, мэдээллийг нээлттэй болгох, ил тод байдлыг сайжруулах шаардлагатай байна.

Компанийн засаглалын хууль тогтоомжийн чанар – Монгол Улс (2008)



⁶

Кодыг англи хэвээр дараахь хаягаар авах боломжтой.
<http://www.ebrd.com/country/sector/law/corpgov/codes/index.htm>

Тайлбар: Тэнхлэгийн төвөөс аль болох хол байх нь сайн үзүүлэлт, ө.х., ЭЗХАХБ-ын Компанийн засаглалын зарчмуудтай нийцсэн гэсэн үг. Энэхүү “тор” том байхын хирээр тухайн улсын компанийн засаглалын хууль тогтоомж тэдгээр зарчмуудтай ойролцоо байна.

Эх сурвалж: ЕСБХБ-наас гаргасан Компанийн засаглалын салбарын үнэлгээ, 2008.

2005 онд ЕСБХБ-наас компанийн засаглалын үр дүнг шалгах (хууль бодит байдал дээр яаж ажилладаг) судалгаа явуулсан. Энэ хүрээнд хувьцаат болон хувьцаат бус компанийн хувьд холбогдогч этгээдийн гүйлгээтэй холбоотой кейс дасгал бэлтгэжээ. Кейс дасгал дээр компанийн холбогдолтой мэдээ мэдээлэл олж аван компани холбогдогч этгээдтэй гүйлгээ хийсэн эсэх, мөн хохирол учирсан нөхцөлд нөхөн төлүүлэх боломжтой эсэх талаар ойлгохыг зорьж буй жижиг хувьцаа эзэмшигчийн байр суурийг судалжээ. Дараа нь хууль тогтоомжийн үр дүнтэй байдлыг үнэлэхдээ үндсэн дөрвөн хувьсагч ашиглажээ. Үүнд: институцийн орчин, хэрэгжүүлэх боломж, нарийн түвэгтэй байдал болон хурд. Судалгаагаар мэдээллийг нээлттэй болгох, нөхөн төлбөр авах журам нь нарийн түвэгтэй, нэн ялангуяа хяналтын багцыг эзэмшигч хамтран ажиллахаас шууд татгалзвал асуудлыг шийдвэрлэхэд хүндрэлтэй болохыг тогтоожээ. Компанийн холбогдолтой мэдээ мэдээлэл ерөнхийдөө найдвартай бус, хууль ёсны аудиторууд хараат бус бие даасан байдлаар ажлаа гүйцэтгэх боломжгүй байна. Ингэснээр мэдээллийг нээлттэй болгох шаардлага нааштайгаар шийдвэрлэгдэх боломжийг бууруулж байна. Хуулийг тайлбарлахад удирдамж болж өгөх учиртай шүүхээс гаргаж байсан шийдвэрүүд дээр үндэслэсэн нийтлэг хууль байхгүй учраас шүүхийн шийдвэрийн тодорхой байдалд сөргөөр нөлөлж байна. Хуулийг хэрэгжүүлэх журмууд нь хэцүү бөгөөд цаг хугацаа маш их шаарддаг. Нөхөн төлбөрийн тухайд доод шатны шүүх компанийн хуультай холбоотой хэргүүдтэй ажиллах туршлага, эрх хэмжээ дутагдалтай, байгаа нь судалгаагаар илэрчээ. Мөн түүнчлэн доод шатны шүүх аль нэг талын эрх ашигт үйлчлэх хандлагатай, нэн ялангуяа нэр нөлөө бүхий яллагдагчийн хэрэг дээр ийм байдал ажиглагддаг болох нь харагджээ. Хууль тогтоогчид хууль тогтоомжийн хүрээ, түүнийг бодитой хэрэгжүүлэх институцийн чадавхийг зохих сургалт, ур чадвар дээшлүүлэх хөтөлбөрөөр дамжуулан сайжруулахад анхаарах хэрэгтэй байна.

Концесси

Монгол Улсад төр, хувийн хэвшлийн түншлэлийг хөхиүлэн дэмжих бодлогын ерөнхий хүрээнээс гадна концессийн тухай хууль байхгүй байна. Гэхдээ Төрийн, орон нутгийн өмчийн тухай хуулийн зарим зүйл заалтууд концессийн харилцааг хамардаг. Цаашилбал, төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн төслийг шинээр боловсруулж, бусад төрлийн гэрээний зэрэгцээ концессийн харилцааг зохицуулах талаар олон саналууд сүүлийн гарсан байна.

Монгол Улсын Засгийн Газрын 2008-2012 оны мөрийн хөтөлбөр, санхүүгийн хямралын зохицуулах хөтөлбөрт төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн төслийг боловсруулах ажил орсон байсан. Үндэсний хөгжил, шинэтгэлийн хорооноос уг хуулийн төслийг боловсруулах ажлын хэсгийг байгуулсан бөгөөд 2009 оны 5 дугаар сард хуулийн төслийн анхны хувилбарыг хэлэлцүүлэгт зориулан танилцуулсан.

Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн дагуу эрх бүхий байгууллагын зөвшөөрснөөр төрийн өмчийг гуравдагч этгээдэд концессийн гэрээ эсвэл түрээсийн гэрээгээр шилжүүлж болно. Газар, газрын хөрстэй холбоотой асуудлыг хуулийн дагуу тусгайлан зохицуулдаг. Концессийн тухай тусгайлсан хууль байхгүй нөхцөлд энэ төрлийн харилцааг Газрын тосны тухай хууль, Ашигт Малтмалын тухай хууль, Усны тухай хууль, Төмөр замын тээврийн аюулгүй

байдлын тухай хууль, Автотээврийн тухай хууль, Эрүүл мэндийн тухай, Боловсролын тухай хууль, Эрчим хүчний тухай хууль зэрэг салбарын хуулиудаар зөвшөөрч болно. Концессийн гэрээг УИХ-аар батлуулах шаардлагатай байдаг тул Засгийн Газар энэ талаар эрх мэдэл бага байна.

Монголын хууль эрх зүйн тогтолцоонд концессийн холбогдолтой гэрээний цар хүрээ, тодорхойлолтын талаар дэлгэрэнгүй зүйл заалтууд ерөнхийдөө байдаггүй. Тухайлбал, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулинд “концесси” хэмээх нэр томъёоны тодорхойлолт байхгүй байна. Зохицуулалтын хүрээ хангалттай бус учраас концессийн гэрээний уян хатан зохицуулалт муу байна. Төсвийн хөрөнгөөр бараа үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу концесситэй төстэй гэрээний эрхийг олгохдоо тендер шалгаруулалт явуулахаар заасан. Мөн түүнчлэн, салбарын хуулиудад (Ашигт малтмалын хуулиас бусад) зааснаар тусгай зөвшөөрөл цуцлагдсан тохиолдолд концесси эзэмшигчид нөхөн төлбөр олгодоггүй. Монголын хууль тогтоомжинд маргаан таслах, түүний дотор гадаадын тал оролцсон маргааныг таслах тогтолцоо харьцангуй сайн тусгагдсан. Иргэний хуулийн дагуу гэрээний талууд холбогдох хууль тогтоомжийг сонгох, маргаанаа арбитрын шүүхээр шийдвэрлүүлэхийг зөвшөөрдөг. Салбарын тусгайлсан хуулиуд ийм зохицуулалт хийхийг хориглодоггүй учраас концессийн гэрээнд оролцогч хувийн хэвшилд энэхүү уян хатан байдал нь маш их хэрэгтэй байх болно. Гэхдээ зарим салбаруудад зөвхөн Монгол Улсын хууль тогтоомжийг ашиглахаар хуулинд заасан байдаг (жишээлбэл, Газрын тосны тухай хууль).

Дүгнэж үзэхэд, Монгол Улсын дэд бүтэц, үйлчилгээний салбарт төр, хувийн хэвшлийн түншлэл байгуулж хөгжүүлэх хууль эрх зүйн орчин хязгаарлагдмал байна.

Төлбөрийн чадваргүйдэл

Төлбөрийн чадваргүйдлийг Дампуурлын тухай хуулиар зохицуулдаг. Дампуурлын тухай хууль нь анх 1997 онд батлагдаж, хамгийн сүүлд 2002 онд нэмэлт өөрчлөлт орсон. Төлбөрийн чадваргүйдлийг зарлаж, үүдэн гарах зөрчлийг шийдвэрлэх үндсэн арга замыг энэ хуулинд зааж өгсөн байдаг. Гэвч төлбөрийн чадваргүйдлийн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаа, итгэмжлэгдсэн төлөөлөгч, шүүгч нарын туршлага дутагдалтай байгаа талаар санаа зовоосон асуудлууд олон байсаар байна. ЕСБХБ-наас гаргасан төлбөрийн чадваргүйдлийн салбарын үнэлгээнд дурьдсан төлбөрийн чадваргүйдлийн олон улсын стандарттай харьцуулж үзвэл Дампуурлын тухай хууль нь “доогуур мөрдөлт”-тэй гэсэн үнэлгээ авчээ (Зураг 3-ыг үзнэ үү).

Доогуур үзүүлэлт авсан нь тухайн хууль ноцтой дутагдалтай байгааг илтгэж байна. Төлбөрийн чадваргүйдлийн тодорхойлолт нь санхүүгийн шалгалт боловч зээлдэгч өөрийн хөрөнгийн хамгийн багадаа 10 хувьтай тэнцэх хэмжээний өрийг хугацаанд нь барагдуулж чадаагүй бол төлбөрийн чадваргүйдэлд орсон гэж үзнэ гэсэн нь тодорхой биш байна. Үүнийг нэмж тодруулах, ялангуяа хугацаа хэтэрсэн өрийн хугацааг тодорхой болгож өгөх шаардлагатай.


Итгэмжлэгдсэн төлөөлөгч дампуурсан компанийн санхүүгийн байдлын талаарх мэдээллийг олж авах механизм хуулинд тусгагдаагүйгээс гадна өртэй этгээд, түүний эд хөрөнгийг эзэмшиж байгаа гуравдагч этгээдийг итгэмжлэгдсэн төлөөлөгчтэй хамтран ажиллахыг тусгайлан шаардаагүй байна. Дампууралд хамрагдах хөрөнгийн тодорхойлолтыг муу хийсэн учраас өр барагдуулах үйл явцыг хүндрүүлдэг. Хуурамч гүйлгээ, бодит үнээс доогуур хийгдсэн шилжүүлэгтэй холбоотой заалтууд нь тодорхой бус бөгөөд ямар нэгэн тодорхойлолтгүй нэр томъёо, санаа зорилгыг нотлох шаардлага дээр үндэслэж байна. Мөн түүнчлэн, тодорхой нэгэн зээлдүлэгчдэд зүй бус давуу

байдал олгосон гүйлгээг хянан үзэх хугацааг дампуурлын хэрэг бүртгэгдсэнээс өмнөх зөвхөн 120 хоногийг хамарч байгаа нь хэт богино бөгөөд буруугаар ашиглах нөхцлийг бүрдүүлж байна. Өөрчлөн байгуулалтын санхүүжилтийн талаар хуулинд мөн юу ч дурьдаагүй байна. Эцэст нь, төлбөрийн чадваргүйдлийг хил дамнан хянан шийдвэрлэх асуудал огт тусгагдаагүй байна.

Дампуурлын тухай хуулийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн (төлбөрийн чадваргүйдлийн асуудлыг хянан шийдвэрлэхэд оролцдог мэргэжлийн хүмүүс) эрх хэмжээ, үүргийн талаарх зохицуулалт мөн муу. Итгэмжлэгдсэн төлөөлөгч томилох тухай заалтууд нь маш энгийн бөгөөд хэрэгжүүлэх талаар дэлгэрэнгүй мэдээлэл байхгүй. Итгэмжлэгдсэн төлөөлөгч томилох, чөлөөлөхөд тавих шалгуур үзүүлэлт гэж байхгүй. Мөн зээлдүүлэгч, бусад ашиг сонирхолтой талуудын томилгоог шүүмжлэх бололцоо байхгүй. Цаашилбал, итгэмжлэгдсэн төлөөлөгчийн цалин урамшуулал, зардлын зохицуулалт хуулинд тусгагдаагүй байна. Итгэмжлэгдсэн төлөөлөгчдийн мэргэжлийн болон ёс зүйн хэм хэмжээ, тэдний үйл ажиллагаа, ажлыг шалган дүгнэх зохицуулалтын байгууллага байхгүй байна. Мөн түүнчлэн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн үйл ажиллагаагаа шүүх эсвэл хэн нэгэн этгээдэд тайлагнах үүрэг хариуцлага нь тодорхой бус байна. Хуулийн эдгээр цоорхойн улмаас итгэмжлэгдсэн төлөөлөгчийн мэргэжлийг сулруулж, тэдгээрийн чиг үүргээ үр ашигтай байдлаар хэрэгжүүлэхэд шаардлагатай арга хэрэгсэлгүй болгож байна.

Эдгээр нь гол асуудлууд болж байна. Одоогоор бүрэн хэмжээний шинэчлэл явагдаж байна (Германы техник туслалцааны нийгэмлэгийн удирдлаган дор).

Төлбөрийн чадваргүйдлийн хууль тогтоомжийн чанар – Монгол Улс (2006)



Тайлбар: Тэнхлэгийн төвөөс аль болох хол байх нь сайн үзүүлэлт, ө.х., Дэлхийн Банкны Төлбөрийн чадваргүйдэл, зээлдүүлэгчийн эрх ашгийн үр дүнтэй системийн үндсэн зарчим, удирдамж, UNCITRAL-ын Төлбөрийн чадваргүйдлийн хуулинд зориулсан эрх зүйн удирдамж болон бусад стандартуудтай нийцсэн гэсэн үг. Энэхүү 'тор, том байхын хирээр тухайн улсын төлбөрийн чадваргүйдлийн хууль тогтоомж тэдгээр зарчмуудтай ойролцоо байна.

Эх сурвалж: ЕСБХБ-наас гаргасан Төлбөрийн чадваргүйдлийн салбарын үнэлгээ, 2006 он

Барьцаатай гүйлгээ

Монгол Улсад барьцаа авах үйл ажиллагааг 2002 онд батлагдсан Иргэний хуулиар үндсэндээ зохицуулдаг бөгөөд энэ хуулийн хүрээнд харьцангуй дэлгэрэнгүй

зохицуулалт бүрдэж чадсан.⁷ Мөн түүнчлэн, Үл хөдлөх хөрөнгийн эрхийг бүртгэх тухай хуулинд барьцаанд байгаа хөрөнгийн хувьд эдлэх эрхийн талаар чухал заалтууд орсон. Шүүхийн заавраар хэрэгжүүлэх үйл ажиллагааг Шүүхийн шийдвэр биелүүлэх тухай хуулиар зохицуулдаг. Зээлийн барьцаанд байгаа үл хөдлөх хөрөнгийг шүүхийн бус журмаар шилжүүлэн авах тухай хуулийг 2005 оны сүүлээр баталсан боловч Үндсэн хуулийг зөрчсөн гэсэн үндэслэлээр одоо үйлчилгээгүй болоод байна. Салбарын тусгайлсан хуулиуд мөн дараахь нөхцөлд ашиглах зохицуулалтыг багтаасан байдаг. Жишээлбэл, Ашигт малтмалын тухай хуулинд уул уурхайн ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй холбоотой заалтууд бий.

Иргэний хууль нь батлагдаад харьцангуй удаагүй байгаа хэдий ч хөдлөх болон үл хөдлөх хөрөнгө (тоног төхөөрөмж, бараа материал, авлага гэх мэт)-ийг барьцаалахтай холбоотой заалтууд нь зах зээлийн эдийн засгийн бодит байдалд нийцээгүй бөгөөд бүрэн хэмжээний шинэчлэл хийгдээгүйгээс зах зээл өргөжин хөгжиж чадахгүй байна. Барьцаанд тавьж болох хөдлөх хөрөнгө болон эрхийн төрлүүд хязгаарлагдмал бөгөөд нийтлэг тодорхойлолттой хөрөнгийг (тухайлбал, бараа материал, ирээдүйд авах тоног төхөөрөмж) барьцаанд хүлээж авдаггүй. Хөдлөх хөрөнгийн барьцааг газрын бүртгэлд (өөрөөр хэлбэл, хөрөнгийн эзэмшигчийн нэр дээр) бүртгүүлэх боломжтой тогтолцоо байдаг боловч практик ач холбогдол муутай бөгөөд шаардлагагүй хязгаарлалт болох нь олонтаа тохиолддог. Хэрэгжилтийн үйл явц удаан бөгөөд үр дүн муутай хэмээн хэрэглэгчид гомдол мэдүүлдэг. Дээр тайлбарласанчлан, Дампуурлын тухай хууль бүхэлдээ зохистой бус байдаг. Орон сууцны барьцааны тухайд газрын бүртгэл дээр хийгддэг бүртгэлийн ажиллагаа, хэрэгжилтийн талаар олон санал гомдол ирдэг. Орон сууцны барьцааны тухай болон Орон сууцаар барьцаалсан үнэт цаасны тухай хуулиудын төсөл шинээр хийгдээд явж байна.

ЕСБХБ нь Хууль зүй дотоод хэргийн яамтай хамтран ажиллаж, хөдлөх хөрөнгийн барьцааны эрхийн хууль эрх зүйн зохицуулалтыг (барьцааны тухай хууль) шинэчлэх чиглэлээр техник туслалцаа үзүүлж байна. Энэ хүрээнд Барьцааны тухай цоо шинэ хуулийг боловсруулж, Иргэний хуулийн холбогдох зүйл заалтуудын найруулгыг нарийвчлан шинэчилж, барьцааны. Өнөөг хүртэл ахиц дэвшил, нэн ялангуяа барьцааны бүртгэлийг бий болгох дээр удаан гарч байгаа бөгөөд ЕСБХБ-ны зүгээс үйл ажиллагааг түргэсгэж, ажлыг хэрэгжүүлэхэд шаардагдах хүний нөөцөд хөрөнгө оруулалт хийхийг Засгийн Газарт анхааруулж байгаа.

Үнэт цаасны зах зээл

Монгол Улсын үнэт цаасны зах зээлийн үндсэн хууль тогтоомж нь Үнэт цаасны зах зээлийн тухай хууль (2002 оны 12-р сарын 12-нд батлагдаж, 2005 оны 11-р сард нэмэлт өөрчлөлт орсон) болон Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль (2005 оны 12-р сарын 17-нд батлагдаж, 2006 оны 7-р сард нэмэлт өөрчлөлт орсон) юм. Үнэт цаасны зах зээлийн тухай хууль нь үнэт цаас гаргах, бүртгэх, арилжих, үнэт цаасны өмчлөх эрхийг шилжүүлэх үйл ажиллагаа, хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалах асуудал, брокерийн хяналт шалгалтыг зохицуулдаг. Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль нь зах зээлийн зохицуулалтын байгууллага болох Санхүүгийн зохицуулах хороо (СЗХ)-г үүсгэн байгуулах, түүний бүтэц зохион байгуулалт болон үйл ажиллагааг зохицуулж, санхүүгийн үйлчилгээний зохицуулалт, хяналтыг хангаж өгдөг. Энэ хууль батлагдсанаар үнэт цаасны зах зээлд оролцогчид, даатгалын компани, банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршоодын

⁷ 153-185-р зүйл.

хяналт шалгалтыг СЗХ хариуцах болж харин Монголбанк Монголын арилжааны банкуудын үйл ажиллалгаа зохицуулах болсон.

Монголын хөрөнгийн бирж бол тус улсад байгаа цорын ганц хөрөнгийн бирж юм. Анх өмч хувьчлалын хэрэгсэл байдлаар үүсгэн байгуулагдсан бөгөөд чиг үүргийн хувьд ерөнхийдөө хоёрдагч зах зээлээр дагнасан хэвээр байна. Хөрөнгийн биржид бүртгэлтэй 380 орчим компани байна. Арилжаа явагдахгүй, холбогдох дүрэм журмыг дагаж мөрдөөгүй, жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг зөрчсөн гэсэн үндэслэлээр 2008 онд СЗХ-ноос 166 компанийн хувьцааны арилжааг түтгэлзүүлсэн. 2008 оны эцсийн байдлаар хөрөнгийн захын хөрөнгөжилт 407 сая орчим доллар байсан.⁸ Үнэт цаасны төлбөр тооцоог Үнэт цаасны төлбөр тооцооны нэгдсэн төвөөр дамжуулан хийдэг. Монгол Улсад хамтарсан хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа, тэтгэврийн сангийн үйл ажиллагааг зохицуулах хууль эрх зүйн орчин байхгүй байна.

ЕСБХБ-наас 2007 онд явуулсан Үнэт цаасны зах зээлийн хууль тогтоомжийн үнэлгээгээр Монгол Улс Үнэт цаасны хороодын олон улсын байгууллагын Зорилт, зарчмуудын хэрэгжилт “дундаж” үзүүлэлттэй гарчээ. Үнэт цаасны зах зээлийн хууль эрх зүйн орчинд, нэн ялангуяа зах зээлийн зуучлагчид, хоёрдогч зах зээл, санхүүгийн хэрэгсэлтэй холбоотой хэсгүүдэд хэд хэдэн дутагдалтай талыг илрүүлжээ. Тухайлбал, мэдээллийг байнга нээлттэй байлгах, хөрвөх болон төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлтүүд, санхүүгийн хүндрэлд орсон зуучлагч нарын асуудлыг шийдвэрлэх, ашиг сонирхлын зөрчил, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах дүрэм, нэг харилцагчид үзүүлэх үйлчилгээний дээд хэмжээ, санхүүгийн дериватив хэрэгслүүдэд тавих хяналтын тогтолцоо зэрэг нь сул байна.

Үнэт цаасны зах зээлийн хууль тогтоомж бодит байдал дээр яаж ажилладгийг ойлгох үүднээс ЕСБХБ-наас үнэт цаасны зах зээл дээр Хууль зүйн үзүүлэлтийн судалгааг 2007 онд явуулсан. Тус бүс нутагт үйл ажиллагаа явуулдаг мэргэжлийн хүмүүсээс зохиомол кейс дасгалын талаар санал дүгнэлтийг нь авсан. Кейс дасгал дээр хувьцаагаа нийтэд анхлан санал болгосон үндэсний компанийн танилцуулган дээр байсан ташаа мэдээллийн улмаас хувьцааг худалдан аваад хадгалсан хөрөнгөө алдсан хөрөнгө оруулагчид зөвлөлгөө өгөх учиртай. Судалгааны хүрээнд шинээр гаргаж буй хувьцааны танилцуулганд тусгагдах мэдээлэлд тавигдах шаардлага үр дүнд хүрч байгаа эсэх, хууль журмын хэрэгжилтийг хангах хувийн болоод төрийн арга механизм, зах зээлийн зохицуулагчийн эрх мэдлийг онцгойлон авч үзсэн. Хууль зүйн үзүүлэлтийн судалгааны дүнгээр Монгол Улсад хувьцааг нийтэд анхлан санал болгох нь нийтлэг бус, компаниудын хувьд банкны зээл санхүүжилтийн гол эх үүсвэр хэвээр байгаа нь харагдсан. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулинд хувьцааг нийтэд анхлан санал болгох танилцуулгад тавих ерөнхий шаардлагыг тогтоож өгсөн боловч хангалттай бус байна. Бодит байдал дээр танилцуулга хангалттай хэмжээний гүнзгий, нарийвчилсан мэдээллийг, бүр хуулиар шаардсан мэдээллийг багтааж чадахгүй байна. Хуулийг хэрэгжилтийг хангах хувийн арга механизмын хүрээн хэд хэдэн чиглэлээр арга хэмжээ авч болох боловч үр дүн нь муу байна: журам нь нарийн түвэгтэйгээс гадна хуулийн арга хэмжээ авсны дараагаар нөхөж авах хөрөнгийн хэмжээ маш бага байна. Үнэт цаасны зах зээлийн байгууллагууд шүүхийн ажиллагаанд шаардлагатай дэмжлэг үзүүлэх боломжгүй байгаа бол шүүх, яллагч, үнэт цаасны зах зээлийн зохицуулагч байгууллагын компанийн нарийн түвэгтэй хэргүүд дээр ажилласан мэдлэг туршлага нэмэгдүүлэх шаардлагатай байна.

⁸ Евроазийн хөрөнгийн биржийн холбооны цахим хуудаснаас авсан мэдээ (<http://www.feas.org/MemberIndex.cfm>)

Хууль тогтоогч байгууллага дотоодын хууль тогтоомжууд олон улсын хэм хэмжээтэй хэрхэн нийцэж байгааг сайтар үнэлж хууль тогтоомжийн зохицуулалт, хэрэгжүүлэгч байгууллагын чадавхи аль алиныг холбогдох сургалт, ур чадварыг дээшлүүлэх хөтөлбөрөөр дамжуулан бэхжүүлэхэд анхаарах ёстой. Цаашилбал, төр засгаас Монголын хөрөнгийн зах дээр байгууллагын хөрөнгө оруулагч, нэн ялангуяа тэтгэврийн болон хөрөнгө оруулалтын сан үүсэн хөгжих нөхцлийг бүрдүүлэх ёстой.

Харилцаа холбоо

Институцийн хүрээ: Харилцаа холбооны зохицуулах хороо (ХХЗХ) нь харилцаа холбооны зохицуулалтын олон чиг үүргийг, түүний дотор тусгай зөвшөөрөл олгох, дугаарлалт, зах зээлийн үлэмж эрх мэдэл олгох ба үйл ажиллагааны нөхцөл, харилцан холболт ба үнэ тариф, үелзлэлийн зохицуулалт, радио давтамжийн хуваарилалт, маргаан таслах, шалгалт, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах зэрэг хууль дүрмийн мөрдөлт, техникийн стандартууд болон нэгдсэн үйлчилгээний сангийн удирдлага зэргийг хариуцан ажилладаг. Мөн түүнчлэн бодлого боловсруулахад саналаа оруулдаг. Мэдээллийн харилцаа холбооны технологи, шуудангийн газар нь харилцаа холбооны бодлогыг боловсруулах үүрэгтэй бөгөөд яамны статусгүй боловч өмнө нь шийдвэр гаргахад яамны эн зэрэгцэх түвшинд ажиллаж ирсэн. Ерөнхий сайдад шууд тайлагнадаг байгууллага юм. Засгийн Газар Монголын харилцаа холбоо компанийн 55 хувийг эзэмшдэг бол Өмнөд Солонгосын харилцаа холбоо компани 40 хувийг, үлдсэн 5 хувийг Монголын хувь хүмүүс эзэмшдэг. Мэдээлэл, харилцаа холбооны сүлжээний компани 100 хувь төрийн мэдэлд байдаг


Зохицуулалтын хараат бус бие даасан байдал: ХХЗХ-ны дарга, орон тооны бус зургаан гишүүнийг Засгийн Газрын оруулсан саналыг үндэслэн Ерөнхий сайд томилдог. ХХЗХ-ны жилийн төсвийг Засгийн Газар баталж, санхүүгийн тайлангуудыг жил бүр хэвлэж, аудит хийлгэдэг. Зохицуулалтын байгууллагын дээд удирдлага харилцаа холбооны оператор компанийн энгийн хувьцааны 20 хүртэл хувийг эзэмших эрх хуулиар олгогдсон боловч энэ заалтын үйлчлэлийг ёс зүйн шинэ дүрмээр хүчингүй болгоно гэсэн найдвар бий. ХХЗХ нь тусгай зөвшөөрөл, зохицуулалтын үйлчилгээний хөлс, үелзлэлийн ашиглалтын орлогоороо санхүүждэг. Зохицуулалтын шинжтэй шийдвэр гаргахаас өмнө олон нийтийн хэлэлцүүлэг явуулахыг хуулиар шаардаагүй байна. Шийдвэрүүдийг нийтэд хэвлэн танилцуулах хуулийн шаардлага байхгүй ч гэсэн саяхнаас цахим хуудас ажиллуулах болж хэлэлцүүлэг хийх суваг болгосон.

Зах зээлийн хүртээмж ба зөвшөөрөл: Саяхнаас ХХЗХ өөрийн шийдвэр гаргах үйл ажиллагааг илүү ил тод болгох замаар тус зах зээл дээр шударгаар өрсөлдөхийг урамшуулах болсон. 2001 онд батлагдсан Харилцаа холбооны тухай хуулиар харилцаа холбооны зах зээлийг бүхэлд нь чөлөөлсөн ч зарим салбарууд (тухайлбал, үүрэн телефон) 2001 оноос өмнө тодорхой хэмжээгээр чөлөөлөгдсөн байсан гэсэн баримт бий. Суурин утасны зах зээл зарчмын хувьд чөлөөлөгдсөн боловч хязгаарлагдмал өрсөлдөөнтэй байна. Суурин утасны шугамны дийлэнх хэсэг (94 хувь) нь МХХКомпанийн мэдэлд байдаг бол дотоодын төмөр замын компанийн охин компани болох Рейлком компани багахан газар нутгийг (төмөр зам дагасан) хамарсан жижиг зах зээлийг эзэмшиж байна. Зөвшөөрлийг компани тус бүрт олгосон тусгай зөвшөөрлөөр өгдөг. Тусгай зөвшөөрөл олгох журмыг 2008 оны 1-р сард шинэчлэн мөрдөх болсон ч ХХЗХ-ноос хэрэгжүүлж эхлэх гэж байна. Шинэ журмаар технологиос үл хамаарах, хуучин (салангид байгаа) тусгай зөвшөөрлүүдийг нэгтгэхэд анхаарч байгаа. Тусгай зөвшөөрлийн төлбөрийг доогуур тогтоож, шинээр орж ирэх этгээд, хөрөнгө оруулагчдыг татах зорилго агуулсан. ХХЗХ-ноос тогтоосон журмын дагуу давтамжийн тусгай зөвшөөрлийг “хүсэлт гаргасан дагуу” олгох учиртай. Радио давтамжийн тухай

хуулинд зааснаар хоёр болон түүнээс дээш тооны санал ирсэн нөхцөлд тендер шалгаруулалт зарлагдах бөгөөд үүнийг тендер шалгаруулалтын нөхцөлд зааж өгсөн байдаг. ХХЗХ-ноос жилийн хураамжийг тогтоохдоо дамжуулагчийн хүчин чадлыг харгалзан үзнэ. 2001 онд батлагдсан Харилцаа холбооны тухай хуулиар маргаан таслах олон төрлийн эрх мэдлийг тогтоосон. Давж заалдах этгээд гэж байхгүй бөгөөд маргаан гарсан тохиолдолд шүүхэд хандаж болно.

Үнэлгээ: ЕСБХБ-ны үйл ажиллагаа явуулдаг улс орнуудын харилцаа холбооны салбарт 2008 онд хийсэн үнэлгээгээр Монгол Улс олон улсын тэргүүн туршлагатай харьцуулахад “дундаж мөрдөлт”-тэй гэсэн үзүүлэлттэй гарчээ.

Монгол Улсын үнэлгээний гол үзүүлэлтүүд



Энэхүү аалзан график дээр үндсэн зургаан бүлэг үзүүлэлтийг харуулсан. Үзүүлэлт тус бүрийн хувьд тавьсан оноо нь хамгийн дээд онооны хувиар илэрхийлэгдэнэ. Үзүүлэлт графикийн төвөөс 0 оноогоор эхэлж зах уруу 1.00 хүртэл хэмжигдэнэ. Иймд тор өргөн байхын хирээр үнэлгээний оноо өндөр байна.

(see <http://ebrd.com/country/sector/law/telecoms/assess/index.htm> for more details).

Хавсралт 5 – 2009 оны 9-р сарын байдлаарх ЕСБХБ-наас батлагдсан төслүүд

САЛБАР	ТӨЛӨВЛӨГӨӨ				ЦЭВЭР БАГЦ			
	Төслийн тоо	Төслийн нийт өртөг	ЕСБХБ-ны санхүүжилт	ЕСБХБ-ны Багцад Эзлэх %	Багц	Багцад Эзлэх %	Ашиглаагүй үлдэгдэл	Үйл ажиллагааны Хөрөнгө
Аж ахуйн нэгж								
ХАА	4	23	14	11%	14	12%	0	14
Аж үйлдвэр	4	9	9	7%	9	8%	1	8
Дэд бүлгийн дүн	8	32	23	18%	23	21%	1	22
Байгалийн баялаг	11	284	83	66%	70	63%	11	59
Санхүүгийн байгууллага								
Банкны өөрийн хөрөнгө	1	5	5	4%	5	5%	0	5
Банкны зээл	4	0	3	2%	3	2%	0	3
Жижиг бизнесийн санхүүжилт	4	16	12	10%	10	9%	0	10
Дэд бүлгийн дүн	9	21	20	16%	18	16%	0	18
УЛСЫН ДҮН	28	337	126	100%	110	100%	12	98

	Төслийн тоо	Дүн (сая евро)	Нийт дүнд эзлэх % (төслийн тоо)
ААН-ИЙН САЛБАР			
Аж үйлдвэр	2	6	13%
ХАА	0	0	0%
ДҮН	2	6	13%
САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА	4	23	25%
БАЙГАЛИЙН БАЯЛАГ	8	106	50%
ДЭД БҮТЭЦ			
Тээвэр	0	0	0%
Эрчим хүч, цахилгаан	2	19	13%
ДҮН	2	19	13%
НИЙТ ДҮН	16	153	100%

* Цаашид хэрэгжих төслүүдийн жагсаалт нь ЕСБХБ-наас заавал хэрэгжүүлэх төлөвлөгөө болохгүй бөгөөд стратегийн хамрах хугацаанд сүүлд гарч ирэх боломжит төслүүд багтаагүй болно.

Хавсралт 7 – Техникийн хамтын ажиллагааны багц

Төлөвлөсөн төслийн нэр		Төлөвлөсөн дүн	Ашиглалт	Батлагдсан	Хэрэгжилт
		Евроодолл	Евроодолл	оноо	
EBSF-2008-07-07	Монгол Улс: Зоос Банк	100,000	15,000	16/07/08	Төлөвлөсөн
EBSF-2008-09-18F	БЗҮ хөтөлбөрийг эхлүүлж дэмжлэг үзүүлэх (ESSF)	298,160	0	19/09/08	Төлөвлөсөн
EBSF-2008-12-83	Монголын олон банкны хөтөлбөр: БЖДБ-ийн зээл, лизинг	500,000	0	08/12/08	Төлөвлөсөн
EBSF-2009-02-21F	ҮҮӨХөтөлбөр - Петровис	75,000	0	17/02/09	Төлөвлөсөн
ETCF-2006-12-45	Монголын олон банкны хөтөлбөр: БЖДБ-ийн зээл, лизинг	1,000,000	661,346	07/12/06	Ашиглаж байгаа
ETCF-2007-02-13	Даатгалын дүрэм журмыг боловсронгуй болгох	300,000	26,665	22/02/07	Ашиглаж байгаа
ETCF-2007-07-36	Хөрөнгө оруулалтын зөвлөл – Ажлын албаны дарга	70,848	26,545	20/07/07	Ашиглаж байгаа
ETCF-2007-08-37	Хөрөнгө оруулалтын зөвлөл: Ажлын албаны даргын туслах	13,939	6,751	06/08/07	Ашиглаж байгаа
ETCF-2007-09-42	Хөрөнгө оруулалтын зөвлөл: Бусад	36,781	34,864	05/09/07	Ашиглаж байгаа
ETCF-2007-10-46	Эрдэнэс, АМГ-ын мэргэжлийн чадавхийг бэхжүүлэх – А хэсэг	115,000	0	25/10/07	Төлөвлөсөн
ETCF-2007-10-47	Эрдэнэс, АМГ-ын мэргэжлийн чадавхийг бэхжүүлэх – В хэсэг	83,600	0	25/10/07	Төлөвлөсөн
ETCF-2008-03-12	Улаанбаатар хотын утаагүй цэвэр агаар санаачлага – I шат	325,000	68,879	28/03/08	Ашиглаж байгаа
ETCF-2008-07-22	Хөрөнгө оруулалтын зөвлөлийн Ажлын алба – Хуулийн шинжээч	18,010	8,875	08/07/08	Ашиглаж байгаа
ETCF-2008-07-24	Хөрөнгө оруулалтын зөвлөл: Эдийн засаг/санхүүгийн зөвлөл	18,011	8,875	14/07/08	Ашиглаж байгаа
ETCF-2008-07-26	Зоос Банк	600,000	15,000	16/07/08	Төлөвлөсөн
ETCF-2008-08-29	Хөрөнгө оруулалтын зөвлөл: Эдийн засаг/санхүүгийн зөвлөл	12,150	5,062	28/08/08	Ашиглаж байгаа
ETCF-2008-12-43	Монголын олон банкны хөтөлбөр: БЖДБ-ийн зээл, лизинг	500,000	0	08/12/08	Төлөвлөсөн
ETCF-2008-12-44	Хөрөнгө оруулалтын зөвлөл: Эдийн засаг/санхүүгийн зөвлөл	10,158	2,282	11/12/08	Төлөвлөсөн
ETCF-2009-01-01	Хөрөнгө оруулалтын зөвлөл	23,222	15,299	08/01/09	Ашиглаж байгаа
JAP-2007-05-21F	ҮҮӨХөтөлбөр – Шалгаруулалт	50,500	7,537	03/05/07	Ашиглаж байгаа
JAP-2007-10-47F	ҮҮӨХөтөлбөр – Хатансүйх импекс ХХК	74,440	19,537	10/10/07	Ашиглаж байгаа
JAP-2007-10-48F	ҮҮӨХөтөлбөр – Ньюком системс	74,440	47,028	10/10/07	Ашиглаж байгаа
JAP-2007-10-49F	ҮҮӨХөтөлбөр – Таван богд косметикс ХХК	74,440	38,337	10/10/07	Ашиглаж байгаа
JAP-2007-10-50F	ҮҮӨХөтөлбөр – Юнайтед Солюшнс Интернэшл ХХК	74,440	31,830	10/10/07	Ашиглаж байгаа
JAP-2007-10-51F	ҮҮӨХөтөлбөр – Номун Интер Трейд	74,440	55,442	17/10/07	Ашиглаж байгаа
JAP-2007-12-65	Сэргээгдэх эрчим хүчний зохицуулалтыг бий болгож хөгжүүлэх замын зураглал	290,000	141,500	14/12/07	Төлөвлөсөн
JAP-2008-03-06F	Дархан Нэхий ХК	74,440	30,026	18/03/08	Төлөвлөсөн
JAP-2008-03-07F	ҮҮӨХөтөлбөр – Монруд	74,440	20,051	18/03/08	Ашиглаж байгаа
JAP-2008-03-08F	ҮҮӨХөтөлбөр – Мөнхийн тун	74,440	21,240	20/03/08	Ашиглаж байгаа
JAP-2008-04-11F	ҮҮӨХөтөлбөр – Гео мандал ХХК	74,440	13,577	29/04/08	Төлөвлөсөн
JAP-2009-02-03F	ҮҮӨХөтөлбөр - Говь	74,440	0	04/02/09	
					Төлөвлөсөн
LUX-2007-12-08	Салхит уул салхины аж ахуйн байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ	76,000	60,800	18/12/07	Ашиглаж байгаа
LUX-2008-09-13F	БЗҮХөтөлбөрийг эхлүүлж дэмжих (Люксембург)	100,000	1,577	19/09/08	Ашиглаж байгаа
MONF-2002-01-01	ТХАС-гийн хэрэгжилт ТХА – байрны түрээс	6,587	6,587	23/01/02	Хаагдсан
MONF-2002-04-04	Иргэний агаарын тээврийн мастер төлөвлөгөө боловсруулах судалгаа	358,543	358,543	04/04/02	Хаагдсан
MONF-2002-07-05	Компанийн засаглалын үнэлгээ	6,612	6,612	12/07/02	Хаагдсан
MONF-2002-07-07	Офис менежерийг ажиллуулах – гэрээний сунгалт	9,360	9,360	31/07/02	Хаагдсан
MONF-2002-10-10	МТХАСан	20,270	20,270	11/10/02	Хаагдсан
MONF-2003-03-02	МТХАСангийн хэрэгжилт ТХА – байрны түрээсийн гэрээний сунгалт	5,296	5,296	13/03/03	Хаагдсан
MONF-2003-03-03F	ҮҮӨХөтөлбөрийн хэрэгжилтийг үргэлжлүүлэх	913,420	873,886	19/03/03	Ашиглаж байгаа
MONF-2003-04-01F	Монголын банкны ажилтнуудын сургалтын хөтөлбөр	288,543	288,543	22/04/03	Хаагдсан
MONF-2003-04-02	МИАТ-ын менежментийн гэрэ	643,287	643,287	24/04/03	Хаагдсан

Шийдвэрийн дугаар	Төлөвлөсөн төслийн нэр	Төлөвлөсөн дүн	Ашиглалт	Батлагдсан огноо	Хэрэгжилт
MONF-2003-05-01	Цахилгаан салбар: Хувийн хэвшлийн оролцоо	271,282	271,282	23/05/03	Хаагдсан
MONF-2003-05-02	Компанийн засаглалын хууль эрх зүйн орчин, хэрэгжилтийг боловсронгуй болгох	198,276	198,276	29/05/03	Хаагдсан
MONF-2003-10-03	Олон улсын банкны үйл ажиллагааны сургалт	18,407	18,407	07/10/03	Хаагдсан
MONF-2003-10-04	Олон улсын банкны үйл ажиллагааны сургалт	19,200	19,200	07/10/03	Хаагдсан
MONF-2003-11-07	Монголын ТХА-ны сан – МХАС-гийн Албаны менежерийн гэрээ, албаны төсвийг сунгах	16,704	16,704	18/11/03	Хаагдсан
MONF-2003-12-08	ХААН Банк – Бичил зээлийн зөвлөхүүд	799,140	799,140	07/12/03	Хаагдсан
MONF-2004-01-01F	Монголбанкинд зориулсан сургалт (Евромани, төвбанкны хэвлэл	29,835	29,835	23/01/04	Хаагдсан
MONF-2004-05-02	Монгол Улсын газрын тосыг хэрэглэгч салбар: Эдийн засгийн тогтвортой хөгжлийн хангах чадавхийг бүрдүүлэх	49,497	49,497	17/05/04	Хаагдсан
MONF-2004-05-03	Монголын харилцаа холбоо компанийг хувьчлах хувилбарууд	345,630	345,630	17/05/04	Хаагдсан
MONF-2004-06-04	МХАС-гийн албаны байрны түрээсийг сунгах	4,163	4,163	23/06/04	Хаагдсан
MONF-2004-07-07	МИАТ-ын менежментийн гэрээ: Гэрээний сунгалт	392,687	392,687	15/07/04	Хаагдсан
MONF-2004-07-08	Монголын банкны ажилтнуудыг худалдааны санхүүжилтийн сургалтанд нэмж хамруулах	23,793	23,793	21/07/04	Хаагдсан
MONF-2004-07-09	Монголын банкны ажилтнуудыг олон улсын залилан, мөнгө угаах гэмт хэргийн сургалтанд хамруулах	21,959	21,959	21/07/04	Хаагдсан
MONF-2004-07-10	Хөрөнгийн удирдлагын бүтээгдэхүүнүүд ба эрсдэлийн удирдлагын сургалт	26,470	26,470	21/07/04	Хаагдсан
MONF-2004-10-11F	ЖДБ-ийн менежментийн сургалт	56,157	56,157	06/10/04	Хаагдсан
MONF-2004-10-12	Техникийн хамтын ажиллагааны сан	17,836	17,836	28/10/04	Хаагдсан
MONF-2005-02-02	МХАС-гийн албаны байрны түрээс	3,084	3,084	28/01/05	Хаагдсан
MONF-2005-04-03	Монголын харилцаа холбоо компанийг хувьчлах хувилбарууд – 3 дугаар шатыг дахин тодорхойлох (хэрэгжиж байгаа ТХА)	200,000	200,000	08/04/05	Хаагдсан
MONF-2005-04-04	Үнэлгээ: МХАС-гийн дунд хугацааны үнэлгээ	64,723	64,723	08/04/05	Хаагдсан
MONF-2005-07-05F	Барьцаатай гүйлгээний тогтолцоог боловсронгуй болгох нь (1-р шат)	180,000	97,884	26/07/05	Ашиглаж байгаа
MONF-2005-08-06	Монголын банкны ажилтнуудад зориулсан зээлийн шинжилгээний сургалт	17,628	17,628	25/08/05	Хаагдсан
MONF-2005-09-07	Харилцаа холбооны зохицуулалтыг хөгжүүлэх хөтөлбөр	749,995	749,995	27/09/05	Хаагдсан
MONF-2006-01-01	Хөрөнгийн захын үнэлгээ, стратегийн зөвлөмж	49,160	49,160	13/01/06	Хаагдсан
MONF-2006-01-02	Орон нутгийн онгоцны буудлын засвар хийх боломжийг судлах ТТ	350,000	297,157	25/01/06	Ашиглаж байгаа
MONF-2006-02-03	МХАС-гийн албаны байрны түрээс	4,162	4,162	16/02/06	Хаагдсан
MONF-2006-07-04F	ҮҮӨХөтөлбөр - Гоёо	110,000	102,693	07/07/06	Ашиглаж байгаа
MONF-2006-09-05	АМГ-ын чадавхийг бэхжүүлэх	55,127	55,127	07/09/06	Хаагдсан
MONF-2006-09-06	АМГ-ын чадавхийг бэхжүүлэх – D хэсэг	20,204	20,204	26/06/06	Хаагдсан
MONF-2006-09-07	АМГ-ын чадавхийг бэхжүүлэх	25,087	25,087	26/09/06	Хаагдсан
MONF-2006-10-08	Монголын харилцаа холбоо компанийг хувьчлах хувилбарууд	50,000	50,000	23/10/06	Хаагдсан
MONF-2006-11-09	Гадаад худалдааг дэмжих хөтөлбөрийн нэгдсэн гааль 600 семинар	12,320	12,320	08/11/06	Хаагдсан
MONF-2006-11-10	Гадаад худалдааг дэмжих хөтөлбөр – Худалдааны санхүүжилтийн Зөвлөх үйлчилгээ	163,070	163,070	08/11/06	Хаагдсан
MONF-2007-01-01	Улаанбаатарын санхүүгийн нягтлан шинжилгээ, СТОУС-ын аудит	69,888	69,888	25/01/07	Хаагдсан
MONF-2007-01-02	Улаанбаатар хотын тээврийн төсөл: Төслийн бэлтгэл зөвлөлгөө, нягтлан шинжилгээ	32,777	32,777	29/01/07	Хаагдсан
MONF-2007-02-03	МАК ХХК-ийн бизнес төлөвлөгөө боловсруулах, багцыг эрэмбэлэх зорилгоор ЕСБХБ-д олгосон ТТ	90,000	73,916	12/02/07	Ашиглаж байгаа
MONF-2007-04-04	АМГ-ын чадавхийг бэхжүүлэх – ажилтнуудын томилолт, орчуулгын Зардлын нөхөн төлбөр	20,000	14,554	10/04/07	Ашиглаж байгаа
MONF-2007-06-05F	Дунд бизнесийн төслийг дэмжих хэрэгсэл	800,000	278,012	06/06/07	Ашиглаж байгаа
MONF-2007-06-09F	БЗҮХөтөлбөрийн үндэслэлийг тогтоох судалгаа - хүрээ	34,482	28,289	26/06/07	Ашиглаж байгаа
MONF-2008-01-01F	ҮҮӨХөтөлбөр - Самосон	75,200	64,972	10/01/08	Ашиглаж байгаа
MONF-2008-01-02F	ҮҮӨХөтөлбөр - Метроэкспресс	33,000	19,477	10/01/08	Ашиглаж байгаа
MONF-2008-01-03F	ҮҮӨХөтөлбөр - NIG	41,820	33,968	28/01/08	Ашиглаж байгаа
MONF-2008-01-04F	ҮҮӨХөтөлбөр - NIG	32,180	25,966	28/01/08	Ашиглаж байгаа
Нийт дүн (евро)		13,687,621	8,441,428		
Төлөвлөсөн төслийн тоо:		84			

Төслийн нэр	Дүн (евро)	ТХА Хорооноос батлагдсан эсэх (Т/Х)	Баг	Санхүүжилтийн байдал
Шилжилтийн эхний шатанд яваа зарим улсуудад Хөрөнгө оруулалтын зөвлөл байгуулж ажиллуулах	359,000	13/05/2009	SEECCA	Давхар санхүүжилт ETC Сан & SSF
Барьцаатай гүйлгээний шинэчлэлийг хэрэгжүүлэх	350,000	Ү	Хууль эрх зүйн шилжилт	
Улаанбаатар хотын утаагүй цэвэр агаар санаачлага - II шат	796,425	03/06/2009	Хууль эрх зүйн шилжилт	Өргөн барьсан байдал: ETC/SSF санхүүжилтийг хайх болно.

**Удирдлагыг Өөөчлөн
Байгуулах/Бизнесийн
Зөвөлгөө Өгөх
Үйлчилгээ Хөтөлбөрийг
Монголд хэрэгжүүлсэн
байдал**

УӨБ/БЗӨҮХөтөлбөрүүд нь ЕСБХБ-ны үйл ажиллагаа явуулдаг улс орнуудын өсөн хөгжих боломжтой бичил, жижиг, дунд бизнесүүдийн (БЖДБ) аж ахуй эрхлэлтийг өөрчлөх замаар эдийн засгийн шилжилтийг дэмжиж өгдөг. 2001 онд Монголд хэрэгжиж эхэлснээсээ хойш УӨБ/БЗӨҮХөтөлбөрүүд нь 3.6 сая гаруй еврогийн санхүүжилт босгосон байна. Гол санхүүжилтийг Япон, Голланд, Люксембург, Тайван, олон хандивлагчдын бүрдүүлдэг ЕСБХБ-Монголын хамтын ажиллагааны сан болон ЕСБХБ-ны хувь нийлүүлэгчдийн тусгай сангаас гаргасан байна.

УӨБХөтөлбөр

УӨБХөтөлбөрийн хүрээнд тухайн салбарт ажилласан 15-20 жилийн мэргэжлийн туршлага бүхий хөгжингүй улсын зөвлөхүүдийг илгээж, цаашид тухайн зах зээлд тэргүүлэгч болох боломжтой ЖДБ-д олон улсын тэргүүн туршлагыг нэвтрүүлдэг. УӨБХөтөлбөрийн төслүүд нь ерөнхийдөө 18 сарын хугацаанд хэрэгждэг. Мөн түүнчлэн хөтөлбөрийн хүрээнд сургалт семинар зохион байгуулж, амжилтанд хүрсэн бизнесийн аргыг сурталчилдаг. 2001 онд хэрэгжиж эхэлснээсээ хойш УӨБХөтөлбөр нь нийтдээ 41 төсөл хэрэгжүүлсэн бөгөөд үүний 19 нь одоо хэрэгжиж байна. Мөн ойрын үед 7 төсөл эхлүүлэхээр төслийн өмнөх шалгаруулалтын явцдаа байна. УӨБХөтөлбөрийн хүрээ нь олон салбарыг хамардаг бөгөөд хүнс боловсруулах, оёмол сүлжмэл эдлэл, эмийн үйлдвэрлэлийн салбарууд хамгийн нийтлэг салбар болж байна. УӨБХөтөлбөр нь бичил, жижиг, дунд бизнесүүдийг хувь тэнцүү хамарч чадсан. Газар зүйн байрлын хувьд нийслэл хотод төвлөрсөн бөгөөд 10 төслийн 9 нь Улаанбаатар хотод үйл ажиллагаагаа явуулдаг аж ахуйн нэгжүүдэд хэрэгжсэн байна. Бүрэн хэрэгжиж дууссан төслүүдийн 88 хувь нь хангалттай буюу түүнээс дээш үнэлгээ авчээ. УӨБХөтөлбөрийн амжилтын үндэс нь тухайн аж ахуйн нэгжийн ажилтнууд УӨБХөтөлбөрийн багаас ихийг сурч мэдэх гэсэн хүсэл эрмэлзэл дүүрэн байх явдал байлаа.

БЗӨҮХөтөлбөр

БЗӨҮХөтөлбөрийн хүрээнд дотоодын хувийн хэвшлийн зөвлөхүүдийг БЖДБ-үүд дээр ажиллуулж, олон төрлийн үйлчилгээ үзүүлдэг. БЗӨҮХөтөлбөр нь эрэлт, нийлүүлэлтийн аль аль тал дээр ажилладаг. Аж ахуйн нэгжүүд нарийн тодорхойлсон төслүүд дээр дотоодын зөвлөхийг ажиллуулж үр дүнг нь түргэн хардаг. Ингэснээр эрэлтийг бий болгож, гадаадын зөвлөхүүдийг авч ажиллуулахын ач холбогдлыг ойлгуулдаг. Мөн түүнчлэн, зах зээл үрүү чиглэсэн хөгжүүлэх үйл ажиллагааны үр нөлөөгөөр дотоодын зөвлөх үйлчилгээний нийлүүлэлт, чанарын сайжруулдаг. БЗӨҮХөтөлбөрийн хүрээнд хэрэгждэг төслүүд гол төлөв 4 сарын хугацаатай байдаг. БЗӨҮХөтөлбөрийн үйл ажиллагаа Монголд 2008 оны 10-р сард эхэлсэн бөгөөд ирэх гурван жилд 200 гаруй БЖДБ-үүд дээр БЗӨҮХөтөлбөрийн төслүүдийг хэрэгжүүлэхийн зэрэгцээ зах зээл үрүү чиглэсэн хөгжүүлэх үйл ажиллагаа явуулна. Үйл ажиллагааны хөрөнгө эх үүсвэр нь Улаанбаатар хотод байх хэдий ч БЗӨҮХөтөлбөр нь сул дорой хөгжилтэй бөгөөд хөдөө орон нутаг уруу чиглэх болно. Цаашилбал эрчим хүчний үр ашигтай, сэргээгдэх эрчим хүч, байгаль орчныг хамгаалах, баталгаажуулах, хүйсийн тэгш байдал, жижиг үндэстэнд туслалцаа үзүүлэхэд анхаарах болно.

**Бүрэн дүүрэн хөгжөөгүй
БЖДБ-ийн салбарт
бичил нэгжүүд
давамгайлж байна**

Бизнесийн бүртгэлийн 90 гаруй хувь, ДНБ-ий 70 гаруй хувийг БЖДБ-үүд бүрдүүлж байна. БЖДБ-үүд бүхэлдээ хувийн хэвшлийн бөгөөд төрийн өмчлөл томоохон, стратегийн ач холбогдолтой дэд бүтэц, уул уурхайн компаниудад төвлөрч байна. БЖДБ-ийн салбарын бүрэлдэхүүн цаг хугацаа өнгөрөхийн хирээр бараг өөрчлөгдөөгүй. Монголын ихэнх БЖДБ-үүд 5 хүртэл тооны ажилчидтай, 95 гаруй хувь нь 50 хүрэхгүй ажилчидтай байна. Гэр бүлийн өмчлөлтэй байх нь, ялангуяа хөдөө аж ахуйн салбарт нийтлэг байна. Ихэнх БЖДБ-үүд жижиглэнгийн худалдаа, бусад үйлчилгээний бизнес эрхэлж байна. Шилжилтийн эхэн үед байгаа бусад улсуудтай харьцуулахад Монголын БЖДБ-үүд техник технологи нэвтрэлт, аудит, нягтлан бодох бүртгэлийн стандартууд, хүнд суртал (нэн ялангуяа тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл), хөрөнгийн бүртгэл, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах, татвар төлөлт зэргээс доогуур үзүүлэлттэй байна. Үйлдвэрлэлийн чанар, экспортын боломж, хөрөнгө

**Засгийн Газрын
бодлого, үйл
ажиллагааны
зохицуулалт**

оруулалтын санхүүжилт, бизнесээ боловсронгуй болгох зэрэг томоохон сорилтууд энэ салбарт тулгарч байна. Монгол Улсад БЖДБ-үүдийг дэмжигч байгууллагуудын тогтолцоог бүрдүүлэхэд олон улсын хандивлагчид чухал үүрэг гүйцэтгэж ирсэн. Худалдааны танхим, ажил олгогчдын холбоо үндэсний хэмжээнд маш сайн төлөөлөлтэй бөгөөд тэдгээрийн үйл ажиллагааг салбарын холбоод, Засгийн Газрын байгууллагууд нөхөн баяжуулж байдаг.

БЗӨҮХөтөлбөрийн боломжит харилцагчдад, нэн ялангуяа хөдөө орон нутагт хүрэхийн тулд эдгээр байгууллагуудтай хамтран ажиллах хэрэгтэй. Гэвч эдгээр байгууллагуудын чадавхи, туршлага хязгаарлагдмал байна. Цаашид олон сайн үр нөлөө авчиргах боломжийг харгалзан үзвэл эдгээр байгууллагыг БЖДБ, дотоодын зөвлөхүүдийн адил БЗӨҮХөтөлбөрийн боломжит харилцагчдын тоонд оруулах нь зүйтэй.

БЖДБ-ийн бодлогын асуудлыг хариуцсан төр засгийн дээд байгууллага бол Үйлдвэр, худалдааны яамны ЖДБ, технологийн газар юм. БЖДБ-ийг бодлогын хэрэгжилтийг хариуцсан бие даасан агентлаг байгуулах тухай хууль гарсан байгаа бөгөөд энэ байгууллагын нэг үндсэн ажил нь аймгуудад бизнес инкубатор байгуулах явдал юм. БЖДБ-ийн бодлогын ерөнхий төлөвлөлт, зохицуулалтыг хариуцсан ЖДБ-ийн үндэсний зөвлөл байгуулж яам тамгын газрууд, худалдааны танхим, БЖДБ-ийн холбоо, Улаанбаатар хотын захиргаанаас төлөөлөл оруулах хэрэгтэй.

**Олон улсын
хандивлагчдын үйл
ажиллагаа**

Олон улсын хандивлагчдын нийгэмлэг Монгол Улсад төслийн дүн, төрөл, газарзүйн тархалтын хувьд нилээд идэвхтэй хэдий ч УӨБ/БЗӨҮХөтөлбөрүүд бусад хандивлагчдын санхүүжилттэй үйл ажиллагаатай давхацна гэсэн эрсдэл бага байна. УӨБ/БЗӨҮХөтөлбөрүүд тус улсын бүх бүс нутгийг хамрах зорилготой учраас бусад хандивлагчдаас ялгарч байгаа бөгөөд олон улсын хандивлагчдын туслалцаа дэмжлэг авсан аж ахуйн нэгжүүдийн тоо маш цөөхөн байна (Монголын хоршоологчдын сургалт, мэдээллийн төвийн гаргасан мэдээгээр БЖДБ-ийн дөнгөж 10 хувь нь л хандивлагчдын санхүүжилт авч байжээ). БЗӨҮХөтөлбөр нь бусад хандивлагчид үйл ажиллагаагаа хумьж байгаа үед илүү өргөн цар хүрээтэйгээр ажиллах гэж байгаагаараа нилээд өвөрмөц байгаа юм.

**Дотоодын зөвлөх
үйлчилгээний зах зээл**

БЗӨҮХөтөлбөрт 15 зөвлөх компани, холбоодын 40 гаруй дотоодын зөвлөхүүд бүртгүүлсэн байна. Зөвлөхүүдийн үйлчилгээ нягтлан бодох бүртгэл, санхүү, менежмент, мэдээллийн технологи, маркетинг, бизнес төлөвлөлт, хөрөнгө оруулалт, хүний нөөцийн удирдлага, програм хангамж, системийн шинжилгээ зэрэг олон салбарыг хамарч байгаа.

Аж ахуйн нэгжүүд бизнесийн зөвлөлгөө авч, зөвлөх үйлчилгээний төсөл хэрэгжүүлэх сонирхолтой байгаа. Олон улсын хандивлагчдын (ГТХАН, АНУОУХА, НҮБХХ, Мерси Корийн зэрэгцээ БЗӨҮХөтөлбөр) урт хугацаанд хэрэгжүүлсэн хөтөлбөрүүдийн үр дүнд Монголын олон БЖДБ-үүд бизнесийн зөвлөх үйлчилгээний үнэ цэнийг ойлгож, үйлчилгээний өртгийн зарим хэсгийг даах хүсэлтэй байна. Монголын БЖДБ-үүд дотоодын болоод гадаадын зөвлөхүүдийн зүгээс чанарын өндөр түвшинд үзүүлэх зөвлөх үйлчилгээ, сургалт авах хүлээлтэй байгааг онцлон тэмдэглэх нь зүйтэй.

**Цаашид хэрэгжүүлэх
УӨБ/БЗӨҮХөтөлбөрийн
зөвлөмж**

УҮӨ/БЗҮХөтөлбөрүүдийн хүрээнд Монголын аж ахуйн нэгжүүдэд тулгарсан асуудлуудыг шийдвэрлэж, хувийн хэвшлийн БЖДБ-ийн хөгжлийг шаардлагатай байгаа шинэ шатанд гаргахын тулд нэмэлт арга хэмжээг уян хатан байдлаар авч хэрэгжүүлэх боломжтой. Монгол дахь УӨБ/БЗӨҮХөтөлбөрийн үр нөлөөг тогтвортой байлгахын тулд менежментийн зөвлөлгөө өгч, сургалт явуулан (УӨБХөтөлбөрийн үндсэн мэргэшил) бизнесийн зөвлөх үйлчилгээний тогтвортой дэд бүтцийг бий болгоход чиглэсэн зах зээлийг хөгжүүлэх үйл ажиллагаануудыг авч хэрэгжүүлэх (БЗӨҮХөтөлбөрийн гол мэддэг зүйл) хэрэгтэй.

Эдийн засгийн салбаруудын хувьд УӨБ/БЗӨҮХөтөлбөрүүд нь экспортын боломж хамгийн өндөртэй салбарт, тухайлбал, хүнс боловсруулах, оёмол сүлжмэл эдлэл үйлдвэрлэл, машин тоног төхөөрөмж, мөн түүнчлэн уул уурхайн үйл ажиллагааны логистик зэрэг экспортонд амжилт гаргасан салбаруудын дагалдах салбарт анхаарна. Мөн түүнчлэн аялал жуулчлал, тээврийн салбар

**УҮӨХөтөлбөрийг
үргэлжлүүлэх**

экспортын боломж өндөртөйд тооцогдож байгаа учраас энэ хоёр салбарын үйл ажиллагааны газар зүйн тархалтыг Улаанбаатар хотоос гадагш Дархан, Эрдэнэт, Чойбалсан зэрэг томоохон хотууд уруу төрөлжүүлэхэд УӨБ/БЗӨҮХөтөлбөрүүд чиглэнэ. УӨБ/БЗӨҮХөтөлбөрүүд нь өөрийн аж ахуйн нэгжид туслалцаа дэмжлэг үзүүлэх үүрэг ролио зах зээлийг хөгжүүлэх үйл ажиллагаагаар нөхөн баяжуулж хөтөлбөрүүдийн шилжилтэнд үзүүлэх нөлөөллийг дээд хэмжээнд хүргэхийг зорьно.

Монголын БЖДБ-үүдэд тулгарч байгаа бөгөөд УӨБХөтөлбөрийн хүрээнд шийдвэрлэх боломжтой хамгийн гол саад бэрхшээл нь бүтээгдэхүүний чанар, маркетинг, бүтэц зохион байгуулалтын удирдлагын үүднээс авч үзвэл стратегийн төлөвлөлт, хүний нөөц, удирдлагын үүрэг хариуцлагыг илүү үр дүнтэй төлөөлүүлэх зэрэг асуудлууд юм.

**БЗҮХөтөлбөрийг
үргэлжлүүлэх**

Монголын БЖДБ-үүдэд тулгарч байгаа бөгөөд БЗӨҮХөтөлбөрийн хүрээнд шийдвэрлэх боломжтой хамгийн гол саад бэрхшээл нь удирдлагын үр дүнд хүрч чадаж байгаа байдал, ажилчдын ур чадвар, бүтээгдэхүүний чанарын асуудлууд байна. Эдгээрийг зорилтот зөвлөх үйлчилгээгээр, тухайлбал, бизнес төлөвлөлт, удирдлагын боловсронгуй хяналтын тогтолцоо, хүний нөөцийн төлөвлөлт, ажилчдын сургалт, инженерийн судалгаа, бусад зөвлөх үйлчилгээгээр дамжуулан шийдвэрлэх боломжтой.

БЗӨҮХөтөлбөрийн хүрээний туслалцааны чухал хэсэг нь буцалтгүй тусламж хэвээр байх ёстой бөгөөд санхүүгийн боломж муутай аж ахуйн нэгжүүдэд зөвлөх үйлчилгээ авах нөхцлийг бүрдүүлж өгөх болно.

Буцалтгүй тусламж олгох тэргүүлэх чиглэлийг тогтоож, нэмэлт дэмжлэг байх нөхцлийг ханган бусад хандивлагчдын үйл ажиллагаатай давхцахаас сэргийлэх зорилгоор буцалтгүй тусламжийн удирдамжийн хүснэгтийг гаргасан байгаа. Буцалтгүй тусламж нь дараахь аж ахуйн харилцагчдад илүүтэйгээр очих учиртай. Үүнд:

- Бичил, жижиг бизнесүүд, ялангуяа эмэгтэй хүний эзэмшиж, эрхэлж байгаа, бизнесийн зөвлөх үйлчилгээг хамгийн бага авсан, аж ахуй эрхлэлтийн хөгжил нь хамгийн доогуур түвшинд байгаа бизнесүүд.
- Нийслэл хот, бусад томоохон хотоос гадна байрлах аж ахуйн нэгжүүд, эдгээрт тусламж дэмжлэг хамгийн их хэрэгтэй байдаг бөгөөд бизнесийн зөвлөх үйлчилгээнээс хүртэх боломж муу, тэдгээр үйлчилгээний өртгийг төлөх санхүүгийн эх үүсвэр байдаггүй.
- Зах зээлийн гүйцэтгэлийг нэмэгдүүлэх, эрчим хүчний үр ашиг, байгаль орчны менежментийг сайжруулахад чиглэсэн төслүүд (ө.х. урт хугацаанд оршин тогтнох, ДНБ-д хувь нэмэр оруулах).

**Зорилтот зах зээлийг
хөгжүүлэх үйл
ажиллагаатай
зэрэгцүүлэх**

УӨБ/БЗӨҮХөтөлбөрүүдийн шилжилтэнд үзүүлэх үр нөлөөг дээд хэмжээнд хүргэхийн тулд аж ахуйн нэгжийн түвшин дэхь хөтөлбөрийн туслалцааг зах зээлийг хөгжүүлэх дараахь үйл ажиллагаагаар нөхөн баяжуулах нь зүйтэй. Үүнд:

- Харагдалт, тархаалт: УӨБ/БЗӨҮХөтөлбөрүүд нь бизнесийн зөвлөх үйлчилгээний хэрэглээ нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээ авч (тухайлбал, аж ахуй эрхлэгч нарт сайн үр дүнд хүрсэн төслүүдийн мэдээллийг тараах), УӨБХөтөлбөр нь олон улсын тэргүүн туршлагыг таниулах сургалт семинарыг олон зохион байгуулах учиртай.
- БЖДБ ба зөвлөх үйлчилгээний сургалт: УӨБ/БЗӨҮХөтөлбөрүүд нь зөвлөх үйлчилгээний нийлүүлэлтийг нэмэгдүүлж, зөвлөх үйлчилгээний үндсэн ур чадвар, Монголын БЖДБ-үүдэд шаардлагатай байгаа зөвлөх үйлчилгээний илүү нарийн чиглэлээр сургалт семинар зохион байгуулах замаар одоо байгаа дутагдлыг арилгах ёстой.
- Дотоодын холбогдох байгууллагуудыг–ялангуяа дотоодын бизнесийн зөвлөх үйлчилгээний зах зээлтэй холбоотой байгууллагуудыг дэмжиж хөгжүүлэх: БЗҮХөтөлбөрт хамрагдах боломжтой этгээдэд ажил олгогч, салбарын холбоодыг оруулж, тэдгээрийн чадавхийг бэхжүүлэх.

**Олон талт асуудлуудыг
шийдвэрлэх**

УӨБ/БЗӨҮХөтөлбөрүүд нь дараахь чиглэлээр үйл ажиллагаагаа өргөжүүлэх зорилготой байна. Үүнд: эрчим хүчний үр ашиг/сэргээгдэх эрчим хүч, байгаль орчны хамгаалал, байгаль орчны баталгаажуулалтын хөтөлбөр. БЖДБ-д үзүүлэх дэмжлэг туслалцааны хүрээнд УӨБ/БЗӨҮХөтөлбөрүүд нь эрчим хүч хэмнэх боломжийг олж тогтоон, байгаль орчны бохирдлыг бууруулах талаар зөвлөлгөө

**ЕСБХБ-ны бодлогын
хэлэлцүүлэг, банкны
салбар дахь холбоосыг
бэхжүүлэхэд энэхүү
танилцуулгын оруулах
хувь нэмэр**

өгдөг. Байгаль орчны доройтол, эрчим хүчний үр ашиг муутай хэрэглээний асуудлыг шийдвэрлэхэд нэгдсэн бүрэн хэмжээний шийдэл олох үүднээс эрчим хүчний үр ашиг/сэргээгдэх эрчим хүч, байгаль орчны хамгаалал, байгаль орчны баталгаажуулалтын асуудлуудыг нэгэн зэрэг авч шийдвэрлэх нь олонтаа байдаг. Цаашилбал, БЗӨҮХөтөлбөрийн хүрээнд эрчим хүчний хэмнэлт, байгаль орчны менежментийн төслүүдэд олгож буй татаасын хувь хэмжээ өндөр байдаг бөгөөд зах зээлийг хөгжүүлэх үйл ажиллагаагаараа дамжуулан эдгээр асуудлыг нийтэд сурталчлан таниулдаг.

УӨБ/БЗӨҮХөтөлбөрүүд нь эмэгтэйчүүдийн аж ахуй эрхлэлт, бизнес дэхь тэдгээрийн оролцоог дэмжин тухайн улсын шилжилтийн зорилтыг хангах суваг болгодог. УӨБХөтөлбөрийн туслалцааг олгохдоо хүйсийн байдлыг чухалчлан анхаарах бол БЗӨҮХөтөлбөр нь эмэгтэй хүний эзэмшил, удирдлаган дор байдаг аж ахуйн нэгжүүдэд илүү их буцалтгүй тусламж олгож, шинээр эхлэж буй бизнесийг хөхиүлэн дэмжих зорилгоор чиглэсэн сургалтууд зохион байгуулна.

Монгол Улсын тухай энэхүү танилцуулга нь бизнесийн орчинд дүн шинжилгээ хийн БЖДБ-ийн салбарт тулгамдаж буй гол сорилтуудыг олж тогтоох замаар ЕСБХБ-ны бодлогын яриа хэлэлцээ явуулах арга замыг бэхжүүлж байна. УӨБ/БЗӨҮХөтөлбөрүүд нь амжилтанд хүрч чадсан Монголын аж ахуйн нэгжүүдийг ЕСБХБ, түүнтэй холбоотой бусад санхүүгийн байгууллагууд танилцуулан хөрөнгө оруулалт хийх эсэх талаар судалгаа хийх боломжийг бүрдүүлж өгдөгөөрөө ЕСБХБ-ны банкны үйл ажиллагаанд чухал холбоос болж чадна. УӨБ/БЗӨҮХөтөлбөрүүд нь ЕСБХБ-ны хөрөнгө оруулалтаас өмнөх болон дараахь шатанд аж ахуйн нэгжүүдэд төслийн туслалцаа үзүүлж чадна.

УӨБ/БЗӨҮХөтөлбөрүүдийн 2008-2010 онуудын стратегийн төлөвлөгөөний дагуу эдгээр хөтөлбөрүүд нь дараахь байдлаар ЕСБХБ-наас хөрөнгө оруулалт хийх боломжтой эдийн засгийн үр ашигтай төслүүдийг жагсаалтыг гаргаж өгөн тус банкны зорилтыг хангахад дэмжлэг болсоор байх болно. Үүнд: (1) хэрэгжүүлэх боломжтой төслүүдийг олж тогтооход туслах (хөрөнгө оруулалтаас өмнөх шат), (2) ЕСБХБ-ны хувийн аж ахуйг санхүүжүүлэх төслүүдийн бэлтгэл ажлыг хангах, дэмжих зорилгоор, мөн аж ахуйн нэгжүүдэд өөрсдөд нь “зөвлөх, бизнес” үйлчилгээ үзүүлэх, (3) ТУЗ-ийн орон тооны бус гишүүдэд нэр дэвшигч санал болгох.

УӨБ/БЗӨҮХөтөлбөрүүд нь санхүүжилтийн хэрэгцээтэй байгаа БЖДБ-үүдийг ЕСБХБ-наас авч болох эх үүсвэртэй, түүний дотор шууд хөрөнгө оруулалт, ЕСБХБ-тай хамтран ажилладаг дотоодын банкуудын зээлийн шугамтай холбон өгнө.

Цаашилбал, УӨБ/БЗӨҮХөтөлбөрүүд нь Монгол Улсын Говийн өмнөд бүсийн нүүрсний уурхайг тойрон орших нутагт аж үйлдвэрийн бүс байгуулахад оролцоно. Нүүрсний энэхүү уурхайд ЕСБХБ ихээхэн хэмжээний хөрөнгө оруулалт хийсэн байгаа. Хөтөлбөрийн хүрээнд үзүүлэх туслалцаа нь аж үйлдвэрийн холбоосыг бэхжүүлэн дэмжиж, тус бүс нутагт тогтвортой хөгжил авчирах төлөвтэй байна.

Хавсралт 10 – Хоёр талт туслалцаа

Франц

2003 оноос хойш Францын Гадаад хэргийн яам Монгол Улсад хүнсний тусламж үзүүлэх тусгай санг ажиллуулж ирсэн. Одоо энэ сангийн үйл ажиллагаа бүхэлдээ нүүдлийн хүн амын хэрэгцээг хангахад чиглэсэн бичил зээл дээр төвлөрч байна. Тухайлбал хэдэн жилийн өмнө болсон их хэмжээний гангийн улмаас малаа алдсан малчдад шинээр мал авахад дэмжлэг үзүүлсэн. Одоо сангийн үйл ажиллагаа гол төлөв орон сууцны нөхцөл сайжруулахад зориулсан санхүүжилт олгож, хөдөө аж ахуйн үндсэн төхөөрөмж, үр худалдан авахад чиглэж байна.

2008 онд Франц, Монгол Улс хоорондын санхүүгийн хоёр протокол батлагдсан. Хэрэгжих шатандаа орсон эдгээр хөнгөлөлттэй зээлүүд нь Эрдэнэт хотын ус цэвэршүүлэх байгууламжийн барилгын ажилд (9 сая евро), Улаанбаатар хотын агаарын чанарт хяналт тавих төхөөрөмжийн худалдан авалтын (2 сая евро) санхүүжилтэнд зарцуулагдана.

2009 онд Францын хөгжлийн агентлаг, түүний салбар болох Пропаркогийн Монгол Улсад явуулах үйл ажиллагааны хүрээг өргөжүүлэх шийдвэрийг Францын Засгийн Газар гаргасан.

Төвлөрсөн бус хоёр талт хамтын ажиллагааны хүрээнд Францын орон нутгийн байгууллагаас Монгол Улсын эрүүл мэнд, боловсролын салбарт төслүүд хэрэгжүүлж байна.

ХБНГУ

Герман, Монголын харилцаа хуучин БНАГУ-ын үеэс тогтсон он удаан жилийн холбооноос үүдэлтэй маш их нөхөрсөг байж ирлээ. Монгол Улсад герман хэлээр ярьдаг хүмүүс олон байдаг. Монгол Улсад улс төр, эдийн засгийн өөрчлөлт эхэлсний дараагаар одоо хэрэгжиж байгаа хөгжлийн хамтын ажиллагаа 1991 оноос эхэлсэн. 1991 оноос өмнө Монгол Улс БНАГУ-аас хөгжлийн дэмжлэг авдаг байсан бөгөөд БНАГУ буцалтгүй тусламжийн хэмжээгээрээ ЗХУ-ын дараа ордог байсан.

Герман Улс 1991 оноос хойш нийтдээ 268 сая орчим еврогийн туслалцаа үзүүлсэн бөгөөд Монгол Улс Германаас нэг хүнд ногдох хамгийн их тусламж авсан орнуудын нэг болж байна. Энэ нь нэг талаас хоёр улсын хооронд байсан олон жилийн нөхөрсөг харилцааны, нөгөө талаас Монгол Улс ардчилсан болж байгааг хүлээн зөвшөөрч, бүтцийн өөрчлөлт, ядуурлыг бууруулах чиглэлээр хүчин чармайлт гаргаж байгааг үнэлсний илрэл билээ.

Герман-Монголын хөгжлийн хамтын ажиллагаа эхний ээлжинд тус улсад нүүрлэсэн үндсэн асуудлуудыг шийдвэрлэхэд анхаарсан. Үүнд:

- Зах зээлийн эдийн засгийг цогцлон байгуулж, эдийн засгийн шинэчлэлд дэмжлэг үзүүлэх (түүний дотор холбогдох хууль эрх зүйн орчин, зохих ёсоор ажиллах чадвартай санхүүгийн систем),
- Эрчим хүч, тээврийн дэд бүтэц нь тус улсын хувьд онцгой ач холбогдолтой байв,
- Байгаль орчны хамгаалал (байгалийн нөөцийн хамгаалал, сэргээгдэх эрчим хүч).

2001 оны 10-р сард нөхцөл байдал өөрчлөгдсөнийг (тус улсад гарсан өөрчлөлт хөгжил, бусад хандивлагчдын туслалцаа) харгалзан үзэж, мөн үр ашгийг нэмэгдүүлэх үүднээс цаашдын хамтын ажиллагаа дараахь тэргүүлэх чиглэлээр явагдахаар тохиролцсон. Үүнд:

- Эдийн засгийн тогтвортой хөгжил (хуучнаар: зах зээлийн эдийн засгийн тогтолцооны эдийн засгийн шинэчлэл, хөгжил),
- Байгаль орчны бодлого (түүний дотор эрчим хүчний үр ашиг, сэргээгдэх эрчим хүч, байгалийн нөөц).

Арга хэмжээнүүд нь хөдөө орон нутагт илүү төвлөрөх ёстой.

Туслалцааны төлөвлөгөөний тойм (1992 оноос хойш)

	Амласан дүн 1992-2001 ¹⁾ Сая евро (сая марк)	2002/03 (2 жилд амласан дүн) Сая евро	2004/05 (2 жилд амласан дүн) Сая евро	2006/07 (2 жилд амласан дүн) Сая евро	2008/2009 (2 жилд амласан дүн) Сая евро	Өнөөг хүртэл нийт амласан дүнгийн нийлбэр (1992 оноос) Сая евро
ФС	78,23 (153)	10	9 +9,3 ³⁾	9	9,0	124,53
ТХА шууд утгаараа	62,9 (123)	10 +1 ²⁾	11 +1 ⁴⁾	9,5 +0,5 ⁵⁾	9,5 +2,0 ⁶⁾	107,4
Дэд бүлгийн дүн	141,13 (276)	21	30,3	18,5	20,5	231,93
ТХА өргөн утгаараа					2,0	36,2
Нийт дүн⁷⁾						268,13

1) 1998 оноос төлөвлөгөөг хоёр жилээр хийх болсон.

2) Парламентын төрийн нарийн бичгийн даргын Монгол Улсад хийсэн айлчлалын үеэр амласан дүн: “Хуульчдын сургалт, дахин сургалт”-нд зориулсан 1 сая евро.

3) а) Дэлхийн хэмжээний ач холбогдол бүхий арга хэмжээний санхүүжилтэнд 3 сая евро (эрчим хүчний үр ашиг),

б) Бичил санхүүгийн байгууллага болох ХасБанкинд өөрийн хөрөнгө болгон хөрвүүлэх сонголттой 3 сая еврогийн хоёрдогч зээл (2005 онд батлагдсан),

в) орон сууцны барилгыг дэмжих 3.3 сая еврогийн зээлийн хөтөлбөр (2005 онд батлагдсан)

4) Дэлхийн хэмжээний ач холбогдол бүхий арга хэмжээний тусгай санхүүжилт (ДОХ-ыг сэргийлэх арга хэмжээ)

5) Байгаль орчны харилцаа холбоо, боловсролд зориулсан 0.5 сая еврогийн тусгай санхүүжилт (2007 онд батлагдсан)

6) Биологийн тархац, уур амьсгалын өөрчлөлтөнд зориулсан 2 сая еврогийн тусгай санхүүжилт

7) Германы мужууд, яамдын санхүүжилтийг оруулаагүй

Эх сурвалж: Германы Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн яам .

Итали

Итали, Монголын хамтын ажиллагааны тухайд Монгол Улсын эрүүл мэндийн тогтолцоог боловсронгуй болгох нь холбогдох байгууллагуудад дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн төсөл хэрэгжиж байгааг бид мэднэ.

Дээр дурьдсан төслийг Италийн Засгийн Газар 2006 оны 10-р сарын 9-нд баталсан бөгөөд Эх нялхсын эрдэм шилжилгээний төв дээр хэрэгжих юм. Төслийн хүрээнд 5 сая 160 мянган еврогийн хөнгөлөлттэй зээл, 396 мянган еврогийн буцалтгүй тусламжийн санхүүжилт олгогдох төлөвлөгөөтэй. Итали, Монгол Улсын Засгийн Газар хоорондын Харилцан ойлголцлын санамж бичигт 2007 оны 11-сард гарын үсэг зурсан. Төслийн зорилго нь Н. Гэндэнжамцын нэрэмжит ЭНЭШТ-ийн чадавхийг дараахь арга хэмжээгээр бэхжүүлэхэд оршиж байна. Үүнд: (1) эх, хүүхдийн эрүүл мэндийн хүндрэлийг эмчлэх (эмнэлгийн хамгийн дээд шатанд), (2) сургалт, судалгааны төв байх чадавхийг бэхжүүлэх, (3) удирдах ажилтнуудын удирдах болон зохион байгуулалтын

ур чадварыг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх, (4) эмнэлгийн шатлалын тогтолцоог боловсронгуй болгоход дэмжлэг үзүүлэх (Улаанбаатар хотын зарим захын эмнэлгүүдэд).

Хамтын ажиллагааны төслийн хүрээнд дараахь үндсэн арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд удахгүй эхлэх ёстой байгаа. Үүнд: тоног төхөөрөмж нийлүүлэх; нийтийн ажил (барилгын засвар, сайжруулалт); эмч, сувилагч нарын сургалт; тоног төхөөрөмжийн инженер, техникийн ажилчдын сургалт; зургаан эмнэлгийн харилцаа холбоо, шатлалын тогтолцоог боловсронгуй болгох.

Япон

Монгол Улс улс төр, эдийн засгийн шилжилтээ 1990 онд эхэлснээс хойш Япон Улс өөрийн хөгжлийн албан ёсны туслалцааны хөтөлбөрөөр дамжуулан шилжилтийн үйл явцыг идэвхтэй дэмжиж ирсэн. Шилжилтийн эхэн үед Японы дэмжлэг бужигнасан эдийн засгийг тогтворжуулж, төлбөрийн тэнцлийг дэмжих замаар нийгмийн салбарт үүссэн шахалтыг сулруулахад голлон чиглэхийн (1990-1993 онуудад нийтдээ 140 сая ам. доллар орчим) хажуугаар төмөр зам, дулааны цахилгаан станц зэрэг үндсэн дэд бүтцийн засвар, нөхөн сэргээлтэнд буцалтгүй тусламж, хөнгөлөлттэй зээлээр хөрөнгө оруулсан (1991-1995 онуудад 160 сая ам. доллар орчим).

2004 оны 11-р сард Япон Улс “Монгол Улсад туслалцаа үзүүлэх хөтөлбөр”-ийг боловсруулж, Японоос Монголд үзүүлэх туслалцааны бодлогын чиглэлийг тодорхойлсон үндсэн баримт бичиг болгосон. Уг бодлогын баримт бичигт тодорхойлсноор Японы үндсэн зорилгыг эдийн засгийн тогтвортой өсөлтөөр дамжуулан ядуурлаа бууруулах гэсэн Монгол Улсын өөрийгөө сайжруулах хүчин чармайлтыг дэмжихэд оршино гэсэн бөгөөд дараахь дөрвөн тэргүүлэх чиглэлийг тодруулжээ:

1. Зах зээлийн эдийн засгийг хөгжүүлэхэд шаардлагатай институцыг байгуулж, хүний нөөцийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх.
2. Хөдөөгийн хөгжилд дэмжлэг үзүүлэх (бүс нутгийн хөгжлийн төв дээр байрлалтай хөгжлийн загвар нутагт дэмжлэг үзүүлэх, бэлчээрийг сэргээх, малын үржил, фермерийн аж ахуй эрхлэх).
3. Байгаль орчны хамгаалалд дэмжлэг үзүүлэх (онгон байгалийг хадгалах, байгалийн нөөцийг зөв зохистой ашиглах, Улаанбаатар хотын байгаль орчны асуудлыг шийдвэрлэх арга хэмжээ).
4. Дэд бүтцийн хөгжилд дэмжлэг үзүүлж, эдийн засгийн үйл ажиллагааг хөхиүлэн дэмжих.

Японы туслалцаа одоо эдгээр тэргүүлэх чиглэлийн дагуу олгогдож байгаа бөгөөд сүүлийн жилүүдэд зээл, буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн томоохон төслүүд гэвэл ЖДБ-ийг хөгжүүлэх, байгаль орчныг хамгаалал 2 шатлалтай зээл, (ХАЁТ зээл: 2,981 сая иень буюу 22.1 сая евро), шинэ онгоцны буудлын барилга (ХАЁТ зээл: 28,807 сая иень буюу 213.7 сая евро), бага боловсролын барилга байгууламжийг сайжруулах (буцалтгүй тусламж: 7,441 сая иень буюу 55.2 сая евро), автозамын магистраль шугамыг сайжруулах (буцалтгүй тусламж: 199 сая иень буюу 1.5 сая евро) төмөр зам дээгүүр гүүрэн гарц барих (буцалтгүй тусламж: 3,658 сая иень буюу 27.1 сая евро). Хамгийн сүүлд 2009 оны 3-р сард Монгол Улсын төсвийн алдагдлыг санхүүжүүлэхэд зориулан 50 сая ам. долларын санхүүжилт олгохоо зарласан. Техник туслалцааны хөтөлбөрүүд нь байгаль орчин, хууль эрх зүйн шинэчлэл, хүний нөөцийн хөгжил зэрэг чиглэлээр хэрэгжиж байна.

Өмнөд Солонгос

Монгол Улс Азийн социалист орнуудын дундаас хамгийн түрүүнд 1990 онд Өмнөд Солонгос Улстай дипломат харилцаа тогтоосон юм. Тэр цагаас хойш Монгол Улсад зах зээлийн эдийн засгийн тогтолцоо нэвтэрч, хоёр талын харилцаа тогтвортой сайжирч ирсэн. Солонгосын Засгийн Газрын зүгээс хөгжлийн албан ёсны туслалцааны хэмжээгээ тус улсын дэлхийн эдийн засагт эзэлдэг байр суурьтай нийцүүлэн нэмэгдүүлэх замаар хөгжил, хамтын ажиллагаагаа нэмэгдүүлэх бодлогыг саяхан гаргаж тавьснаар Монгол Улсад олгож буй туслалцаа илүү хурдацтай нэмэгдэж байна.

Солонгосын Эдийн засгийн хөгжил, хамтын ажиллагааны сангаас (СЭЗХХАС) Монголд үзүүлдэг туслалцаа 1991 онд 5.2 сая ам. доллар байсан бол 2008 онд гэхэд 84 сая ам. доллар болж нэмэгджээ. Олгохоор амласан туслалцааны өссөн дүнгээр Монгол Улс дэмжлэг авдаг 45 улсаас 14 дүгээрт жагсаж, СЭЗХХАС-гийн хөрөнгийн 2 хувьтай тэнцэж байна. СЭЗХХАС-гийн санхүүжилтүүд нь гол төлөв мэдээллийн технологи, харилцаа холбоо, тээвэр, эрчим хүч, эрүүл мэнд, төрийн харилцаа холбооны сүлжээг хөгжүүлэхэд зориулагдсан байна.

Монгол Улс Солонгосын буцалтгүй тусламжаас тэргүүн ээлжинд хүртэх ёстой орнуудын тоонд багтдаг. Монгол Улсад олгосон буцалтгүй тусламжийн хэмжээ 1991 онд 1.5 сая ам. доллар байсан бол 2008 онд 12.3 сая ам. доллар болж нэмэгдсэн нь өмнөх оноос 105.4 хувиар их байна. Нийт олгосон тусламжийн дүн 2008 онд 39 сая ам. доллар хүрсэн байв. Буцалтгүй тусламжийг олгох 2007 оны амлалт төлөвлөгөөний хувьд Монгол Улс 170 орноос 10 дугаар бичигдэж, нийт тусламжийн 2.6 хувийг эзэлж байна. Буцалтгүй тусламж дэд бүтэц, хүний нөөц, хөдөө орон нутаг, эрүүл мэнд, гамшгийн уршгийг арилгах, нөхөн сэргээх, МХЗ-ууд, ТББ, олон улсын байгууллагын үйл ажиллагаанд үндсэндээ чиглэжээ.

Солонгосын Монгол Улсад оруулсан шууд хөрөнгө оруулалт 2008 онд өмнөх оноос 31.7 хувиар буюу 58.4 сая ам. доллараар нэмэгджээ. 2007 онд хөрөнгө оруулалтын жилийн өсөлт 128.6 хувь байсан бол дэлхийн санхүү эдийн засгийн хямралын улмаас 2008 онд 31.7 хувь болж саарчээ. Монгол Улсад Солонгосын шууд хөрөнгө оруулалтаар үүсгэн байгуулагдсан аж ахуйн нэгжийн тоо 2008 онд өмнөх онтой харьцуулахад 46.3 хувь буюу 79-өөр өсчээ. Эдийн засгийн салбарын хувьд мэдээлэл, харилцаа холбооны салбарт хамгийн их хөрөнгө оруулалт хийгдсэн бөгөөд түүний дараа уул уурхай, түрээс, барилгын салбарууд орж байна.

Солонгос, Монголын хоёр талт туслалцаа (1991-2008)

Сая ам. доллар	1991-2000	2001	2002	2003	2004	2005	2006	2007	2008	Нийт
СЭЗХХАС	33.7	-	-	-	23.9	-	26.3	-	-	83.9
Буцалтгүй тусламж	8.5	2.1	0.9	1.7	1.8	2.8	3	6	12.3*	39.0
Гадаадын хөрөнгө оруулалт	11.6	2.6	2.9	1	3.3	6.7	19.4	44.3	58.5	150.3

* Урьдчилсан тоо

БНСУ-ын Засгийн Газар Монгол Улсын хөгжилд хувь нэмрээ оруулахын төлөөх хүчин чармайлтаа үргэлжлүүлж, хоёр улсын хоорондын эдийн засгийн болоод дипломат харилцааг бэхжүүлэх голлох үүрэг гүйцэтгэхийг зорьж байна.

Люксембург

ЕСБХБ-ны Монголын хамтын ажиллагааны санд 1 сая еврогийн эх үүсвэр хандивлахын зэрэгцээ Люксембург Улс нь Монгол Улсад хоёр талт хамтын ажиллагааны хөтөлбөрөө үр дүнтэй хэрэгжүүлж байна. Энэхүү хөтөлбөр нь эрүүл мэнд, байгаль орчин, санхүүгийн салбаруудад төвлөрч байна.

Зүрх судасны өвчнөөс сэргийлэх ажил, эмчилгээг сайжруулахад чиглэсэн эрүүл мэндийн хөтөлбөр 2001 оноос хэрэгжиж эхэлсэн бөгөөд Люксембургийн талаас олгох санхүүжилт 2010 хүртэл сунгагдаж нийтдээ 2.5 сая евро зарцуулахаар төлөвлөжээ.

Өөрийн хөтөлбөрийг нөхөн баяжуулах үүднээс эхийн эрүүл мэндийн теле эмчилгээний төсөлд 1 сая еврогийн санхүүжилт олгож байгаа. Монгол, Хятадын хил дээр ДОХ-оос сэргийлэх төслийн санхүүжилтэнд мөн 230 мянган еврогийн дэмжлэг үзүүлж байгаа.

Байгаль орчны салбарт, гамшигтай тэмцэхэд зориулан 1 сая еврогийн санхүүжилт олгосон.

Санхүүгийн салбарт Люксембургийн Засгийн Газраас 1 сая гаруй еврогийн санхүүжилт гаргаж, Монгол Улсын техник туслалцааны хэрэгцээг хангахад зориулсан. Энэ хүрээнд сургалт, зөвлөх үйлчилгээний хөтөлбөрүүд хэрэгжсэн бөгөөд эдгээрийг Люксембургийн Засгийн Газрын мэргэжлийн санхүүгийн байгууллага болох АТТФ зохион байгуулсан юм. Энэ байгууллага нь 1999 онд үүсгэн байгуулагдсан бөгөөд банк, санхүүгийн шинэлэг мэдлэг туршлагыг шинэ тутам хөгжиж байгаа орнуудад шилжүүлэх зорилготой юм.

АТТФ нь Монгол Улсад Сангийн яам, Монголбанк, Даатгалын байгууллагуудын холбоо, Санхүүгийн зохицуулах хороотой хамтран ажиллаж, дараах асуудлуудыг хамардаг. Үүнд: санхүүгийн төвийн үйл ажиллагаа; зах зээлийн эдийн засгийн тогтолцоон дахь банк, санхүүгийн салбар; зээлийн үнэлгээ; банкны үйл ажиллагааны эрсдэл; банкны үйл ажиллагааны гүйцэтгэл; банкны маркетинг ба стратегийн төлөвлөлт; салбарын удирдлага; хөндлөнгийн болоод дотоод аудит; олон улсын санхүүгийн зах; даяарчлал; эрсдэлийн удирдлага; актив, пассивын удирдлага; хувийн банкны үйл ажиллагаа; санхүүгийн шинэ бүтээгдэхүүнүүд; харилцааны ур чадвар; манлайлал; хүний нөөцийн удирдлага; мөнгө угаахтай тэмцэх зэрэг эдгээр болно.

2009 оноос СЗХ дээр чадавхи бэхжүүлэх, сургалтын хөтөлбөр хэрэгжиж эхлэх бөгөөд эхний ээлжинд 2 сая еврогийн санхүүжилт хуваарилаад байна. Мөн түүнчлэн, Монгол Улсад бичил даатгалын зах зээлийг хөгжүүлэхэд чиглэсэн 1 сая еврогийн санхүүжилттэй чадавхи бэхжүүлэх хөтөлбөр байгаа. Цаашилбал, Монгол Улсын тэтгэврийн тогтолцоог бэхжүүлэхэд зориулсан хөтөлбөрийн санхүүжилтэнд 500 мянган евро олгосон.

Мөн түүнчлэн Монголын оюутнуудыг Люксембургийн Санхүүгийн сургуульд өдрийн ангид элсэн суралцах боломжийг олгох зорилготой хөтөлбөр 2005 оноос хойш хэрэгжиж, сургалтын төлбөрийг дааж байна.

Одоогоор Люксембург дээрх бүх төслүүдэд нийтдээ 10.5 сая еврогийн санхүүгийн туслалцаа олгоод байна.

Голланд Улс

Голландын Засгийн Газрын санхүүжилттэй хөгжлийн хамтын ажиллагааны Монгол Улсад хэрэгжиж буй хөтөлбөрийн үндсэн зорилго нь эдийн засгийн хөгжлийг хангаж, улмаар ядуурлыг бууруулах байгаль орчны тогтвортой нөхцлийг бий болгоход оршиж байна. Иймд Голландын хөгжлийн хамтын ажиллагааны хөтөлбөр нь байгаль орчны салбарт чиглэж байна.

Тэргүүлэх чиглэлийг сонгохдоо Монголын болоод Голландын бодлогод гарсан өөрчлөлтүүд, бусад хандивлагчдын үйл ажиллагаа, Уур амьсгалын өөрчлөлт, билологийн тархацын олон улсын конвенцийн дагуу Монгол Улсын хүлээсэн үүрэг зэргийг үндэслэсэн. Байгаль орчны хөтөлбөрийн эцсийн зорилго нь НҮБ-ийн Мянганы хөгжлийн зорилтуудад заасан тогтвортой хөгжлийн болоод (шууд бусаар) ядуурлыг бууруулах олон улсын зорилтууд, мөн түүнчлэн Тогтвортой хөгжлийн дэлхийн чуулганаас тогтоосон зорилтуудыг хангахад Монгол Улсад туслалцаа үзүүлэхэд оршиж байна.

Тодруулбал, байгаль орчны хөтөлбөр нь Монгол Улсын хувьд онцгойлон хамааралтай гэж үзсэн дараахь чиглэлүүдэд анхаарч байна. Үүнд:

- Байгаль орчны хамгаалал ба тогтвортой ашиглалт (тал хээр, ой, усны нөөцийн ашиглалтыг зохицуулахад анхаарах);
- Ундны усны хүртээмжийг нэмэгдүүлэх;
- Уур амьсгалын өөрчлөлттэй дасан зохицох.

Байгаль орчны хөтөлбөрийг Парисын Деклараци, Европын холбооны Ёс зүйн дүрмийн дагуу тогтвортой хөгжлийн зарчимд нийцүүлэн хэрэгжүүлж, хандивлагчид болон Монгол Улсын Засгийн Газар хоорондын уялдаа холбоог бүрэн хангаж, тохируулахад онцгойлон анхаарна.

Голландын хөгжлийн хамтын ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд хэрэгжиж байгаа арга хэмжээнүүд нь дээр дурьдсан тэргүүлэх чиглэлүүдтэй нийцэхийн зэрэгцээ Монгол Улсын Засгийн Газрын мөрийн хөтөлбөр, хөгжлийн бусад стратеги, Голландын хөгжлийн хамтын ажиллагааны бодлого, түүний дотор “GAVIM” зорилтуудтай (сайн засаглал, ядуурлын бууралт, эмэгтэйчүүд ба хөгжил, институцийн чадавхи, байгаль орчин гэсэн Голланд үгсийн товчлол) уялдах ёстой. Голландын бодлого нь үр дүнгийн баримжаанд суурилсан бөгөөд МХЗ-ын хангах Голландын зорилтуудад шууд чиглэх учиртай.

Төслийн үндсэн түншүүд нь Монгол Улсын яам, тамгын газрууд, тухайлбал, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, УСУГ болон Vitens Evides International, Монгол, Голландын улаан загалмайн нийгэмлэг, Хустайн траст сан, Дэлхийн Банк, ГТТН, НҮБХХ, ХХААБ ба Азийн Сан юм.

Монгол Улсын Хөгжлийн хамтын ажиллагааны олон жилийн стратегийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх жилийн төсөв нь 9 сая орчим евро юм. Энэхүү төлөвлөгөөний зохицуулалтыг Голландын нэгдсэн вант улсын элчин сайдын яам хэрэгжүүлж, Голландын элчин сайдын яамны Улаанбаатар хот дахь төлөөлөгчийн газраас дэмжлэг үзүүлдэг. 2001-2008 онуудад Голландын Засгийн Газар нийтдээ 47 сая ам. долларын ХАЁТ өгсөн байна (тэгэхлээр Германы дараа ЕХ-ны хамгийн том хандивлагч). Одоогийн жилийн төсөв 8.2 сая евро байна.

Америкийн Нэгдсэн Улс

АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлаг (АНУОУХА) нь Монгол Улсад хоёр талт туслалцаа үзүүлэхэд тэргүүлэх үүрэг гүйцэтгэдэг. Тус агентлагын хэрэгжүүлдэг хөтөлбөрийн хүрээнд нэг үндсэн чиглэлийг онцгойлон анхаардаг: тогтвортой бөгөөд хувийн хэвшлээр манлайлуулсан эдийн засгийн өсөлт ба илүү үр дүнтэй, хариуцлагатай засаглал. 1991-2008 онуудад АНУОУХА-ийн нийт туслалцаа 174.5 сая орчим ам. доллар байсан бөгөөд бүгд буцалтгүй тусламж байжээ. АНУОУХА-ийн Монгол дахь хөтөлбөрийн 2007 оны санхүүгийн жилийн 6.625 сая ам. долларын төсвийн хүрээнд дараахь арга хэмжээнүүд хэрэгжинэ. Үүнд: а) макро эдийн засгийн бодлогын шинэчлэл, эрчим хүчний салбарын бүтцийн өөрчлөлт, санхүүгийн салбарын шинэчлэл, бичил, жижиг бизнесийн хөгжлийг дэмжсэн үйл ажиллагаан дээр анхааран эдийн засгийн өсөлтийг дэмжих; б) шүүх засаглалын шинэчлэл, сонгуулийн шинэчлэл, парламентын шинэчлэл ба авилгатай тэмцэх чиглэлийн арга хэмжээн дээр анхааран шударга, ардчилсан засаглалыг бүрдүүлэх.

1993 оноос хойш АНУ-ын Хөдөө аж ахуйн яам Дэвшлийн төлөөх хүнс, 416(b) хөтөлбөрийн хүрээнд Монгол Улсад хүнсний тусламж үзүүлж ирсэн. Хүнсний тусламжийн борлуулалтын орлогыг (2006 онд 4.2 сая ам. доллар) аж ахуй эрхлэлтийг дэмжих, малчдын амьжиргааны эх үүсвэрийг төрөлжүүлэх, мал эмнэлгийн үйлчилгээг сайжруулахад чиглэсэн хөтөлбөрийн санхүүжилтэнд ашигладаг.

АНУ батлан хамгаалах ажиллагааны шинэчлэл, Монгол Улсын зэвсэгт хүчнийг олон улсын энхийг сахиулах үйл ажиллагаанд оролцох чадавхийг нэмэгдүүлэхийг дэмжиж ирсэн. Монгол Улс 2003 оноос хойш Ирак, Афганистан дахь холбоотны үйл ажиллагаанд цөөн тооны анги нэгтгэлээ явуулснаар 2005 онд НҮБ, НАТО-гийн энхийг сахиулах ажиллагаанд зэвсэгт энхийг сахиулагчдаа илгээх туршлагатай болсон.

Энх тайвны корпус Монголд 100 орчим сайн дурынхантай үйл ажиллагаагаа явуулж байна. Сайн дуранхан юуны түрүүнд англи хэл заах, багш нарыг сургах ажил хийж байна. Монгол Улсын Засгийн Газрын хүсэлтээр Энх тайвны корпус нь нийтийн эрүүл мэнд, жижиг бизнесийн хөгжил, залуучуудын хөгжил чиглэлээр хөтөлбөрүүд боловсруулан хэрэгжүүлж байна. 2005, 2006 онуудад Монгол Улсын төр засгийн албан тушаалтнууд, түүний дотор Ерөнхийлөгч Энхбаяр, Ерөнхий сайд Элбэгдорж нар тус улсад ажиллаж буй сайн дурын ажилтнуудын тоог үлэмж нэмэгдүүлэх хүсэлт тавьсныг Энх тайвны корпус хүлээн авч 2010 он хүртэл жил бүр бага багаар нэмэгдүүлэх төлөвлөгөөтэй байгаагаа илэрхийлсэн.

2004 оноос шинээр хэрэгжиж эхэлсэн Мянганы сорилтын сангаас хамгийн түрүүнд санхүүжилт авах эрх үүссэн улсуудын нэг нь Монгол Улс байсан. Тус сангийн үйл ажиллагааг Мянганы сорилтын корпораци хэрэгжүүлдэг. 2007 оны 10-р сарын 22-нд Цагаан ордонд болсон ёслолын арга хэмжээн дээр Ерөнхийлөгч Буш, Ерөнхийлөгч Энхбаяр нар Монгол Улстай байгуулах Мянганы сорилтын гэрээг үзэглэж, 2008 оны 9-р сараас эхлэн 5 жилийн хугацаанд хэрэгжих 4 төслүүдэд 285 сая ам. доллар зарцуулах болсон. Гэрээний дөрвөн үндсэн чиглэлд, түүний дотор төмөр замын техникийн шинэчлэл, өмчийн эрх, мэргэжлийн сургалт, эрүүл мэндийн салбарт анхаарч, Монгол Улсын эдийн засгийн хөгжлийг өргөжүүлэн, гүнзгийрүүлэх болно.

Хавсралт 11 – Шилжилтийн үеийн сорилт бэрхшээлийн үнэлгээ

Доорхи хүснэгтэнд Монгол Улсын шилжилтийн үеийн сорилт бэрхшээлийн 2009 оны байдлаар ерөнхий үнэлгээг харуулав (Монгол Улс 2005 оны үнэлгээнд хамрагдаагүй байсан). Онооны хувьд ялихгүй, жижиг, дунд, том гэсэн үнэлгээтэй. “Ялихгүй” гэдэг нь үлдэж байгаа сорилт бэрхшээлүүд нь маш жижиг, тухайн салбар бүрэн ажиллагаатай зах зээлийн эдийн засгийн тогтолцоо уруу шилжихэд туг ойртсон. “Том” гэдэг нь үлдэж байгаа сорилт бэрхшээлүүд нь томоохон бөгөөд тухайн салбар цар хэмжээний хувьд шинэчлэлийн эхэн шатанд явж байна. 2009 оны ерөнхий үнэлгээг гаргахдаа зах зээлийн бүтэц, зах зээлийн тогтолцоог дэмжигч байгууллагууд, бодлого тус бүрийн үнэлгээн дээр үндэслэсэн (тусгай хавсралтаар танилцуулсан аргачлалыг үзнэ үү).

Монгол Улс	Зах зээлийн бүтэц	Зах зээлийн байгууллагууд	2009 оны үр дүн
Хөдөө аж ахуй	Дунд	Дунд	Дунд
Ерөнхий аж үйлдвэр	Том	Дунд	Том
Үл хөдлөх хөрөнгө, аялал жуулчлал	Том	Том	Том
Харилцаа холбоо	Том	Дунд	Дунд
Хот, байгаль орчны дэд бүтэц	Дунд	Том	Том
Байгалийн нөөц	Дунд	Том	Том
Цахилгаан	Том	Том	Том
Тогтвортой эрчим хүч	Том	Том	Том
Тээвэр	Том	Дунд	Том
Банк	Дунд	Дунд	Дунд
Даатгал, санхүүгийн үйлчилгээ	Том	Дунд	Том
БЖДБ	Том	Дунд	Дунд
Хувийн эзэмшил, хөрөнгийн зах зээл	Том	Дунд	Том

1. Салбар тус бүрийн шилжилтийн үеийн сорилт бэрхшээлийн үнэлгээ

1.1 Аж ахуйн нэгж

Хөдөө аж ахуй

Зах зээлийн бүтэц: Дунд

Байгууллага/бодлого: Дунд

Монгол Улс худалдаа, үнийг чөлөөлөх үйл ажиллагааг харьцангуй эрт эхлүүлж, 1996 он гэхэд дуусгасан. Мөн түүнчлэн хөдөө аж ахуйн салбарт олгодог татаас маш бага бөгөөд Засгийн Газраас талхны үнэн дээр зохицуулалт хийдэг нь онцгой тохиолдол юм. Том, дунд аж ахуйн нэгжийн хувьчлал үндсэндээ хийгдэж дууссан. Гэвч хөдөө аж ахуйн салбарын өрсөлдөөн, салбарын хэмжээний өртгийн сүлжээний бүтцийн өөрчлөлт удаан явагдаж байгаа бөгөөд орчин үеийн жижиглэнгийн худалдаа хөгжиж амжаагүй байна. Чанар, эрүүл ахуйн стандартууд нийт салбарын хэмжээнд томоохон сорилт хэвээр байна. Хамгийн том хүндрэл гэвэл хөдөө орон нутагт санхүүжилт дутагдалтай, агуулах, логистик, тусгай хэрэгцээний дэд бүтэц, анхан шатны боловсруулалтын байгууламж зэрэг хөдөө орон нутгийн дэд бүтцэд хөрөнгө оруулалт хангалттай хийгдэхгүй байна.

Ерөнхий аж үйлдвэр

Зах зээлийн бүтэц: Том

Байгууллага/бодлого: Дунд

Ерөнхий аж үйлдвэрт зах зээлийн гажуудал хязгаарлагдмал байна. Томоохон аж ахуйн нэгжүүд бараг бүгдээрээ хувьчлагдаж, зарим тохиолдолд гадаадын хөрөнгө оруулагчийг татаж чадсан. Гэхдээ өнөөг хүртэл хийгдсэн гадаадын хөрөнгө оруулалтын ихэнх хэсэг нь уул уурхайн салбарт байна. Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг өргөжүүлж, хуучин төрийн өмчит аж ахуйн нэгжийг бүтцийн өөрчлөлтөнд хамруулах нь бүтээмж, үр ашгийг нэмэгдүүлэх түлхүүр болоод байна. Мөн түүнчлэн, зах зээлийн тогтолцоог дэмжигч байгууллагуудыг бэхжүүлэн зах зээлд нэвтрэх, гарах нөхцлийг зөөлрүүлж, компанийн засаглал, бизнесийн стандартуудыг боловсронгуй болгох нь томоохон сорилт болж байна.

Үл хөдлөх хөрөнгө, аялал жуулчлал

Зах зээлийн бүтэц: Том

Байгууллага/бодлого: Том

Үл хөдлөх зах зээл дөнгөж хөгжиж эхэлж байгаа бөгөөд чанарын шаардлага хангасан орон сууц ихээхэн дутагдалтай, бизнесийн зориулалттай орчин үеийн үл хөдлөх хөрөнгийн нийлүүлэлт бүх салбарт байхгүй байна. Хууль эрх зүйн орчны хүрээнд барьцааны хөрөнгийн тухай ойлголтыг хүлээн зөвшөөрдөггүй бөгөөд орон сууцаар барьцаалагдсан зээл буюу ипотекийн хууль тогтоомж байхгүй байгаагаас ипотекийн зах зээл маш бага хэмжээтэй хэвээр байна. Гэхдээ зээлийн эх үүсвэрийг (ипотекийн хөрөнгийг банк, бусад хөрөнгө оруулагч нараас худалдан авах/худалдах) нэмэгдүүлэх үүднээс арилжааны банкууд Төвбанкт хамтран Монголын Ипотекийн Корпорацийг үүсгэн байгуулаад байгаа. Монголчууд өмчилж байгаа газраа бүртгүүлж, гэрчилгээ авах боломжгүй байгаагаас үл хөдлөх хөрөнгийн бодит өмчлөлийг хангахад ноцтой бэрхшээл болж байна. Цаашилбал, худалдаа арилжаа, хөдөө аж ахуй, аялал жуулчлал, аж үйлдвэрийн зориулалтаар газар хайж байгаа хөрөнгө оруулагч нарт саад болж байна. Кадастрын судалгаа, газрын бүртгэлийн төслийн хүрээнд хувьчлагдахаар заагдсан газрын зураглалыг гаргаж, тодорхой үр дүнд хүрсэн. Үл хөдлөх хөрөнгийн эрхийн төсөл одоо хэрэгжиж байгаа бөгөөд энэ хүрээнд газрын эрхийг хүлээн зөвшөөрч бүртгэх, шилжүүлэх албан ёсны тогтолцооны үнэн зөв байдал, хүртээмж, үр ашиг нэмэгдэхээр байгаа. Аялал жуулчлал бол Монгол Улсын өсөлттэй байгаа салбар бөгөөд гадаадын хөрөнгө оруулалттай хэд хэдэн зочид буудлууд Улаанбаатар хотод үйл ажиллагаагаа явуулж байна. Гэхдээ томоохон сорилтууд, нэн ялангуяа хөдөө орон нутагт байсаар байна. Газрыг худалдах боломж бодит байдал дээр хязгаарлагдмал байгаа.

Харилцаа холбоо

Зах зээлийн бүтэц: Том

Байгууллага/бодлого: Дунд

Харилцаа холбооны зах зээл 2001 он гэхэд бүрэн чөлөөлөгдсөн хэдий ч суурин утасны зах зээлд өрсөлдөөн хязгаарлагдмал байна. Учир нь бусад таван операторууд суурин утасны зах зээлийн 10 орчим хувийг л авч чадсан байна. Салбарын зохицуулагч нь үйл ажиллагаагаа тусгай зөвшөөрлийн төлбөр, зохицуулалтын үйлчилгээний төлбөр, долгион ашиглалтын төлбөрийн орлогоор санхүүжүүлж байгаа хэдий ч үйлчилж буй

торгуулийн дээд хэмжээ нь их биш бөгөөд харилцан холболт асуудалтай хэвээр байна. Хүртээмж, нэн ялангуяа хөдөө орон нутагт, үнэ өртөг нь шийдвэрлэх шаардлагатай асуудал хэдий ч нийтэд хүртээмжтэй сан байгуулагдсан. Мөн түүнчлэн төр засгаас олгодог хөдөө орон нутагт харилцаа холбооны сүлжээ байгуулахад зориулсан татаасын эрх олгох тендер шалгаруулалтын ил тод тогтолцоо бүрдэж чадсан. 2005-2006 онуудад үүрэн телефоны тусгай зөвшөөрлийг Юнител, хөдөөгийн үүрэн оператор Жи-мобайлд олгосноор үүрэн телефоны дөрвөн оператортой болсон. Ингэснээр Монгол Улсын үүрэн холбооны салбарт үсрэнгүй өсөлт бий болж, зах зээлийг давамгайлж байсан Мобиком компанийн зах зээлд эзлэх хувийг багасгасан. Хэдэн жилийн өмнө тус компани нийт зах зээлийн 90 хувь орчмыг эзэлж байсан бол 2008 оны 6 дугаар сарын байдлаар 65 хувь болж багасчээ. Интернетийн нэвтрэлт хот суурингийн төвөөр өндөр үзүүлэлттэй, гэхдээ хөдөөгийн хэрэглээ нэмэгдэж байгаа бөгөөд аймгийн төвүүдийн 50 гаруй хувь нь өндөр хурдны Интернет ашиглах боломжтой болжээ. Өргөн зурвасын хэрэглэгчдийн нэвтрэлтийн түвшин маш бага хэвээр байна.

Эрчим хүч, дэд бүтэц

Хот, байгаль орчны дэд бүтэц

Зах зээлийн бүтэц: Дунд

Байгууллага/бодлого: Том

1995 онд батлагдсан Усны тухай хуулинд заасны дагуу хотын захиргаа цэвэр бохир усны нөөцлөлтийг зохицуулж, үнэ тарифыг (мөн журмыг) тогтоох эрхтэй болсон. Хувийн хэвшлийн оролцоо энэ салбарт цөөн хэдэн менежментийн гэрээ ороод хязгаарлагдмал байсан. Одоо мөрдөгдөж буй үнэ тариф нь ихэнх үйлчилгээний төрөл, хэрэглэгчдийн бүлгийн хувьд зардал нөхөхүйц түвшинд тогтоогдсон ч цэвэр усны нэгдсэн сүлжээний хүртээмж нийслэл Улаанбаатар хотод хүртэл маш хязгаарлагдмал байна. Тоолуур ашиглалтын хувьд энэ салбар хамгийн их хоцрогдсон.

Нийтийн тээврийн автобусны компаниудыг аж ахуйн тооцоонд шилжүүлсэн хэдий ч хөрөнгө оруулалтын ихэнх хэсгийг хандивлагчид санхүүжүүлж байна. Тээврийн үйлчилгээг аж ахуйн тооцоонд оруулах чиглэлээр маш бага дэвшил гарч, үнэ тариф хэтэрхий доогуур тогтоогдож байна. Хотын тээврийн төлөвлөлтийн хөгжил муу, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний зохицуулалт дөнгөж бүрдэж эхэлж байна.

Байгалийн баялаг

Зах зээлийн бүтэц: Дунд

Байгууллага/бодлого: Том

Монгол Улсын уул уурхайн салбар бол үндэсний эдийн засгийн үндсэн тоглогч бөгөөд ДНБ-ий бараг 30 хувь, экспортын орлогын 65 хувийг эзэлж байна. Уурхайнууд компанийн бүтэцтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байгаа хэдий ч нүүрсний олборлолтонд төр давамгайлсан хэвээр байж, алдагдалтай ажиллаж байгаа нүүрс олборлогч нарт татаас олгож байна. Монгол Улс нь газрын тосны жижиг нөөцтэй хэдий ч боловсруулах үйлдвэр байхгүйгээс импортын түлшнээс хамааралтай байна. Бензин түлшний жижиглэнгийн зах зээл бүрэн чөлөөлөгдсөн бөгөөд төрийн өмчит монополь байсан НИК компанийг Петровис компани худалдан авснаар энэ салбарт хувийн хэвшлийнхэн давамгайлж байна. Зах зээлд оролцогчдын тоо хязгаарлагдмал, мөн Петровис-НИК компанийн зах зээлийн томоохон хэсгийг эзэлж байгаа учраас өрсөлдөөн бага хэвээр байна.

Зах зээлийн дэмжигч байгууллагууд, бодлого сул дорой хэвээр бөгөөд томоохон цоорхойнууд байсаар байна. Уул уурхайн салбарт үйлчилдэг зохицуулалтын тогтолцоонд саяхан оруулсан өөрчлөлтүүд нь тус улсын гадаадын хөрөнгө оруулагч нарыг татах чадварт сөргөөр нөлөөлөх эрсдэл агуулж байна. 2006 онд шинээр батлагдсан Ашигт малтмалын тухай хуулинд металл олборлолтын үйл ажиллагааны нөөц ашигласны төлбөрийг өсгөж, татварын хөнгөлөлт чөлөөлөлтийг хүчингүй болгосон. Түүгээр үл барам 2006 оны 5 дугаар сараас алт, зэсэнд гэнэтийн ашгийн татвар оногдуулах болсон. Шинэ хуулийн дагуу Засгийн Газар хувийн хөрөнгөөр хайгуул хийж илрүүлсэн стратегийн орд газарт 34 хүртэл хувийн оролцоо, төсвийн хөрөнгөөр хайгуул хийж илрүүлсэн стратегийн орд газарт 50 хүртэл хувийн оролцоотой байх эрхтэй болсон.

ОСИТБС-ыг хэрэгжүүлж эхэлсэн нь нөөцийн орлогын удирдлага, ил тод байдлыг бэхжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэж байна. Монгол Улсын анхны тайлан 2008 оны 2 дугаар сард гарсан бөгөөд тайланд уул уурхайн компаниудын хийсэн төлбөр, Засгийн Газрын хүлээн авсан орлогыг 2006 оны байдлаар гаргажээ. Гэхдээ хөндлөнгийн аудитууд хэд хэдэн асуудлыг гаргаж тавьснаар нэмж шалгах шаардлагатай болсон. Аж үйлдвэр, худалдааны яамны хэрэгжүүлэгч агентлаг болох ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох чиг үүрэг бүхий Ашигт малтмалын газрын чадавхийг бэхжүүлэх зорилгоор ЕСБХБ нь хандивлагчдаас хөрөнгө босгосон. Тус газар нь төдийлөн бүрэн бие дааж амжаагүй байгаа бөгөөд цаашид шийдвэрлэх ёстой гол сорилт нь чадавхиа бэхжүүлэх, нэн ялангуяа цаашид төр засаг уул уурхайн салбарт илүү үүрэг рольтойгоор оролцохтой холбогдуулан бэхжүүлэх явдал болоод байна. Үр дүнтэй зохицуулалт хийж чадах тогтолцоог бүрдүүлэн хөгжүүлэх нэн чухал байх болно.

Цахилгаан

Зах зээлийн бүтэц: Том

Байгууллага/бодлого: Том

Монгол Улсын цахилгааны систем компанийн бүтцэд шилжиж, хуулийн дагуу задарсан бүтэцтэй хэдий ч төрийн өмчит хэвээр байна. Том нутаг дэвсгэртэй хэдий ч цахилгааны зах зээл бага учраас бодит байдал дээр томоохон сорилтууд тулгарч байна. Зохицуулалтын тогтолцоо сул, их хэмжээний зээл авсны үр дагаврын улмаас энэ салбарыг хувьчлах оролдлого амжилтанд хүрч чадаагүй. Саяхан концессийн нөхцөлтэйгээр шинээр барих дулааны цахилгааны станцийн тендер шалгаруулалтыг зарласан хэдий ч нэг л санал ирсэн нь Хятадын компаниас байсан бөгөөд одоо яриа хэлэлцээр явагдаж байгаа. Цахилгаан үйлдвэрлэх систем хуучирсаар, агаарыг бохирдуулсан, үр ашиггүй хэвээр байгаагийн зэрэгцээ нийлүүлэлтийн дутагдлыг ОХУ-аас авч нөхөж байна. Говийн Өмнөд бүсэд төр, хувийн хэвшлийн түншлэлийн хэд хэдэн төслүүд яригдаж байгаа бөгөөд эдгээр нь БНХАУ уруу цахилгаан худалдах эсвэл ашигт малтмалын олборлолтыг явуулахад шаардлагатай цахилгааныг нийлүүлэх зорилготой. Эдгээр төслүүдийг баталж хэрэгжүүлэхийн тулд төр, хувийн хэвшлийн түншлэлийн төслүүд дээр ажиллах төр засгийн зохицуулалт, гэрээний чадавхийг бэхжүүлэх шаардлагатай. Үнэ тарифыг өсгөсөн хэдий ч өртөг нөхөхүйц түвшинд хүрч чадаагүй байна. 2008 онд орлого багатай өрхүүдэд цахилгааныг үнэгүй нийлүүлэх шийдвэрийг Засгийн Газраас гаргасан. Эрчим хүчний салбарт тулгарч байгаа шилжилтийн үеийн сорилтууд гэвэл цахилгааны салбарын компаниудын бүтцийг өөрчлөх, тэдгээрийн өрийн асуудлыг шийдвэрлэх, байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг нь эрс сайжруулах, зохицуулагч байгууллагын хараат бус бие даасан байдлыг бэхжүүлэх, зах зээлийг чөлөөлж эхлэх эдгээр болно. Үнэ тариф тогтоох аргачлалыг мөн өөрчилж, хуучирсан, үр ашиггүй хөрөнгөнд хөрөнгө оруулалт татах хэрэгтэй байна.

Монгол Улс сэргээгдэх эрчим хүчний үлэмж их нөөцийг (тодруулбал, салхи) ашиглах хөшүүргийг бий болгох зорилгоор сэргээгдэх эрчим хүчний үнэ тарифын шинэ тогтолцоог нэвтрүүлсэн хэдий ч зохицуулалтын орчин нь сул бөгөөд энэ чиглэлээр олигтой ажил хийгдэхгүй байна.

Тогтвортой эрчим хүч

Зах зээлийн бүтэц/үр дүн: Том

Байгууллага/бодлого: Том

Эрчим хүчний үнэ тариф өртгийг тусгаж чадахгүй байгаагаас гадна байгаль орчны зардлыг багтаадаггүй. Иймд үнийн дохио нь эрчим хүчийг үр ашигтай ашиглаж, сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийн төсөлд хөрөнгө оруулалт хийх хөшүүрэг болж чадахгүй байна. Хууль эрх зүйн орчин байхгүй, институцуудын хөгжил сул буюу огт байхгүй байна. Нүүрсийн хэрэглээ өндөр байгаагийн зэрэгцээ үр ашиг муутай төхөөрөмж ашиглаж байгаагаас эрчим хүч, нүүрсхүчлийн хийн идэвхжил өндөр байна. Эрчим хүчний үр ашгийн тухай хууль, бодлого, төрийн байгууллага байхгүй байна. Сэргээгдэх эрчим хүчний төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх тусгайлсан бодлого, хөшүүрэг байхгүй байна. НҮБ-ын Цаг уурын өөрчлөлтийн тухай конвенци, протоколыг соёрхон баталсан хэдий ч цаг уурын бодлого боловсруулаагүй байна.

Тээвэр

Зах зээлийн бүтэц: Том

Байгууллага/бодлого: Дунд

Төмөр замын өмчлөгч, үйлчилгээ үзүүлэгч нь ОХУ-ын төмөр зам, Монгол Улсын Тээврийн яамны 50/50 хувийн оролцоотойгоор 1949 онд байгуулагдсан хамтарсан нийгэмлэг болох Улаанбаатар төмөр зам юм. Төмөр замын үйл ажиллагаа ашигтай хэдий ч тус салбарын санхүүжилтэнд хангалттай бус бөгөөд хүчин чадал хязгаарлагдмал байна. Хувийн хэвшлийн оролцоо байхгүй, гэхдээ төр, хувийн хэвшлийн түншлэлийн зарим төслүүдийг хянан хэлэлцэж байгаа. 1997 онд анхны бизнес төлөвлөгөө гарч, зардлын бүртгэлийн тогтолцоог боловсронгуй болгосон. Төмөр замын арилжааны хүчин чадлыг цаашид нэмэгдүүлэх шаардлагатай.

Автозамын сүлжээ 11,000 орчим км-ыг багтаасан бөгөөд үүний 13 хувь нь л хатуу хучилттай юм. Зам, тээвэр, аялал жуулчлалын яам автозамын бодлого боловсруулах үндсэн үүрэгтэй бөгөөд Автозамын газар (Зам, тээврийн газрын бүтцэд байдаг нэг хэлтэс) зам барих, засвар арчлалтыг хариуцдаг. Монгол Улсад хатуу хучилтгүй автозамын хувь хэмжээ өндөр хэдий ч ДНБ-ий 1 хувьтай тэнцэх хэмжээний санхүүжилтийг улсын төсвөөс зам засвар, арчлалтанд хуваарилдаг. Автозамын газар зам барих, засвар арчлалтын ажлын үр ашиг, ил тод байдлыг нэмэгдүүлэх шаардлагатай.

Санхүүгийн байгууллагууд

Банк

Зах зээлийн бүтэц: Дунд

Байгууллага/бодлого: Дунд

Банкны зээл сүүлийн үед огцом нэмэгдсэн хэдий ч 2008 оноос зээлийн тэлэлт эрс саарсан. Санхүүжилтийн хүртээмж үлэмж сайжирч, хот суурин газарт зах зээлийн

өрсөлдөөн маш ширүүн байна. Нийслэл хот, түүний ойролцоох газруудад зах зээлийн ханалт бий болж, хэт их өрөнд баригдсан байдал нь санаа зовоосон бодит асуудал болоод байна. Хөдөө орон нутгийн зарим хэсэгт хэрэглээний санхүүжилт нилээд олон асуудал дагуулж ижил нөхцөл байдлыг үүсгээд байна. Чанаргүй зээлийн багц сүүлийн үед өссөн. Шилжилтийн үед шийдвэрлэгдээгүй үлдсэн сорилтууд гэвэл банкуудын өөрийн хөрөнгийн баазыг нэмэгдүүлэх, зах зээл дээр байгаа зээлийн бүтээгдэхүүний хугацааг уртасгах, төгрөгийн зээлийн хэрэгцээг бүрэн хангах, лизингийн үйл ажиллагааг нэвтрүүлэх, эрүүл мэнд, мал аж хуй, газар тариалан, бусад төрлийн даатгалын бүтээгдэхүүнийг зах зээл дээр гаргах эдгээр болно. 2006 онд хараат бус бие даасан зохицуулагчтай болж, зээлийн мэдээллийн сан байгуулагдсанаар санхүүгийн салбарын институцийн хүрээ сүүлийн жилүүдэд боловсронгуй болсон. Хадгаламжийн даатгалын тогтолцоо бүрдээгүй хэвээр байна.

Даатгал, санхүүгийн үйлчилгээ

Зах зээлийн бүтэц: Том

Байгууллага/бодлого: Дунд

Банк бус санхүүгийн байгууллагуудын зохицуулалт, хяналт шалгалтын асуудлыг 2000 оны эхээр батлагдсан хэд хэдэн хуулинд тусгасан байдаг. Төрийн өмчит байсан даатгалын компанийг 2004 онд хувьчилж, хэд хэдэн компаниуд зах зээлд шинээр орж ирсэн хэдий ч хуучин улсын монополь байсан компани зах зээл дээр харьцуулашгүй өндөр байр суурь эзэлсээр байна. Амьдралын даатгалын зах зээл гэж бараг байхгүй, эрүүл мэнд, мал аж ахуй, газар тариалан, бусад төрлийн даатгалын хэрэгцээ хангагдахгүй үлдэж байна. Төрийн мэдэлд байдаг тэтгэврийн тогтолцоо (эв санааны) үндсэндээ шинэчлэгдээгүй байгаа бөгөөд хувийн тэтгэврийн сан өнөөг хүртэл байгуулагдаагүй байна. Лизингийн салбарын хөгжил доогуур хэвээр байна.

Бичил, жижиг, дунд аж ахуйн нэгж

Зах зээлийн бүтэц: Том

Байгууллага/бодлого: Дунд

Санхүүгийн салбарын шинэчлэлийн чиглэлээр төр засаг тодорхой ахиц гаргасан хэдий ч санхүүжилтийн өртөг, хүртээмж зарим аж ахуйн нэгжийн хувьд саад бэрхшээл дагуулсаар байна. Зээлийн мэдээллийн сан байгуулагдаж байна. БЖДБ-ийн зээлийг цөөн тооны банкууд гол төлөв барьцааны үндсэн дээр олгож байгаа хэдий ч сүүлийн жилүүдэд банкны зээл олголт огцом нэмэгдэж, саяхнаас зогсоход хүрсэн. Санхүүжилтийн хүртээмж үлэмж сайжирч, хот суурин газарт зах зээлийн өрсөлдөөн их ширүүн байна. Нийслэл хот, түүний ойролцоох газруудад зах зээлийн ханалт бий болж, хэт их өрөнд баригдсан байдал нь бодит асуудал болоод байна. Хөдөө орон нутгийн зарим хэсэгт хэрэглээний санхүүжилт нилээд олон асуудал дагуулж ижил нөхцөл байдлыг үүсгээд байна. Чанаргүй зээлийн багц сүүлийн үед өссөн. Мөн түүнчлэн, банкууд зээлийг гадаад валютаар олгож, аж ахуйн нэгжүүдийн орлого төгрөгөөр орж ирдэгээс валютын позицийн зөрүү нэмэгджээ. Нийт улсын хэмжээнд урт хугацаанд санхүүжилт хүндрэлтэй хэвээр байна.

Хувийн эзэмшил, хөрөнгийн зах зээл

Зах зээлийн бүтэц: Том

Байгууллага/бодлого: Дунд

Үнэт цаасны хууль тогтоомж зарим нэгэн сул доголдолтой талтай байсан. Тухайлбал, мөнгө угаахтай холбоотой болон хэрэгжилтийн үр өгөөжийн талаарх зохицуулалт тусгагдаагүй байна. Дотоодын хөрөнгийн бирж бүрэн дүүрэн ажиллаж чадахгүй байгаа (арилжааны цаг богино, арилжааны хэмжээ бага байсаар байна), үнэт цаасыг биржид бүртгүүлэхэд тавих шаардлага доогуур, тэдгээрийн хэрэгжилт муу байна (тухайлбал, бүртгэлтэй компаниудын ихэнх нь жилийн тайлан хэвлүүлдэг, гэхдээ хувьцаа эзэмшигчдийн хурлыг жил бүр зохион байгуулдаггүй). Ямартаа ч гэсэн хувьцааны зах зээлийн хөрөнгөжилт 2006 онд 112 сая ам. доллар байсан бол 2008 онд 723 сая ам. долларт (ДНБ-ий 16 орчим хувь) хүрч үлэмж өссөн. Хэдэн жилийн турш компаниуд огт хувьцаа гаргахгүй байсан бөгөөд 2007-2008 онуудад долоон компанийн хувьцааг нийтэд шууд худалдсан. Хувийн эзэмшлийг арилжааны зориулалтаар арилжих салбар дөнгөж хөгжиж байгаа бөгөөд өнөөг хүртэл хувийн хэвшлийн арилжааны олон улсын цөөн тооны сангууд хөрөнгө оруулах сонирхлоо илэрхийлж, үйл ажиллагаагаа Монголд эхлүүлсэн ч үйл ажиллагаа нь хязгаарлагдмал хэвээр байна. Бизнес эрхлэх орчин бэрхшээл ихтэй, хөрөнгө оруулах боломж хязгаарлагдмал, зах зээлээс гарах төлөв сайнгүй байгаа зэрэг бүхэлдээ энэ салбарын эсрэг ажиллаж байна.